

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2024 оны 1 дүгээр сар

Тайлангийн агуулга

1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц

1.2. Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хөгжүүлэлт, хүртээмжийг сайжруулах

- *Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний соёлыг сайжруулах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх хүрээнд*
- *Нийгмийн даатгалын байгууллагад Чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэн, хэрэгжүүлэх ажлын талаар*
- *Ажил олгогч, даатгуулагчдын санал, хүсэлтийг сонсох, хүсэлт хүлээн авах чиглэлээр*
- *Нийгмийн даатгалын мэдээллийн цөм систем нэвтрүүлэх ажлын хүрээнд*
- *Шалгах хуудас боловсруулсан талаар*
- *Тэтгэврийн программд мэдээлэл оруулах ажлын талаар*
- *Тэтгэврийн өөрчлөн тогтоолтын шалгах хуудас*
- *Процессын дахин инженерчлэлийн ажлын талаар*
- *Сургалт сурталчилгааны чиглэлээр*

2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, СУДАЛГАА

2.1. Хууль тогтоомжийн төслийн санал боловсруулах, шинээр батлагдсан хуулийн хэрэгжилтийг зохион байгуулсан үйл ажиллагааны чиглэлээр

- *Нийгмийн даатгалын шинэчилсэн хуультай холбоотой зохион байгуулсан ажлын талаар*
- *Нийгмийн даатгалын холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулсан ажлын талаар*
- *Хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах чиглэлээр төрийн байгууллагатай хамтран ажилласан талаар*

2.2. Нийгмийн даатгалын хамралтын талаар

2.3. Нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийн талаар

2.4. Судалгаа, шинжилгээний ажлын талаар

2.5. Нийгмийн даатгалын сангийн төсвийн төлөвлөлтийн талаар

3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНХҮҮ БҮРТГЭЛ

3.1. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх ажлын талаар

- *Даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хуульд заасан хугацаанд олгох, урсгал үйл ажиллагааны зардлыг ангиллын дагуу зарцуулах ажлын талаар*
- *Нийгмийн даатгалын байгууллагуудад сангийн болон үйл ажиллагааны урсгал санхүүжилтийг шилжүүлэх ажлын талаар*
- *Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн дагуу шимтгэлийн орлогыг цуглуулах, төвлөрүүлэх ажлын талаар*
- *Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогод эзлэх авлагын хэмжээг 60,0 хувиас хэтрүүлэхгүй байх ажлын талаар*

3.2. Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах ажлын талаар

3.3. Нийгмийн даатгалын ерөнхий газрын эзэмшилд байгаа үл хөдлөх хөрөнгийн нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулсан ажлын талаар

4. ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАЛ

4.1. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр

4.2. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагааны чанарыг сайжруулах чиглэлээр

- *Хяналт шалгалтын талаар*
- *Сургалт, судалгааны талаар*
- *Тайлагнах, мэдээлэх үйл ажиллагаа*

5. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- *Нэгдсэн мэдээллийн сангаас 200 гаруй удаагийн мэдээллийн боловсруулалт, судалгаа тооцооллын талаар*
- *Төрийн мэдээлэл солилцоо ХҮР системээр мэдээлэл солилцох ажлыг өргөжүүлэх 7 сервис шинээр боловсруулан нэвтрүүлсэн ажлын талаар*

- *Иргэд даатгуулагч, ажил олгогч, харилцагч байгууллагуудад тогтмол 24/7 цагийн горимоор мэдээллийг цахимаар хүргүүлэх ажлын талаар*
- *Даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2022 оны жилийн эцсийн үлдэгдлийн тооцооллын талаар*
- *Мэдээллийн шинэчилсэн системийг үе шаттайгаар нэвтрүүлэх бэлтгэл ажлын талаар*
- *Салбарын байгууллагуудын сүлжээ, компьютер, техник хангамжийн хэвийн ажиллагааны талаар*

6. БАЙГУУЛЛАГЫН СУРГАЛТ, ОЛОН НИЙТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

6.1. Сургалтын арга зүйг сайжруулах чиглэлээр

- *Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, ажилтнуудыг сургаж хөгжүүлэх чиглэлээр*
- *Ажил олгогч, даатгуулагчдын нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн ойлголтыг дээшлүүлэх чиглэлээр*

6.2. Олон нийттэй харилцах ажлын хүрээнд

- *Нийгмийн даатгалын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах талаар*
- *Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай харилцах талаар*

7. БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨВИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТАСАГ

7.1. БНСУ-д оршин сууж буй Монгол Улсын иргэдэд нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулах, сургалт, сурталчилгаа

- *Иргэд, даатгуулагчдад хууль тогтоомжийн тухай сургалт, сурталчилгаа хийх, явуулын үйлчилгээ зохион байгуулсан талаар*
- *Иргэд, даатгуулагчид, ажил олгогчдод нийгмийн даатгалын талаар ажлын байр дээр очиж мэдээлэл, заавар, зөвлөгөө өгсөн талаар*

7.2. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийг нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулах, Нийгмийн хамгааллын тухай МУ-ын ЗГ, БНСУ-ын ЗГ хоорондын хэлэлцээрийн дагуу тэтгэврийн даатгалд даатгуулсан иргэдэд гэрчилгээ олгох

- *Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийн нийгмийн даатгалд бүртгүүлсэн байдал, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх*
- *Хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирж буй иргэдийг нийгмийн даатгалд хамруулах*

7.3. БНСУ-д оршин сууж буй Монгол Улсын иргэдийг сайн дурын даатгалд хамруулах

- *Хөдөлмөрийн гэрээнээс бусад хэлбэрээр БНСУ-д оршин сууж буй иргэдийг сайн дурын даатгалд хамруулсан талаар*
- *Сайн дурын даатгалд хамрагдсан иргэдэд гэрчилгээ бичиж олгосон талаар*

7.4. Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлого төвлөрүүлэх ажлын хүрээнд

- *Тасгийн нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн орлогын талаар*
- *Төвлөрүүлсэн орлогыг нийгмийн даатгалын санд шилжүүлсэн байдал*
- *Даатгалын шимтгэлийг хугацаанд нь төлөөгүй даатгуулагчидтай холбогдох, авлагыг барагдуулах талаар*

7.5. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр (Е-9, Н-2 визээр) ажиллах хугацаандаа тус улсын Үндэсний тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн иргэдийн шимтгэлийг буцаан олгуулах ажил

- *Монгол Улсын НДЕГ, БНСУ-ын ҮТА хоорондын Харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилт*
- *Шимтгэл төлсөн иргэдэд шимтгэлийг буцаан олгосон байдал, тоон мэдээлэл*

7.6. БНСУ-ын адил төст үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудтай хамтран ажиллах

8. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

8.1. Хяналт шалгалт хийж хэрэгжүүлсэн онцлох ажлын талаар

9. САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, ДОТООД АУДИТ

9.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээ

- *Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ*

9.2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээ

- *Төсвийн ерөнхийлөн захирагч-Төсвийн шууд захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт*
- *Төсвийн шууд захирагч-Менежер нартай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт*
- *Төсвийн төвлөрүүлэн захирагч-Төсвийн шууд захирагч нартай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт*

- 9.3. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ
- *Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт*
 - *Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт*
 - *Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт*
 - *Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт*
 - *Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт*
- 9.4. Салбарын үйл ажиллагааг үр дүнтэй байлгах чиглэлээр бусад байгууллагуудтай хамтран ажиллах
- *Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд мэдээллийн шинэчилсэн системийг турших, нэвтрүүлэх ажил*
 - *Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийн хэрэгжилт*
 - *Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021, 2022 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө, хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтэд аудит хийх*
 - *Татварын албанд бүртгэлтэй боловч нийгмийн даатгалын байгууллагад бүртгээгүй ажил олгогчдын судалгаа*
- 9.5. Төсөв, санхүүгийн үйл ажиллагаа
- *2023 онд өндөр насны тэтгэвэрт гарах албан хаагчдын ажилласан жил, 36 сарын тэтгэмжид мониторинг хийх*
 - *Үндэсний аудитын газраас салбар байгууллагуудын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн акт, албан шаардлага, зөвлөмжид мониторинг хийх*
 - *Нийгмийн даатгалын сангуудын орлогын төвлөрүүлэлтэд мониторинг хийх*
 - *Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтэд мониторинг хийх*
- 9.6. Төлөвлөгөөт бус ажлын талаар
- *ХУД-ийн НДХ-ийн 2022, 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн талаар*
 - *Архангай аймгийн НДХ-т Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн шалгалтын талаар*
 - *ҮОМШӨ-өөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх журмын хэрэгжилтэд шинжилгээ хийсэн талаар*
 - *Захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ хийсэн талаар*
 - *Салбарын өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдалд мониторинг хийсэн талаар*
 - *Нийгмийн даатгалын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтооход мониторинг хийсэн талаар*
 - *Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх сэргээх, эрх баталгаажуулах шалгалтад орох байцаагч, ажилтнуудын нэрсэд мониторинг хийсэн талаар*
 - *Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, авлагын мэдээнд мониторинг хийсэн талаар*
 - *Нийгмийн даатгалын хамралтын мэдээнд мониторинг хийсэн талаар*
- 9.7. Тооцоолол, судалгаа, зөвлөмжийн биелэлт нэгтгэх

---oOo---

1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Засгийн газрын 2017 оны “Агентлаг байгуулах тухай” 344 дүгээр тогтоол, 2018 оны Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 04 дүгээр тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны “Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц, орон тоог батлах тухай” А/25 дугаар тушаал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны “Бүтэц, орон тоо батлах тухай” А/22 дугаар тушаалын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын чиг үүргийг 6 газар, 5 хэлтэс, дэргэдээ 2 төвтэй байхаар шинэчлэн баталсны дагуу 2023 онд Нийгмийн даатгалын ерөнхий газар нь

1. Тамгын газар,
Хуулийн хэлтэс,
Үйл ажиллагааны хөгжлийн хэлтэс,
Аж ахуйн алба,
2. Дотоод аудит, мониторингийн газар,
3. Бодлогын хэрэгжилт, судалгааны газар,
Судалгааны хэлтэс,
4. Санхүү бүртгэлийн газар,
Хуримтлалын сан, өрийн удирдлагын хэлтэс,
5. Хяналт шалгалтын газар,
6. Сургалт, олон нийт, хамтын ажиллагааны газар болон

Олон нийттэй харилцах хэлтэс гэсэн нэгжүүдэд нийт 84 ажилтан, албан хаагчтай,

- дэргэдэх
1. Мэдээллийн технологийн төв 12,
 2. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс 3,
 3. БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын төвийн Нийгмийн даатгалын алба 8,
 4. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл 10 албан хаагчидтай ажиллав.

Монгол улсын 21 аймаг, 9 дүүрэг нийт Нийгмийн даатгалын салбарын 31 хэлтсүүдэд 1242 ажилтан, албан хаагч, Нийгмийн даатгалын салбарын төв болон орон нутгийн байгууллагад нийт 1359 албан хаагчид ажиллаж байна.

Нийгмийн даатгалын салбарын төв байгууллага болох Нийгмийн даатгалын ерөнхий газар нь дараах үндсэн чиг үүргийн хүрээнд 10 зорилт, 59 арга хэмжээ бүхий үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулж, эхний хагас жилд **90 хувь** буюу **“Тодорхой үр дүнд хүрсэн”**, сүүлийн хагас жилээр **92 хувь** буюу **“Тодорхой үр дүнд хүрсэн”** гэсэн Төсвийн ерөнхийлөн захирагчаас үнэлэгдсэн байна.

Нийгмийн даатгалын салбарын ажилтнуудын бүтэц

			<i>Хүснэгт-1</i>
№	Албан тушаалын ангилал	Тоо	Хувь
1	Удирдах албан тушаалтан	41	3.0
2	Гүйцэтгэх албан тушаалтан	1096	76.7
3	Үйлчилгээний	222	20.3
Нийт		1359	100

Нийгмийн даатгалын салбарын албан хаагчдын албан тушаалын ангилал, тоо

			<i>Хүснэгт-2</i>
№	Төрийн албан тушаалын ангилал	Тоо	
1	Жинхэнэ албан хаагч	1137	
2	Төрийн үйлчилгээний албан хаагч	222	
4	Үүнээс: Улсын байцаагч	872	

Нийгмийн даатгалын салбарын албан хаагчдын боловсрол, мэргэжил

		<i>Хүснэгт-3</i>
№	Боловсрол	

1	Доктор	2	Санхүүч, Эдийн засагч, Нягтлан бодогч	1062
2	Магистр	162	Эрх зүйч	44
3	Бакалавр	1132	Бусад мэргэжил	253
4	Бусад	63	-	-

Нийгмийн даатгалын салбарын албан хаагчдын нас, хүйсийн мэдээлэл

Хүснэгт-4

№	Нас	Тоо	Хүйс	Тоо
1	30 хүртэлх	273	Эрэгтэй	410
2	31-40	447	Эмэгтэй	949
3	41-50	411	-	-
4	51-60	228	-	-

Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагчдын “Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх дунд хугацааны 2023 оны төлөвлөгөөг 5 зорилт, хэрэгжүүлэх 10 арга хэмжээтэй батлан биелэлтийг ханган ажиллалаа. Тайлант онд давхардсан тоогоор нийт 357 албан хаагчид 48,200 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг олгосон байна.

➤ Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

➤ Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил, арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах;

➤ Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

➤ Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах;

➤ Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах;

➤ Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага, салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах;

➤ Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эмнэлэг хөдөлмөрийн магадлалын чиглэлээр мэргэжил, арга зүйн үйлчилгээ үзүүлэх;


➤ Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх;

➤ Нийгмийн даатгалын байцаагч нарыг чадавхжуулах, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургалтыг системтэй мэргэжлийн түвшинд байнга тасралтгүй явуулах, нөгөө талаар ажил олгогч, даатгуулагчдад нийгмийн даатгалын талаарх хууль эрх зүйн мэдлэг олгох хичээл сургалтыг нэгдсэн хөтөлбөрийн дагуу зохион байгуулах;

➤ Бүгд Найрамдах Солонгос улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа Монгол Улсын иргэдийг нийгмийн даатгалын талаарх мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах, тэтгэврийн даатгалд хамруулах, төлсөн шимтгэлийг бүртгэх, тэтгэврийн даатгалын сан бүрдүүлэх, төвлөрүүлэх, шимтгэлийн буцаан олголтыг холбогдох журмын дагуу зохион байгуулах;

1.1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц

Хүснэгт-5



1.2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХӨГЖҮҮЛЭЛТ, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ

[Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний соёлыг сайжруулах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх хүрээнд](#)

Нийгмийн даатгалын байгууллагаас 2023 оныг “Нийгмийн даатгалын шинэчлэлийн жил” болгон зарласантай холбогдуулан Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн А/01 дүгээр тушаалыг батлуулж, нэрэмжит жилийн хүрээнд нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хийгдэх нийгмийн даатгалын багц хуулийн хэлэлцүүлэг, уулзалт, сургалтууд, байгууллагын санхүү, хүний нөөц, бүтээгдэхүүн үйлчилгээний цахим системийг турших, нэвтрүүлэх, хамралтыг нэмэгдүүлэх, өр авлагыг барагдуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг ажил олгогч, даатгуулагчдад сурталчилах, байцаагч ажилтнуудыг чадавхжуулах ажлуудыг тусгасан 20 заалт бүхий төлөвлөгөөг батлуулж, төв, орон нутгийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэв.

Нийгмийн даатгалын байцаагч ажилтнуудын нийгмийн даатгалын болон холбогдох хууль тогтоомжийн талаарх мэдлэгийн түвшин, мэргэшүүлэх сургалтын хэрэгцээг тодорхойлох, хөгжүүлэх зорилгоор нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтын дүнд шинжилгээ хийж танилцуулга бэлтгэлээ. Уг ажлын хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 15-20-ны өдрүүдэд зохион байгуулсан нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, баталгаажуулах, сэргээх шалгалтад хамрагдсан 406 байцаагч ажилтны ерөнхий мэдлэгийн болон онол арга зүйн шалгалтын цахим системийн үнэлгээ, 340 байцаагч ажилтны албан хэрэг хөтлөлтийн сорилын гүйцэтгэл (монгол бичгийн болон баримт бичиг төлөвлөлт)-ийн үнэлгээг цаасан суурьтай баримтад тулгуурлан судалгаа хийж дүгнэлт гаргалаа. Мөн шалгалтад хангалтгүй дүн үзүүлсэн 66 байцаагч ажилтны ажлын туршлага, үр дүн, өмнөх шалгалтын үнэлгээ зэрэгт харьцуулсан шинжилгээ хийлээ.

Цаашид нийгмийн даатгалын байцаагч ажилтнуудыг үе шаттайгаар тасралтгүй сургаж хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө гарган ажиллах, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний “Мэдлэг боловсролоо дээшлүүлэх зорилт, арга хэмжээ”-ний үнэлгээг кредитээр дүгнэдэг байх зэрэг санал гарган удирдлагад танилцууллаа.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/151 дүгээр тушаалаар баталсан улсын байцаагчийн эрх олгох, эрх сэргээх шалгалтын бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллан, дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

-Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалт зохион байгуулах тухай албан бичгийг боловсруулан (2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 1/2109 тоотой) Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.

-Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Улсын байцаагчийн шалгалт зохион байгуулах тухай” А/156 дугаар тушаалаар шалгалтын товыг тогтоон “Шалгалтад орох ажилтнуудын дүнгийн хуудасны загвар”-ыг батлуулав.

-“Нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудын судалбал зохих хууль тогтоомжийн жагсаалт”-ыг шинэчлэн гаргаж төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллага болон холбогдох албан хаагчдад хүргүүлэв.

-“Шалгалтын сорилын сан (2023)”-г шинэчлэх ажлын хүрээнд Нийгмийн даатгалын тухай хуулийн 170, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 50, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 60, нийт 280 тестэд боловсруулалт хийв. Мөн гадны 14 хуулийн 435 тестийг хянан баталгаажуулж ажлын хэсэгт хүлээлгэн өглөө.

-Албан хэрэг хөтлөлтийн шалгалтыг дүгнэх хуудсыг улсын байцаагчийн акт боловсруулах шаардлага, бичвэрийн бүтцийг дүгнэх 13 үзүүлэлт, захирамжлалын баримт

бичиг боловсруулах чадварыг дүгнэх 13 үзүүлэлт, албан бичиг боловсруулах чадварыг дүгнэх 12 үзүүлэлтээр тус тус гаргасан ба акт бичих өгөгдлийг 30 хувилбараар, албан бичиг боловсруулах 50 өгөгдлийг боловсруулав.

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд ND_lav-ийн программ ашиглаж буй албан хаагчдын судалгааг гаргаж, саналын хамт Мэдээллийн технологийн төвд хүргүүллээ. ND_lav-ийн программыг 30 нэгжийн 343 албан хаагч, QR код бүхий лавлагааны программыг 20 архивын ажилтан, 16 тэтгэвэр, тэтгэмж, орлого шимтгэлийн байцаагч давхар ашиглаж байна.

Судалгаагаар QR код бүхий лавлагааны программыг хэлтсийн архивын ажилтан хэрэглэж байгаа бөгөөд уг ажилтан эзгүй байх, ачаалал ихтэй үед зарим хэлтсүүдэд тасгийн дарга, тэтгэврийн болон тэтгэмжийн байцаагч нар архивын ажилтны (QR код бүхий) эрхээр орж мэдээллийг харах тохиолдол байгаа тул QR код бүхий лавлагааны программын эрхийг зарим байцаагч ажилтнуудад нэмж олгох шаардлага байна.

Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний соёл, орчны нөхцөл, байцаагч, ажилтнуудын харилцаа хандлага болон үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн байдалд тандалт судалгаа хийх, санал боловсруулах зорилгоор нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс болон Баянхошуу, Хайлааст тасагт 2023 оны 9 дүгээр сарын 11-14-ний өдрүүдэд ажиллав.

НДЕГ-ын даргын баталсан удирдамжид заасны дагуу ажлын байрны эмх цэгц, ажилтнуудын хувцаслалт, нэг цэгийн үйлчилгээний ачаалал, “Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний гарын авлага”-ын ашиглалтын байдалд тандалт хийж, нийт 28 иргэд, даатгуулагчаас нийгмийн даатгалын үйлчилгээ, байцаагч ажилтнуудын харилцаа хандлага, зөвлөгөө мэдээлэл өгч буй байдлыг үнэлэх зорилгоор сэтгэл ханамжийн судалгаа авч нэгтгэлээ. Тандалт, судалгааны ажлын дүнг нэгтгэн, танилцуулга, санал дүгнэлтийн хамт удирдлагад танилцуулав.

Судалгаагаар нийгмийн даатгалын байгууллагаас иргэд, даатгуулагчдын авч байгаа үйлчилгээний 60.7% тэтгэвэртэй холбоотой, 17.9% нь нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй, 10.7% нь тэтгэмжтэй холбоотой, 7.1% нь ажил олгогч шинээр бүртгүүлэх, 3.6% нь сайн дурын даатгалтай холбоотой байна. Нийгмийн даатгалын холбогдолтой мэдээ, мэдээллийг ямар сувгаар авч байгааг судлахад 35.7% нь нийгмийн даатгалын хэлтэст биечлэн ирж, 28.6% нь фэйсбүүк хуудсаар, 25.0% нь телевизээс мэдээ, мэдээллээ авдаг гэсэн бол “Нийгмийн даатгал” гар утасны аппликейшныг нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 67.9% нь огт ашигладаггүй, 24.1% нь ашигладаг, 7.1% нь ухаалаг утас ашигладаггүй, 3.6% нь татаж авч чадахгүй байгаа гэж тус тус хариулсан байна. Огт ашигладаггүй гэж хариулсан иргэдээс тодруулахад хэрэглэхэд төвөгтэй, алдаа их заадаг гэж хариулсан байна.

[Нийгмийн даатгалын байгууллагад Чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэн, хэрэгжүүлэх ажлын талаар](#)

Нийгмийн даатгалын байгууллагаас иргэд, даатгуулагч, ажил олгогчдод үзүүлж буй үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран АХБ-ны “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 2022 онд 21 аймаг, 8 дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд “Дотоод хяналт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны систем”-ийг нэвтрүүлэн, киоск төхөөрөмжийг байршуулсан ашиглаж эхэлсэн.

Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүд киоск төхөөрөмж ашиглаж эхэлснээс хойш энэ оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн 661 байцаагч ажилтны 264 487 иргэнд үзүүлсэн 304 540 үйлчилгээ (давхардсан тоогоор) бүртгэгдсэн байна. Үүнээс 22 883 иргэн өөрийн авсан үйлчилгээндээ үнэлгээ өгсөн бөгөөд үнэлгээний дундаж нь 4.7 оноотой гарсан байна.

Харин Говь-Алтай-17, Говьсүмбэр-43, Өмнөговь-91, Сэлэнгэ-94, Хөвсгөл-6 аймаг, Сүхбаатар дүүрэг-2 үйлчилгээ бүртгэсэн нь эдгээрийн хэлтсүүдийн төхөөрөмжийн ашиглалт хангалтгүй байна.

Иймээс хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны киоск төхөөрөмжийн ашиглалтыг нэмэгдүүлэх, ажилтан, албан хаагчдыг нэгдсэн ойлголттой болгох зорилгоор аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарт (2023.05.03 01/913 тоот) цахим сургалтын систем болон киоск төхөөрөмжийн талаар зөвлөмж хүргүүллээ. Уг зөвлөмжид “Очир Ай Гүүл” ХХК-тай хамтран ажилтан, албан хаагчдад цахимаар сургалт зохион байгуулах, төхөөрөмжийг тогтмол бүрэн ашиглах, үнэлгээ, сэтгэл ханамжийн судалгааны дүнд хяналт тавих, иргэдээс өгсөн үнэлгээ 4 ба түүнээс доош оноотой байгаа тохиолдолд шалтгааныг нь тодруулан шаардлагатай бол иргэнтэй холбогдож асуудлыг нь шуурхай шийдвэрлэх, төхөөрөмжийг иргэд, даатгуулагчдад сурталчилан таниулах зэргийг хэрэгжүүлэн ажиллахыг мэдэгдэв.

2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн албан хаагчдад Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001 стандартын талаар танилцуулга сургалт болон магадлан аудитад хэрхэн бэлтгэх талаар сургалтыг тус хэлтсийн 26 албан хаагч хамруулан зохион байгуулав.

Мөн Тамгын газрын даргын 2023 оны 11 сарын 8-ны өдөр баталсан “Сонгинохайрхан дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаанд Чанарын дотоод аудит хийх” удирдамжийн хүрээнд 11 дүгээр сарын 9-ний өдөр Сонгинохайрхан дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст ажиллав.

Аудитыг чанарын менежментын тогтолцоо ISO9001:2015 стандартын 4-10 дугаар бүлгийн шаардлагын хүрээнд 20 шаардлагаар хийсэн бөгөөд аудитаар 6 сайжруулах санал гарсан. Үүнд:

- ЧМТ-ны зураглалыг албан хаагчдад танилцуулж ойлгуулах
- Хэлтсийн үйл ажиллагааны хүрээнд тодорхойлсон эрсдэл боломжийн хүрээнд төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх
- Нийт албан хаагчдаар төрийн жинхэнэ албан хаагчийн шинэ анкетын бөглүүлэх /гадаад хэлний мэдлэг, мэдээлэл технологийн хэрэглээ, манлайлах ур чадварын түвшин гэх мэт /
- Хэлтсийн хэмжээнд чанарын зорилтыг хэрэгжүүлэх
- Хэлтсээс үзүүлж байгаа үйлчилгээг төрлөөр нь ангилж жагсаалт гаргах
- Хэлтсийн албан хаагчдыг Чанарын дотоод аудиторын сургалтад хамруулах зэрэг болно.

Дээрх сайжруулах саналыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллахыг зөвлөлөө.

“Үндэсний давхар даатгал” ХХК-ны хүсэлтийн дагуу 2023 оны 03 дугаар сарын 24-нд тус байгууллагын 29 ажилтанд Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 стандарт нэвтрүүлэх, хэрэгжүүлэх талаар болон Нийгмийн даатгалын ерөнхий газарт стандарт хэрхэн нэвтрүүлсэн тухай мэдээлэл өгөв.

[Ажил олгогч, даатгуулагчдын санал, хүсэлтийг сонсох, хүсэлт хүлээн авах чиглэлээр](#)

Иргэд, даатгуулагчийн санал хүсэлтийг цахим хэлбэр хүлээн авах, эргэх холбоог бий болгох чиглэлээр доорх ажлыг зохион байгуулж, хэрэгжүүллээ. Үүнд:

“Нийгмийн даатгалын мэдээлэл зөвлөгөө” facebook хуудсыг нийт 31 895 хүн дагаж байгаа бөгөөд энэ оны байдлаар хандалтын байдлыг тоон үзүүлэлтээр авч үзвэл:

(2023.1.1-2023.11.30-ны байдлаар)
Хүснэгт-6

№	Үзүүлэлт	Хүний тоо
1	Facebook хуудаст нэгдсэн	1825
2	Зөвлөгөө, мэдээлэлтэй танилцсан	258366

3	Давтан үзсэн	8534
4	Like буюу мэдээлэл таалагдсан	1092
5	Comment буюу сэтгэгдэл үлдээсэн	156
6	Share буюу бусдад түгээсэн	589
7	Chat буюу зурвас хэлбэрээр харилцсан	1853

Facebook хуудсыг дагаж байгаа иргэдийн дийлэнх нь 25-34 насныхан байгаа бөгөөд мэдээлэл авсан нийт иргэдийн 80.5% нь эмэгтэй, 19.5 хувь нь эрэгтэй хүмүүс байна.

Дээрх үзүүлэлтээс харахад facebook хуудас дагагчдын дийлэнх хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа нь нийгмийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны тэтгэмж болон сайн дурын даатгалын талаар илүү их мэдээлэл авахаар хандаж байгаагаас харагдаж байна.

Фэйсбүүк хуудас дагагчдыг оршин суугаа байршлаар нь авч үзвэл Улаанбаатар хотод 26655, хөдөө орон нутагт 4265, хилийн чанадад 1390 иргэн байна.

Түүнчлэн Нийгмийн даатгалын мэдээлэл зөвлөгөө facebook хуудасны автомат хариулагч (чатбот)-д 1193 иргэн хандаж нийгмийн даатгалтай холбоотой мэдээлэл авсан байна.

Нийгмийн даатгалын мэдээлэл зөвлөгөө facebook хуудасны мессенжерээр 1056 иргэн мэдээлэл, зөвлөгөө авсныг агуулгаар нь ангилбал:

		Хүснэгт-7
№	Агуулга	Тоо
1	Жирэмсэн, амаржсаны тэтгэмж олголтын хугацааны талаар болон цахимаар тэтгэмжийн хүсэлт илгээхтэй холбоотой	363
2	Тэтгэвэр тогтоолт, олголттой холбоотой	112
3	“Нийгмийн даатгал” аппликейшн баталгаажуулахтай холбоотой	275
4	Сайн дурын даатгал, нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой	204
5	Ажилгүйдлийн тэтгэмж олголт, эрх үүсэхтэй холбоотой	102
Нийт		1056

Нийгмийн даатгалын байгууллагаас нэвтрүүлсэн ухаалаг төхөөрөмжид зориулсан “Нийгмийн даатгал” гар утасны аппликейшний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор иргэд даатгуулагчдын санал хүсэлтэд тулгуурлан аппликейшнд нэвтрэх эрхийг 9590-1289 дугаарын утсаар баталгаажуулан ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд нийт 2647 иргэнд баталгаажилтын нууц дугаар олгож, 2122 иргэнд Нийгмийн даатгалын үйлчилгээний талаар мэдээлэл зөвлөгөө өгч ажиллав.

Нийгмийн даатгалын үйлчилгээний лавлах утас (7777-1289)-аар нийт 57137 иргэн үйлчилгээний ажилтантай холбогдож өөрт хамааралтай шаардлагатай мэдээ, мэдээллийг авсан бол автомат хариулагчаас 45755 иргэн мэдээлэл, зөвлөгөө сонссон бөгөөд иргэдийн сонссон мэдээллийг агуулгаар нь ангилж үзвэл:

- Тэтгэвэртэй холбоотой 5,298
- Тэтгэмжтэй холбоотой 22,252
- Сайн дурын даатгалтай холбоотой 6,442
- НДШ төлөлттэй холбоотой 3,881
- ЭХМТК-той холбоотой 731 иргэн мэдээлэл сонссон байна.
- Ажлын бус өдөр холбогдохыг хүссэн 7,151

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газарт цахимаар нийтдээ 8030, үүнээс www.ndaatgal.mn вэбсайтын “Санал хүсэлт” буланд 35 санал хүсэлт, асуулт, “Нийгмийн даатгал” аппликейшнээр 7378 санал хүсэлт, Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд 617 асуулт ирсэнийг ажлын 5 хоногт багтаан хариуг иргэд, даатгуулагчид утсаар болон цахим хаягаар нь хүргүүлж ажиллалаа.

www.ndaatgal.mn, аппликейшн болон иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд ирсэн асуулт, санал хүсэлт, гомдлын эзлэх хувийг агуулгаар нь ангилж үзвэл:

№	Агуулга	ndaatgal.mn болон аппликейшнээр (%)	Засгийн газрын 11-11 төвөөр (%)
1	Тэтгэвэртэй холбоотой	9,2	23,3
2	Тэтгэмжтэй холбоотой	21,9	28,8
3	Сайн дурын даатгалтай холбоотой	30,2	6,6
4	НДШ болон ЭМДШ төлөлттэй холбоотой	7,0	18,3
5	Нөхөн даатгалтай холбоотой	1,4	0,6
6	Аппликейшнтэй холбоотой	19,4	0,6
7	НДШ-ийн 50%-ийн буцаан олголттой холбоотой	3,6	3,1
8	Хүүхдээ асарч байгаа эхийн СДД-тай холбоотой	2,9	1,0
9	НДХэлтсүүд утсаа авахгүй байгаатай холбоотой	0,6	8,9
10	Талархал	0,8	1,0
11	Нэрийн данстай холбоотой	0,5	-
12	ЭХМК-той холбоотой	-	0,8
13	НДБ үйл ажиллагаа, байцаагчтай холбоотой	-	3,5
14	Бусад асуудлаар	2,5	3,5
Нийт		100%	100%

Үүнээс үзэхэд нийт санал хүсэлтийн дийлэнх хувийг тэтгэвэр, тэтгэмж, сайн дурын даатгалын шимтгэл төлөлт, гар утасны аппликейшн, нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой асуултууд эзэлж байна.

[Нийгмийн даатгалын мэдээллийн цөм систем нэвтрүүлэх ажлын хүрээнд](#)

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 14-ний А/185 тоот тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх” төслийн хүрээнд хийгдсэн программ хангамжийн үйл ажиллагааг турших, нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Дэд ажлын хэсэг байгуулагдсан. Уг ажлын хүрээнд нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга, байцаагч нартай гурвалсан хариуцлагын гэрээ байгуулан 6 байцаагчийг үндсэн ажлаас нь чөлөөлөн ажиллуулж SICOS программаар тэтгэвэр тогтоох үйл ажиллагааг тэтгэврийн хувийн хэрэг, үндсэн баримтад тулгуурлан 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн туршин ажиллаж байна.

Шинэ систем нэвтрүүлэх ажлын хүрээнд Ажлын хэсэг 7 хоног бүрийн Мягмар, Пүрэв гарагт ITZone компанийн мэргэжилтнүүдтэй, Даваа, Лхагва гарагт бүтээгдэхүүн хөгжүүлэлттэй холбоотой асуудлаар болон шалгах хуудас боловсруулах ажлаар дотооддоо батлагдсан хуваарийн дагуу тогтмол ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт 31 удаагийн уулзалт хурал, Дэд ажлын хэсэг 5 удаагийн хурлыг хийв.

[Шалгах хуудас боловсруулсан талаар](#)

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/174 дүгээр тушаалаар батлагдсан ажлын хэсгийн гишүүд холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран тэтгэвэр, тэтгэмж тогтоохтой холбоотой шинэ систем дээр гарч болзошгүй алдааг илрүүлэх, залруулах, заавар зөвлөгөө өгөх зорилгоор шалгах хуудас боловсруулан ажиллалаа.

Шалгах хуудсыг одоогийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа Нийгмийн даатгалын багц хуулиуд болон холбогдох бусад хууль, дүрэм, журам, зааврын хүрээнд боловсруулсан бөгөөд Бодлогын хэрэгжилт судалгааны газар, Дотоод аудит, мониторингийн газар, Хяналт шалгалтын газрын мэргэжилтнүүдтэй хамтран шинээр тэтгэвэр тогтоохтой холбоотой нийт 27 төрлийн 2081, тэтгэвэр өөрчлөн тогтоохтой холбоотой 5 төрлийн 216, тэтгэвэр олголтын 55, тэтгэмж тогтоохтой холбоотой 5 төрлийн 310, тэтгэмж олгохтой холбоотой 3 төрлийн 71 асуулт бүхий шалгах хуудсыг боловсруулан туршилтын багт хүргүүлэв.

Тэтгэврийн программд мэдээлэл оруулах ажлын талаар

Тэтгэвэр, тэтгэмж тогтоох, өөрчлөн бодох, тэтгэвэр, тэтгэмж олголттой холбоотой үйл ажиллагааг шинэ системд оруулан турших багийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавин, чиглүүлж ажиллалаа.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль болон Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст 2022 оны 11, 12 сард шинээр тогтоосон 447 тэтгэврийн хувийн хэрэг, материалыг татан авч шинэ систем (SICOS)-д мэдээллийг оруулан өмнөх системээр тогтоосон тэтгэврийн тогтоолтын хуудастай тулган шалгав.

Байцаагч нар тэтгэврийн программд тэтгэвэр тогтоохдоо тухайн тэтгэвэртэй холбоотой шалгах хуудасны асуултын дагуу программд гарч байгаа асуудлуудыг давхар шалгаж ажилласан бөгөөд шалгах хуудсанд байгаа огт гараагүй болон цөөхөн тоотой тохиолдлыг турших зорилгоор нэмэлтээр Баянзүрх, Баянгол дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс 2021 оноос хойш шинээр тогтоосон өндөр насны тэтгэврийн 120 хувийн хэргийг татан авч мэдээлэлд оруулав.

Мөн тахир дутуугийн тэтгэвэр тогтоолтыг турших явцад Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын программд 104 иргэний холбогдох мэдээлэл, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг оруулан тэтгэврийн программ руу татан шалгав.

Тэтгэвэр өөрчлөн тогтоохтой холбоотойгоор Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс 101, Сонгинохайрхан дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс 124 хувийн хэргийг татан авч мэдээллийн баазад оруулсан.

Туршилтын ажлыг нийгмийн даатгалын 6 байцаагч ITZone компанийн тэтгэврийн программ хариуцсан ажилтнуудтай хамтран хийсэн бөгөөд тэтгэврийн хувийн хэрэг, материалыг шинэ системд оруулан шалгах хуудсаар хянах явцад нийтдээ 43 асуудал гарсныг ITZone компанитай хамтран шийдвэрлэж ажилласан.

Тэтгэмжийн программд мэдээлэл оруулах ажлын талаар

Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс 2022 оны 11, 12 сард олгосон ажилгүйдлийн тэтгэмжийн 484, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн 2532, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн 852, оршуулгын тэтгэмжийн 15, ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгосон хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн 34, нийт 3917 тэтгэмжийн материалыг шинэ систем (SICOS)-д мэдээллийг оруулан ажиллав.

Байцаагч нар ажилгүйдлийн тэтгэмжийн программд тэтгэмж тогтоохдоо тухайн тэтгэмжтэй холбоотой шалгах хуудасны асуултын дагуу программд гарч байгаа асуудлуудыг давхар шалгаж ажилласан бөгөөд тус тэтгэмжтэй холбоотой асуудлын талаар Дэд ажлын хэсгийг хурлаар хэлэлцүүлээ.

Тэтгэврийн өөрчлөн тогтоолтын шалгах хуудас

Цэргийн өндөр насны тэтгэврийн өөрчлөлттэй холбоотой болон энгийн өндөр насны тэтгэврийн өөрчлөлттэй холбоотой нийт 312 асуулт бүхий 5 төрлийн шалгах хуудсыг Бодлогын хэрэгжилт судалгааны газраас ирүүлснийг туршилтын багт хүргүүлэн шалгах ажлыг эхлүүлээ.

Дээрх шалгах хуудсын хүрээнд SICOS програмд амжилтгүй гарсан тохиолдлуудын жагсаалтыг гарган Мэдээллийн технологийн төв болон ITZone ажлын хэсэгт хүргүүлэв.

Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системийн хөгжүүлэлттэй холбоотойгоор “Зар мэдээ”-ний шалгах хуудсыг “файл бэлтгэх хэсэг”, “файл байршуулах хэсэг”, “хайлт хийх хэсэг”-тэйгээр, “Хэрэглэгчийн бүртгэл”-ийн шалгах хуудсыг “бүртгэлийн хэсэг”, “үйлчилгээний хэсэг”, “үнэлгээний хэсэг”-тэйгээр тус тус боловсруулав. Ажлын хэсгийн 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралд “Зар мэдээ”-ний шалгах хуудасны төслийг танилцуулан, саналыг тусган ажиллав.

Процессын дахин инженерчлэлийн ажлын талаар

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 64 тоот тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газар болон харъяа нэгжүүдэд процессын

дахин инженерчлэл хийх ажлыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Үүний дагуу НДЕГ-ын даргын 2023 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн А/95 тоот тушаалаар байгуулагдсан процессын дахин инженерчлэл хийх ажилд дэмжлэг үзүүлж ажиллав.

Энэ ажлын хүрээнд Сэлэнгэ, Архангай, Хэнтий аймгийн төвд бүсчлэн 13 аймгийн 78 албан хаагчдыг, Нийслэлийн 9 дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн 42 албан хаагчдыг төрийн албаны бүтээмж, чадамжийг дээшлүүлэх, төрийн үйлчилгээг үзүүлж буй албан хаагч, үйлчилгээ авч буй иргэдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх сургалтад хамрууллаа.

Процессын дахин инженерчлэлийн багын ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор шаардлагатай судалгаа, мэдээ мэдээллээр хангаж, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн 815 албан хаагчдыг цахимаар судалгаанд хамруулах ажлыг зохион байгуулав.

Сургалт, сурталчилгааны чиглэлээр

Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн талаар төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагын байцаагч, албан хаагчдад нэгдсэн ойлголт өгч, сургах, чадавхижуулах, ажил олгогч даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаар мэдээлэл, танилцуулга хийх НДЕГ-ын даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгчийн 2023 оны А/115 дугаар тушаалын дагуу “Сургагч багш бэлтгэх” сургалтыг 2023 оны 9 дүгээр сарын 13-наас 10 дугаар сарын 27-ны өдрүүдэд зохион байгуулав.

Сургагч багшийн эрх авсан ХНХЯ, НДЕГ-ын 36 сургагч багш батлагдсан удирдамж, хуваарийн дагуу, Дэлхийн банкны Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн санхүүжилтээр нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд явуулж, нийт 1195 албан хаагч, 4740 Ажил олгогч байгууллагын 6726 даатгуулагчийг хамруулав.

2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, СУДАЛГАА

2.1. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН САНАЛ БОЛОВСРУУЛАХ, ШИНЭЭР БАТЛАГДСАН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/197 дугаар тушаалаар баталсан Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах Ажлын хэсэгт ажиллаж Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлснээр Улсын Их хуралд өргөн барив. Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Нийгмийн бодлогын байнгын хорооны зөвлөхүүдтэй хамтран хэлэлцэх саналын томьёолол бэлтгэх ажлыг зохион байгуулав.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэлэлцэн баталж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөхөөр шийдвэрлэв.

Нийгмийн даатгалын багц хууль шинэчлэн баталсантай холбогдуулан тус газраас дараах баримт бичгийг боловсруулж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас санал авахаар ирүүлсэн УИХ-ын тогтоолоор батлах 1, Засгийн газрын тогтоолоор батлах 15, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Сангийн сайд, Эрүүл мэндийн сайд, Гадаад хэргийн сайд, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын хамтарсан тушаалаар батлах 18, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор батлах 13 дүрэм, журмаас 33 дүрэм, журмын төсөлтэй танилцан, 23 дүрэм, журамд холбогдох саналыг тусган боловсруулж, төслийг албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. Бусад 10 дүрэм, журмын төсөлд оруулах саналыг боловсруулан ажиллаж байна. Санал өгсөн дүрэм журмаас Засгийн газрын тогтоолоор 2, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Эрүүл мэндийн сайд, Гадаад хэргийн сайд, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын хамтарсан тушаалаар 7, нийтдээ 9 дүрэм, журам батлагдсан байна.

2. Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын

сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төслийг танилцуулах, шинэчлэн батлагдсан хуулиудын дагуу боловсруулах дүрэм, журам, заавар, аргачлалын төслийг Нийгмийн даатгалын хэлтсүүд, ажил олгогч, даатгуулагч, иргэдэд танилцуулах, санал авах уулзалт хэлэлцүүлгийг Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймагт зохион байгуулав.

3. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Хуваарь батлах тухай” А/113 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын батлах 11 журмыг боловсруулан батлуулах журам, зааврын хуваарийг баталж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллав.

4. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/139 дүгээр тушаалаар “Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх журам”, А/147 дугаар тушаалаар “Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан хүлээн авах, хянах, залруулга хийх, баталгаажуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан журам”-ыг баталж Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр хүргүүлээд байна. “Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын сан тус бүрийн орлогын зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, хугацаа, хяналт тавих журам”, “Үйлдвэрлэлийн ослын улмаас сул зогссон хугацааг тогтоох журам”, “Татварын албатай цахимаар мэдээлэл харилцан солилцох журам”-ын төслийг нийгмийн даатгалын байгууллагын төв, орон нутгийн газар, газарт хүргүүлэн, танилцуулж холбогдох саналыг тусган боловсруулав.

5. “Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэх маягтын загвар, тэдгээрийг хэвлүүлэх, үнэ тогтоох, зарцуулах, тайлагнах журам”, “Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчид бүртгэлийн дугаар олгох, хэрэглэх болон хувийн хэрэг нээх, бүртгэх, хөтлөх, шилжүүлэх журам”, “Илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох харилцааг зохицуулсан журам”, “Нийгмийн даатгалын шимтгэлийн ногдуулалт, төлөлтөд хяналт шалгалт хийх журам”, “Тэтгэвэр тогтоолгох өргөдлийн маягтын загвар, тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, бүртгэх журам, тэтгэвэр бодох заавар”, “Тэтгэмж тогтоолгох өргөдлийн маягтын загвар, тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг авах эрх бүхий иргэн, албан тушаалтныг тодорхойлох журам, тэтгэмж бодох аргачлал, заавар”-ын төслийг боловсруулан холбогдох олон нийтээс санал авахаар www.ndaatgal.mn цахим хуудаст байршуулав.

[Нийгмийн даатгалын шинэчилсэн хуультай холбоотой зохион байгуулсан ажлын талаар](#)

Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн болон холбогдох бусад шийдвэрүүдийн 2023 онд дагаж мөрдөх өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх 12 удаагийн зөвлөмжийг Нийслэлийн нийгмийн даатгалын газар, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллав.

Төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагуудад 2023 онд өндөр насны тэтгэвэр тогтоох нас болон шимтгэл төлсөн байвал зохих хугацаа, “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлийн ажил мэргэжлийн жагсаалт”-д орсон өөрчлөлтийг хэрэгжүүлэх, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчийн тэтгэвэр авагчид өндөр насны тэтгэвэр тогтоож, олгохтой холбоотой асуудлаар 6 удаагийн зөвлөмж, Онцгой байдлын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүх шинжилгээний ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын зөвлөмжийн хүрээнд Гамшгаас хамгаалах тухай, Цагдаагийн албаны тухай, Дотоодын цэргийн тухай, Шүүхийн шинжилгээний тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудыг хэрэгжүүлэх 4 удаагийн чиглэл, зөвлөмжийг Нийслэлийн нийгмийн даатгалын газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2023 оны “Журамд нэмэлт оруулах тухай” А/59 дүгээр тушаалаар “Тэтгэвэр тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам”-ын 2.10, мөн журмын 4.1.2-т оруулсан нэмэлтийг Хууль зүй, дотоод хэргийн яам 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Захиргааны хэм

хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэсэн шийдвэрийг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллав.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны “Оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 04 дүгээр тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан нөхцөлийг хангасан даатгуулагчийн оршуулгын тэтгэмжийн болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу нас барагч цэргийн алба хаагчийн ар гэрт олгох тэтгэмжийн хэмжээг хоёр сая төгрөгөөр шинэчлэн, оршуулгын тэтгэмж олгох нөхцөлийг хангасан, амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт олгох оршуулгын тэтгэмжийн хэмжээг гурван сая таван зуун мянган төгрөгөөр тус тус тогтоож, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж байгаатай холбогдуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллав.

Амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт оршуулгын тэтгэмж олгоход “Даатгуулагчийг донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлэхээр болсон талаарх тодорхойлолт”-ын маягтыг батлуулах хүсэлтийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албанд холбогдох хүсэлтийг явуулаад байна. 2023 онд оршуулгын тэтгэмж олгох нөхцөлийг хангасан, амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн 1 даатгуулагчийн ар гэрт гурван сая таван зуун мянган төгрөгийн тэтгэмж олгов.

Засгийн газрын 2023 оны “Итгэлцүүр шинэчлэн батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 238 дугаар, “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 239 тогтоолуудын хэрэгжилтийг зохион байгуулан нийгмийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тогтоосон цэргийн алба хаасны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны нийтдээ 488.8 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг шинэчлэн тогтоож, нэмэгдүүлэн олгов. Дээрх тогтоолуудын дагуу 326.8 мянган хүний тэтгэвэр тогтоолгосон цалинг шинэ итгэлцүүрээр өсгөж шинэчлэн тогтоож, уг тэтгэврийн хэмжээг нь 10 хувиар нэмэгдүүлэхэд 394.5 тэрбум.төг зарцуулав. Энэхүү арга хэмжээний үр дүнд дундаж тэтгэврийн хэмжээ 560.4 мянган төгрөг байсан бол шинээр баталсан итгэлцүүрээр тэтгэврийг шинэчлэн бодоход дундаж тэтгэвэр сард 622.3 мянган төгрөг, уг тэтгэврийн хэмжээг 10 хувиар дундаж тэтгэвэр сард 687.7 мянган төгрөг болж нэмэгдэв. Мөн Засгийн газраас бүрэн тэтгэврийн доод хэмжээг 550000 төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 440000 төгрөг болгон нэмэгдүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулав.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 29 дүгээр зүйлийн 29.3-т заасны дагуу тэтгэврээ 2019-2023 онд дараалсан 6 эсхүл 7 жилийн цалин хөлсний дунджаас тогтоолгосон, тэтгэврээ 5 жилийн цалин хөлснөөс өөрчлүүлэх тэтгэвэр авагчийн хүсэлтийг цахимаар авах, баталгаажуулах боломжийг бүрдүүлэв. Энэхүү ажлын хүрээнд нийт 77.8 мянган тэтгэвэр авагч 6 болон 7 жилийн дундаж цалингаар тэтгэврээ тогтоолгосон бөгөөд эдгээр тэтгэвэр авагчаас 46.3 мянган тэтгэвэр авагчийн өөрчлөгдсөн тэтгэврийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс олгов. Үлдсэн 31.5 мянган тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосон 6 эсхүл 7 жилийн цалин хөлсөө өөрчлөх хүсэлт гаргаагүй байгаа бөгөөд хүсэлт гаргасан өдрөөс нь тэтгэврийг нь 5 жилийн дундаж цалин хөлснөөс өөрчлөн тогтооно.

УБТЗ-ын Барилга орон сууцны албанд харъяалагддаг Зүүнхараа 2, 3, 4 дүгээр, Салхит, Орхонтуул, Багахангай, Булагтай, Сайншанд 1 дүгээр, Айраг, Зүүнбаян, Чойр 1 дүгээр зуух, Зүүнхараа вагон засварын депо, Хөтөл бетон дэрний үйлдвэр зэрэг байнгын ажиллагаатай 13 уурын зууханд “галч” ажил мэргэжлээр ажилласан даатгуулагчийн уг хугацааг ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр бус бодит хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос жилийн турш шимтгэл төлсөн эсэх зэргийг үндэслэн хөдөлмөрийн хүнд нөхцөлд хамааруулан хуульд заасан нөхцөлийг хангасан тохиолдолд өндөр насны тэтгэвэр тогтоох зөвлөмжийг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

[Нийгмийн даатгалын холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулсан ажлын талаар](#)

Засгийн газрын 2023 оны 60 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацааны нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам”, 2023 оны “Итгэлцүүр шинэчлэн батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 238 дугаар тогтоол, “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 239 дүгээр тогтоол, 2023 оны 362 дугаар тогтоолоор

баталсан "Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн дүрэм", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны "Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай" А/01 дүгээр тушаал, 2023 оны А/137 дугаар тушаалаар шинэчлэн баталсан "Нийгмийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, зэргийн нэмэгдэл олгох журам", Гадаад хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны "Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны адилтгах албан тушаалын жагсаалт, нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах жишиг цалин хөлсний хэмжээг батлах тухай" А/69, А/132 дугаар хамтарсан тушаал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/59 дүгээр тушаалаар өөрчлөлт оруулсан "Тэтгэвэр тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам"-ыг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд холбогдох зөвлөмжийн хамт хүргүүлэн, хэрэгжилтийг зохион байгуулав.

Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг 2023 онд хэрэгжүүлэх чиглэлээр болон шинээр баталсан даатгуулагчийн төрлийн 70 (хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон ажилтан), 71 (цэргийн байгууллагын захиалгаар суралцагч цэргийн цолтой алба хаагч), 72 (хилс хэргээр мөрдөгдсөн, хилс хэргээр хорих ял эдэлсэн хүн), 73 (цаг уурын хүнд нөхцөл бүхий улс дахь Дипломат төлөөлөгчийн газарт ажилласан жилийг өсгөн тооцуулсан ажилтан), өөрчлөгдсөн 06 (хүүхэд асрах чөлөөтэй байгаа аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан эх), 32 (хууль бусаар ажлаас халагдсан хүн) кодыг шимтгэл төлөлтийн програмд нэмж оруулах, олон хүүхдийн нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох даатгуулагч эхийн бусдад үрчлүүлсэн, Монгол Улсын харъяатаас гарсан хүүхдийн болон нас барсан тэтгэвэр авагчийн регистрийн мэдээлэл, тэтгэврийн нэмэгдэл, тэтгэвэр бодсон цалинг итгэлцүүрээр өсгөхтэй холбоотой 8 удаагийн програмын даалгаврыг Мэдээллийн технологийн төвд хүргүүлэн, тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлж ажиллав.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээг хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлага, эрсдэл бүхий ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлөөс хамааралтайгаар ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос ялгавартай тогтоох бөгөөд шимтгэл төлөх ажил мэргэжлийн жагсаалт, шимтгэлийн хувь хэмжээ, хэрэглэх журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална" гэж заасны дагуу Монгол улсын Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (ҮАМАТ-08)-ыг Засгийн газрын 2008 оны 142 дугаар тогтоолоор батлагдсан "Жагсаалт батлах тухай (үйлдвэрлэлийн ослын даатгалын шимтгэлийн)" жагсаалт болон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны "Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай" 77 дугаар тушаалтай уялдуулан 4228 ажил мэргэжлийг үйлдвэрлэлийн ослын хувь хэмжээ болох 0.5, 1.5, 2.5 хувь хэмжээгээр нэг бүрчлэн кодлон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан 31 ажлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороо, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд нийт 591.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгов.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны баталсан "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөө"-нд 1.548.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 64 арга хэмжээ тусгагдсанаас тайлант онд 56 арга хэмжээг зохион байгуулж, 1.376.6 сая төгрөгийн санхүүжилт олгох хүсэлт холбогдох байгууллагуудаас ирүүлснийг "Хамтран ажиллах гэрээ", "Ажил гүйцэтгэх гэрээ" байгуулж, санхүүжилтийг олгож, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллав.

1.588.3 мянган даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2022 оны орлогод Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан хүүг баримтлан хүү тооцож, эцсийн үлдэгдэл 27.4 их наяд төгрөгийг бүртгэв. Даатгуулагч тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны мэдээлэх хуудсаа "Нийгмийн даатгал" аппликейшн, www.ndaatgal.mn цахим хуудсан дахь "Даатгуулагчид зориулсан вэб", төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох

“ХУР” систем, төрийн үйлчилгээний нэгдсэн портал “E-Mongolia” системээс цахимаар авах боломжийг бүрдүүлэв.

Нэрийн дансны 2023 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг 2019-2022 оны нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчдын дундаж цалинд үндэслэн тооцож, Үндэсний статистикийн хорооны санал авч Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны “Нэрийн дансны 2023 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох” тухай 15 дугаар тогтоолоор даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2023 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 14.3 хувиар батлуулж хэрэгжилтийг зохион байгуулав.

[Хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах чиглэлээр төрийн байгууллагатай хамтран ажилласан талаар](#)

Нийгмийн даатгалын хууль тогтоомж болон холбогдох бусад хуулийн дагуу даатгуулагчдад тэтгэвэр тогтоож, олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдон гарч байгаа зөрчлийг арилгах, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газар, Архивын ерөнхий газрын хооронд 2023 оны ХАГ/2023-07, НД/74/23 дугаартай “Хамтран ажиллах гэрээ”-г шинэчлэн байгуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллав.

Монгол Улсын Хилийн тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хил хамгаалах байгууллагын алба хаагч, улсын хил дээр алба хааж байгаа офицер, ахлагч нарын ажил эрхлээгүй гэр бүл, Хилийн цэргийн сургуульд сонсогчоор суралцсан болон хугацаат цэргийн алба хаасан иргэдийн хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж авах эрхийг баталгаажуулах, нийгмийн баталгааг хангах зорилгоор 2023 оны 03/НД-22/23 дугаартай Хил хамгаалах ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын хамтран ажиллах санамж бичгийг байгуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллав. Энэхүү санамж бичгийн хүрээнд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 1995-1996 онд хугацаат цэргийн албыг байлдагч, түрүүчийн хаасан алба хаагчдын хугацаандаа төлөгдөөгүй нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх чиглэлээр ЗХЖШ-тай хамтран 12 нийгмийн даатгалын хэлтэс, 34 зэвсэгт хүчний анги, нэгтгэлийг хамруулсан ажлын хэсгийг байгуулах, ажлын төлөвлөгөө боловсруулах, мэргэжил арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулав.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулан цэргийн алба хаагчид тэтгэвэр тогтоож олгохтой холбоотой Нийгмийн даатгалын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хооронд “Хамтран ажиллах гэрээ”-ний төслийг шинэчлэн боловсруулж батлуулан, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллав. Энэхүү ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар хооронд болон Нийгмийн даатгалын ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар хооронд байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний төслийг шинэчлэн боловсруулж санал авахаар дээрх 2 байгууллагад хүргүүлэв.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3, 19.4 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны “Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2023 оны хэмжээг тогтоох тухай 500 дугаар тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар хооронд 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 65/НД-39/23 дугаартай “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулан хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2023 онд иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулахтай холбоотой хамтарсан чиглэлийг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллав.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-тай дагалдан батлагдсан 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахаар Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар хооронд байгуулах хамтран ажиллах гэрээг шинэчлэх ажлын хэсгийг байгуулан ажиллахаар бэлтгэл ажлыг хангав.

Засгийн газрын 2022 оны 296 дугаар тогтоолоор баталсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын хэрэгжилтийг хангуулах, бичил уурхай эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах ажлын хүрээнд Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоотой 2023 оны НД73/23 дугаартай хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулж хамтран ажиллав.

Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох хуулийн үйлчлэлд хамрагдсан даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлсөн хугацааг албан журмын болон сайн дурын даатгалын хугацаатай давхцуулан төлүүлснийг малын “А” данстай өөр хугацаанд шилжүүлэн тооцох ажлыг зохион байгуулж нийт 1 дүүрэг, 7 аймгийн 287 иргэний малын “А” дансны мэдээлэлтэй тулган шалгаж “Нөхөн даатгал 2020” програмд залруулан тэдгээр иргэдэд малчны нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох боломжоор хангав.

Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн хүрээнд 1990-2000 онуудад ажилласан жилээ нөхөн тооцуулсан даатгуулагчдаас регистр, овог нэр, өөрчлүүлэхээр хүсэлт гаргасан 6 дүүрэг, 13 аймгийн 105 даатгуулагчийн мэдээллийг Refund.exe програмд залруулж, өндөр насны тэтгэвэр тогтоолгох нөхцөлийг бүрдүүлэв.

2.2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХАМРАЛТЫН ТАЛААР

Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор 23.1 мянган даатгуулагчийг шинээр сайн дурын даатгалд хамруулах төлөвлөгөөг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгав. 2023 оны жилийн эцсийн байдлаар 28.1 мянган иргэнийг сайн дурын даатгалд шинээр хамруулсан дүнтэй байна. Мөн 9.0 мянган малчинтай сайн дурын даатгалын гэрээг цахимаар байгуулах ажлыг зохион байгуулав.

Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор 4.9 мянган ажил олгогч, 26.9 мянган даатгуулагчийг шинээр хамруулах төлөвлөгөөг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгав. Энэхүү ажлын үр дүнд 2023 оны жилийн эцсийн байдлаар 5.4 мянган аж ахуйн нэгж, байгууллага, 22.7 мянган даатгуулагчийг албан журмын даатгалд шинээр хамруулав.

Хөдөлмөрийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасан туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан, тэдгээртэй адилтгах ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ бүхий 192 иргэнийг сайн дурын даатгалд хамруулав.

2.3. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ОЛОН УЛСЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улсын Засгийн газар хооронд байгуулсан “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр” албан ёсоор хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан иргэд даатгуулагчдад мэдээлэл өгөх танилцуулгыг www.ndaatgal.mn веб болон нийгмийн даатгалын байгууллагын фэйсбүүк хуудсанд байршуулав.

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд ашиглах маягтуудад оруулах санал боловсруулж, 2 талын цахим уулзалтаар хэлэлцэн тохиролцов.

Бүгд Найрамдах Чех Улсын Нийгмийн хамгааллын байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын тэтгэврийн тогтолцооны талаар мэдээллийг англи хэл дээр бэлтгэж цахимаар хүргүүлэв. Хэлэлцээрийн хүрээнд Бүгд Найрамдах Чех Улсын нийгмийн даатгалын газарт MN/CZ 205 маягтаар 15 иргэн, MN/CZ 001 маягтаар 19 иргэн, MN/CZ 202 маягтаар 7 иргэний хүсэлтийг уламжлав.

Монгол Улс, Унгар Улс хоорондын нийгмийн хамгааллын хэлэлцээрийн хэрэгжилтийг ханган тус улсаас тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 13 иргэний MN/HU 001 маягт, 7 иргэний Монгол Улсад шимтгэл төлж ажилласан жилийг баталгаажуулах MN/HU205 маягт, 8 иргэний сануулах маягтыг тус тус гарган Бүгд Найрамдах Унгар Улсын талд хүргүүлэв.

Монгол Улс, Бүгд Найрамдах Польш Улс, хоорондын нийгмийн хамгааллын хэлэлцээрийн хүрээнд тус улсаас тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 2 иргэний хүсэлтийн маягт, 2 иргэний сануулах маягтыг тус тус Бүгд Найрамдах Польш Улсын талд хүргүүлэв.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хооронд “Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах хэлэлцээр”-ийн төсөл боловсруулах шинжээчдийн багийн 14 удаагийн уулзалтад тус газрыг төлөөлөн оролцов.

Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд нийгмийн даатгалын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг шинэчлэхтэй холбоотой зохион байгуулсан 2 талын ажлын хэсгийн цахим уулзалтад тус газрыг төлөөлөн оролцов.

2.4. СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЛААР

Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, ажил олгогч, албан журмын болон сайн дурын даатгуулагчийн тоо, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ зэрэг тоон мэдээллийг аймаг, дүүргээр 2022 оны байдлаар шинэчлэн нийгмийн даатгалын статистик үзүүлэлтийн нэгтгэлийг шинэчлэв. Үндэсний статистикийн хорооноос баталсан маягтын дагуу 2022 он, 2023 оны эхний хагас жилийн байдлаар гаргасан мэдээллээр үзүүлэлтийн нэгтгэлийг баяжуулан ажиллав. Нийгмийн даатгалын сангийн сарын мэдээний тоймыг тухай бүр бэлтгэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын www.ndaatgal.mn цахим хуудсанд байршуулав.

Эрүүл мэндийн даатгалын хамралтын мэдээллийг сар бүр, аймаг, дүүргээр гарган Санхүү бүртгэлийн газарт хүргүүлэв. Үндэсний статистикийн хорооны даргын баталсан маягтын дагуу нийгмийн даатгалын салбарын 2022 он, 2023 оны эхний хагас жилийн статистик мэдээллийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Үндэсний статистикийн хороо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтэд цахимаар болон албан бичгээр хүргүүлэв.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын www.ndaatgal.mn вэбсайтад “Нийгмийн даатгалын сангийн сарын мэдээний тойм”, нийгмийн даатгалын хамралтын 2021, 2022 оны жилийн эцсийн тоон мэдээлэл, “Нийгмийн даатгалын статистик эмхтгэл-2022”-ийг байршуулав. Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан ёсны фэйсбүүк хуудсанд байршуулах “Нийгмийн даатгалын сангийн статистик мэдээлэл”-ийг бэлтгэн Сургалт, олон нийт, хамтын ажиллагааны газарт тухай бүр хүргүүлэв.

Нийгмийн даатгалын танилцуулга номонд орох статистик мэдээллийг бэлтгэж, СОНХАГ-т хүргүүлэв. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд орон нутагт ажиллахтай холбогдуулан 21 аймгийн нийгмийн даатгалын холбогдолтой мэдээллийг бэлтгэж, удирдлагад өгөв. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон бусад газруудад нийт 29 удаа мэдээ, мэдээлэл хүргүүлэв.

Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны “Нийгмийн халамж, даатгалын салбарын статистикийн мэдээллийн маягт, түүнийг нөхөх зааврыг батлах тухай” А/137 дугаар тушаалаар баталсан нийгмийн даатгалын салбарын статистик мэдээллийн маягт, түүнийг нөхөх зааврыг шинэчлэн батлуулах ажлын хүрээнд Үндэсний статистикийн хорооны саналыг тусган статистик мэдээллийн маягтыг боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.

Нийгмийн даатгалын албан журмын даатгалд 2023 оны 01-03 сарын хугацаанд хамрагдсан ажил олгогчдоос хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс нийгмийн даатгалын шимтгэл төлдөг 24 367, нийгмийн даатгалын албан журмын даатгалд хамрагдсан 1-5 даатгуулагчтай 34 550 ажил олгогчийн судалгааг Мэдээллийг технологийн төвөөр гаргуулан авч, холбогдох танилцуулга бэлтгэв.

Засгийн газраас зохион байгуулж буй “Шил ажиллагаа”-ны хүрээнд нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нээлттэй мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор Засгийн газрын тусгай сангийн мэдээллийг www.shilen.gov.mn вэбсайтад байршуулах ажлын хүрээнд нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэл болон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авсан хүний тоо, нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө, Засгийн газрын бонд худалдан авсан талаарх мэдээллийг 2008-2022 оны байдлаар бэлтгэн Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлж, уг мэдээллийг инфографик хэлбэрээр байршуулахад саналаа өгөв.

2.5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТАЛААР

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Заавар батлах тухай” А/78 дугаар тушаалаар нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөөлөл болон үйл ажиллагааны урсгал зардал, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын төсвийн төсөл, төсөөлөл боловсруулахад баримтлах зааврыг шинэчлэн баталж, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагуудад хүргүүлэв.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/04 дүгээр тушаалаар нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн 2023 оны сар, улирлын хуваарийг батлуулан, хэрэгжүүлэх зөвлөмжийн хамт аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн

даатгалын хэлтсийн газруудад хүргүүлэв. Мөн нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын 2023 оны төсвийн хуваарьт өөрчлөлт орсонтой холбоотойгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/49 дүгээр тушаалаар батлуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар нийгмийн даатгалын сангийн орлогыг 4.175.2 тэрбум, үүнээс төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаасыг 774.4 тэрбум, сангийн зарлагыг 4.152.7 тэрбум төгрөгөөр тус тус өөрчлөн баталсан. Уг хуулийн дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 05 тоот тогтоолоор Нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны урсгал зардлын тодотгосон төсвийн аймаг, нийслэл, дүүргийн нарийвчилсан хуваарийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/105 дугаар тушаалаар сар, улирлын хуваарийг батлуулан, хэрэгжүүлэх зөвлөмжийн хамт аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагуудад хүргүүлэв.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/135 дугаар тушаалаар 2023 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан батлуулж, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

Нийгмийн даатгалын сангийн 2024-2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл болон жилийн хязгаарын саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2024 оны төсвийн төслийн санал, 2025-2026 оны төсвийн төсөөллийг хэлэлцүүлэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд төсвийн төсөл, төсөөллийн саналыг хүргүүлэв. Уг төсвийн төсөлд нийгмийн даатгалын багц хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан 2024 оноос хэрэгжих сангийн орлого, зарлагын нөлөөллийн, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний нөлөөллийн, цалин, тэтгэврийг нэмэгдүүлэхэд нөлөөллийг тус тус тооцон тусгав.

Нийгмийн даатгалын сангийн төсвийн 2024 оны төсвийн сар, улирлын хуваарийг боловсруулан Төсвийн тухай хуульд заасан хугацаанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.14.2-т заасны дагуу аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс /газар/-үүдийн нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны урсгал зардлын 2024 оны төсвийн нарийвчилсан хуваарийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Нийгмийн даатгалын сангийн 2024 оны тусвийн хуваарь батлах тухай” А/02, “Үйл ажиллагааны зардлын 2024 оны төсвийн хуваарь батлах тухай” А/03 дугаар тушаалыг тус тус батлуулан аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудад хүргүүлэв.

Тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийн нийгмийн даатгалын санд нөлөөлөх нөлөөллийн тооцоог боловсруулан нэмэгдэх хүний тоо, дундаж нэмэгдэл, нэмж шаардагдах хөрөнгийн тооцоо, итгэлцүүрийг шинэчилсний дараа тэтгэврийн хэмжээг 10.0 хувиар нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгийг тус тус тооцон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв. Тооцоогоор итгэлцүүрийг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс шинэчилснээр 200.2 тэрбум.төг, тэтгэврийн хэмжээг 10.0 хувиар нэмэгдүүлснээр 194.4 тэрбум.төг, санд нийт 394.5 тэрбум.төг нэмж шаардагдах бөгөөд уг төсвийг Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар батлуулав.

Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн батлах тухай” 488, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох тухай” 491 дүгээр тогтоолын дагуу нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдын албан тушаалын ангилал зэрэглэл, шатлал өөрчлөгдөж, төрийн алба хаасан хугацаа өөрчлөгдөж байгаатай холбогдуулан холбогдох тооцооллыг хийв.

3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНХҮҮ БҮРТГЭЛ

3.1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ


Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд 4,175.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталсан. Үүнд:

- НД-ын шимтгэлийн орлого 3,400.8 тэрбум төгрөг;
- Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 774,4 тэрбум төгрөгөөр баталсан.

Нийт зарлага 4,152.7 тэрбум төгрөг. Үүнд:

- Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардалд 4,105.6 тэрбум төгрөг;
- НД-ын байгууллагын үйл ажиллагааны зардалд 47.1 тэрбум төгрөг зарцуулахаар тус тус баталсан.


НДС-ийн төсөв /тэрбум.төг/ *График 1.*



3.2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО

НДС-д 2023 онд шимтгэлийн орлого 3,400.8 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 3,507.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 103.1 хувиар биелүүлсэн. /энэ дүнд Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 774,4 тэрбум төгрөг ороогүй/

НДС-ийн орлогын бүтэц /хувиар/ *График 2.*



НДС-ийн нийт орлогын 54.8 хувь буюу 1,923.6 тэрбум төгрөгийг ажил олгогч, 44.5 хувь буюу 1,559.7 тэрбум төгрөгийг даатгуулагчийн төлсөн шимтгэл, 0.7 хувь буюу 24.0 тэрбум төгрөгийг ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн шимтгэлийн орлого болон бусад орлого эзэлж байна.

НДС-ийн орлогын биелэлт /тэрбум.төг/ *Хүснэгт-9.*

№	Орлогын төрөл	2022	2023
1	Улсын төсвөөс олгох дэмжлэг	842.8	764.4
2	Ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагаас	1,182.0	1,923.6

3	Төсөвт газраас	289.5	-
4	Даатгуулагчаас	1,068.1	1,422.5
5	Сайн дурын даатгуулагчаас	111.7	134.3
6	Гадаадад ажиллаж буй иргэдийн	2.5	2.8
7	ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн	1.5	1.8
8	ЭМДС-аас санхүүжих	1.1	-
9	Бусад орлого	13.3	22.2
Нийт		3,512.5	4,271.6

Мөн орлогын 17.9 хувь буюу 764.4 тэрбум төгрөгийг улсын төсвийн орлого эзэлж байна.

НДС-ийн 2023 оны орлогын гүйцэтгэл Хүснэгт-10.

№	Орлого	Мөнгөн дүн /тэрбум.төгрөг/	Нийт орлогод эзлэх хувь
1	Тэтгэврийн даатгалын сан	3,620.2	84.7
2	Тэтгэмжийн даатгалын сан	306.0	7.2
3	ҮОМШӨ-ний даатгалын сан	282.7	6.6
4	Ажилгүйдлийн даатгалын сан	62.7	1.5
Нийт		4,271.6	100

3.3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

НДС-ийн зардлын төсөв 4,152.7 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд 3,993.0 тэрбум төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөрт, 43.2 тэрбум төгрөгийг НДБ-ын үйл ажиллагааны зардалд тус тус зарцуулсан.

НДС-ийн 2023 оны зарлагын гүйцэтгэл Хүснэгт-11.

№	Зардал	Мөнгөн дүн /тэрбум.төгрөг/	Нийт зардалд эзлэх хувь
1	Тэтгэврийн даатгалын сан	3,617.0	89.6
2	Тэтгэмжийн даатгалын сан	212.5	5.3
3	ҮОМШӨ-ний даатгалын сан	41.5	1.0
4	Ажилгүйдлийн даатгалын сан	110.2	2.7
5	ДТШ 50 хувийн буцаалт	11.8	0.3
6	Үйл ажиллагааны зардал	43.2	1.1
Нийт		4,036.2	100

НДС-ийн зарлага өмнөх оны мөн үеэс 620.5 тэрбум төгрөг буюу 18.2 хувиар өссөн.

НДС-ийн 2023 онд зарцуулсан мөнгөн дүн, үйлчлүүлсэн хүний тоо /мян.хүн, тэрбум.төг/


Хүснэгт-12.

№	Нийгмийн даатгалын сан	2021 он		2022 он		2023 он	
		Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
1	Тэтгэврийн	455.5	2,281.8	473.8	3,031.3	486.4	3,617.0
2	Тэтгэмжийн	364.5	169.4	260.9	165.9	214.5	212.5
3	ҮОМШӨ-ний	5.7	30.7	7.2	35.9	6.7	41.5
4	Ажилгүйдлийн	26.2	57.0	30.5	78.7	29.4	110.2
5	ДТШ 50 хувийн буцаалт	-	-	2087.7	72.7	310.9	11.8
6	Үйл ажиллагааны зардал		26.6		31.2	-	43.2
Нийт		851.9	2,565.5	2860.1	3,415.7	1047.9	4,036.2

НДС-аар үйлчлүүлсэн иргэдийн тоо өмнөх оныхоос 1812.2 мянга буюу 64.4 хувиар буурсан нь “Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай” хуулийн хэрэгжилттэй холбоотой байна. 2023 оны 1 дүгээр сард 2022 оны 12 дугаар сарын өөрөө хариуцан төлсөн шимтгэлийн буцаан олголтыг 310.9 мянган даатгуулагчдад 11.8 тэрбум төгрөгийг олгосон.

НДБ-ын үйл ажиллагааны зардал 12.0 тэрбум төгрөг буюу 38.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

3.4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХАМРАЛТ



НД-ын мэдээллийн санд 2022 оны жилийн эцсийн байдлаар 55.4 мянган ААНБ бүртгэгдсэн нь 2021 онтой харьцуулахад 2.7 мянган ажил олгогч буюу 5.1 хувиар нэмэгдсэн.

Мөн албан журмын 1,104.8 мянган даатгуулагч хамрагдсан нь нийт ажиллах хүчний 90.3 хувийг эзэлж байна. /ҮСХ-ны 2022 оны 4-р улирлын тоон мэдээгээр нийт ажиллах хүчний тоо 1,222.8 мянган хүн/

3.5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ҮЗҮҮЛЖ БУЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨР ЗАРДАЛ

Тэтгэврийн даатгалын сан


Тэтгэврийн даатгалын сангаас 2023 онд нийт 486.4 мянган тэтгэвэр авагчдад 3,342,4 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосон. Нийгмийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө буюу 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон 42.2 мянган тэтгэвэр авагч, 21.3 мянган цэргийн албан хаагчдын тэтгэвэрт 273.1 тэрбум төгрөг зарцуулсан.

Тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн /мянган хүн, тэрбум.төг/ *Хүснэгт-13.*

№	Тэтгэврийн төрөл	2021 он		2022 он		2023 он	
		Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
1	Өндөр насны	353.2	1,789.6	372.0	2,408.0	382.8	2,887.2
2	Тахир дутуугийн	63.1	247.7	62.2	316.7	62.5	341.8
3	Тэжээгчээ алдсаны	19.5	77.1	19.6	103.7	19.8	113.4
4	Цэргийн	19.7	162.7	20.0	201.8	21.3	273.1
Нийт		455.5	2,277.1*	473.8	3030.2*	486.4	3,615.5*

*Үйл ажиллагааны зардал, Бусад зардал болон ДТШ 50 хувийн буцаалтын дүн ороогүй болно.

Тэтгэврийн зарлага /тэрбум.төг/ *График 5.*




Тэтгэврийн даатгалын зардал өмнөх оноос 585.3 тэрбум төгрөг буюу 19.3 хувиар өссөн.


Тэтгэвэр авагчдын бүтэц /хувиар/ *График 6.*

Нийт өндөр насны тэтгэвэр авагчдын 8.2 хувь нь хувь тэнцүүлсэн тэтгэвэр, 91.8 хувь нь бүрэн тэтгэвэр авч байна.

2023 оны байдлаар НДС-аас олгож буй бүрэн тэтгэврийн доод хэмжээ 550.0 мянган төгрөг байгаа нь амьжиргааны доод түвшингээс 75.4 хувиар илүү байна. /ҮСХ-ны мэдээллээр 2023 оны Улаанбаатар хотын хүн амын амьжиргааны доод түвшин сарын 313.4 мянган төгрөг/



Тэтгэврийн доод болон дундаж хэмжээ /мян.төг/ *График 7.*



Улсын хэмжээгээр дундаж тэтгэврийн хэмжээ өмнөх оноос 23.7 хувиар өссөн.

Тэтгэмжийн даатгалын сан

Тэтгэмжийн даатгалын сангаас 241.7 мянган даатгуулагчдад 212.4 тэрбум төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж олгожээ.


Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн /мян.хүн, тэрбум.төг/ *Хүснэгт-14.*

№	Тэтгэмжийн төрөл	2021 он		2022 он		2023 он	
		Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
1	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	179.7	30.4	162.3	27.4	139.7	32.6

2	Жирэмсний болон амаржсаны	64.9	119.3	58.5	121.1	60.7	147.7
3	Оршуулгын	16.2	16.2	14.2	14.2	14.0	28.3
4	Эхийн хүүхдээ асрах чөлөөтэй байсан хугацааны шимтгэл	103.7	3.2	25.9	3.2	27.3	3.8
Нийт		364.5	169.1*	260.9	165.9*	241.7	212.4*

*Үйл ажиллагааны зардал, Бусад зардал болон ДТШ 50 хувийн буцаалтын дүн ороогүй болно.

Тэтгэмжийн зарлага /тэрбум.төг/ *График 8.*



Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үетэй харьцуулахад 46.5 тэрбум төгрөг буюу 28.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ҮОМШӨ-ний даатгалын сан

2023 оны жилийн эцсийн байдлаар 6.7 мянган даатгуулагчдад тахир дутуугийн, тэжээгчээ алдсан, ХЧТА, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувиллын зардалд ҮОМШӨ-ний даатгалын сангаас 41.5 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан.


Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн /мян.хүн, тэрбум.төг/

Хүснэгт-15.

№	Тэтгэвэр, тэтгэмжийн төрөл	2021 он		2022 он		2023 он	
		Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
1	Тахир дутуугийн тэтгэвэр	3.7	24.4	3.5	27.5	3.5	31.8
2	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	0.5	2.9	0.5	3.4	0.5	4.0
3	ХЧТА-ны тэтгэмж	0.7	0.7	1.2	1.3	1.4	1.8
4	Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр	0.01	0.08	0.01	0.01	0.01	0.01
5	Рашаан сувиллын зардал	0.8	0.2	2.0	1.1	1.3	1.0
6	Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	-	0.7	-	1.1		1.1
7	Тахир дутуугийн тэтгэвэр авагчдын тэтгэврийн даатгалын шимтгэл	-	1.6	-	1.5		1.8
Нийт		5.7	30.6*	7.2	36.0*	6.7	41.5*

*Үйл ажиллагааны зардал, Бусад зардал болон ДТШ 50 хувийн буцаалтын дүн ороогүй болно.

ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага /тэрбум.төг/ *График 9.*




ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 5.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.

Ажилгүйдлийн даатгалын сан

2023 онд ажилгүйдлийн даатгалын сангаас 29.4 мянган даатгуулагч 111.0 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж авсан байна.

Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн *График 10.*



Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогод эзлэх авлагын хэмжээг 60.0 хувиас хэтрүүлэхгүй байх ажлын талаар

Ковид-19 цар тахлын улмаас аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа доголдсонтой холбоотойгоор нийгмийн даатгалын шимтгэлийн авлага нэмэгдсэн. Энэхүү шимтгэлийн авлагыг бууруулахаар аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд үүрэг чиглэл өгч үр дүнг тооцон ажиллав.

Шимтгэлийн авлагыг бууруулах, хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2023 оны “Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө биелүүлэх, шимтгэлийн авлага барагдуулах тухай” А/16 дугаар тушаал батлагдан, хэрэгжилтийг ханган ажиллав.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай “Хамтран ажиллах гэрээ” байгуулан шүүхийн шийдвэртэй шимтгэлийн авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлэн сар бүр үр дүнг тооцон, тайлан мэдээг талууд солилцож байна.

Дээрх НДЕГ-ын А/16 дугаар тушаал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтарсан гэрээний хэрэгжилтийг хангуулахаар төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудын ажил олгогч, даатгуулагчаас авах шимтгэлийн авлагыг бууруулах талаар дараах чиглэл, заавруудыг аймаг /нийслэл/, дүүргийн Нийгмийн даатгалын /газар/ хэлтсүүдэд хүргүүлж, бусад холбогдох 8 ажлуудыг зохион байгуулан ажилласан байна Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай 2023-01 сард “Хамтран ажиллах гэрээ” байгуулан шүүхийн шийдвэртэй шимтгэлийн авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлэх ажлыг хамтран зохион байгуулж, талууд сар бүр шийдвэр гүйцэтгэлийн тайлан мэдээг солилцсон, үр дүнг тооцох;

2. Аймаг /нийслэл/, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс/газар/-т тушаал, гэрээний хэрэгжилтийг ханган хуримтлагдсан шимтгэлийн авлага үүсгэсэн аж ахуйн, нэгж байгууллагын авлагыг барагдуулах;

3. ЦЕГ-т сураггүй, хаяг тодорхойгүй байгаа байгууллагыг эрэн сурвалжлах ажиллагааг эрчимжүүлэх талаар хамтран ажиллах хүсэлт хүргүүлснээр цагдаагийн байгууллагаас харъяа байгууллагууддаа чиглэл, заавар өгч, хамтран ажиллах;

4. Зөвшөөрлийн тухай хуулийг үндэслэн аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг олгох, хугацааг сунгах зэрэг асуудлыг шийдвэрлэхдээ нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй эсэхийг харгалзан үздэг байх талаар хамтран ажиллах хүсэлтийг доорх байгууллагуудад хүргүүлэв. Үүнд:

- Гадаадын иргэн, харьяатын газар, б.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар,
- Барилга, хот байгуулалтын яам,
- Боловсрол, шинжлэх ухааны яам, Барилга хот байгуулалтын яам,
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам,
- Эрүүл мэндийн яам,
- Эрчим хүчний яам,
- Сангийн яам,
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Зам, тээврийн хөгжлийн яам,
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам зэрэг болно.

5. Тухайн салбарт ажиллаж буй даатгуулагчдын нийгмийн баталгааг хангах, ажил олгогчийг санхүүгийн эрсдэлд орохоос сэргийлэхэд дэмжлэг үзүүлж, шимтгэлийн өрийг бүрэн барагдуулах, цаашид өр үүсгэхгүй байх талаар холбогдох арга хэмжээг авч, хамтран ажиллах талаарх хүсэлтүүдийг дараах байгууллагуудад хүргүүлэв. Үүнд:

- Монголын барилгын үндэсний ассоциац;
- Ашигт малтмал, газрын тосны газар;
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам зэрэг
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар,
- Сангийн яамны Санхүү төрийн сангийн газар,
- Сангийн яамны Төсвийн бодлого зохицуулалтын газарт зэрэг болно.

6. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийг төлөөлдөг байгууллагын хувьд дараах байгууллагуудад нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй ажил олгогчдын шимтгэлийг төлүүлэх, цаашид өр нэмж үүсгэхгүй байх, ажилчдын нийгмийн баталгааг хангах талаар тодорхой ажлуудыг “Хамтран ажиллах гэрээ”-ний үндсэн дээр зохион байгуулах талаарх саналыг хүргүүлээ. Үүнд:

- Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо;
- Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо;
- Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг болно.

7. Нийгмийн даатгалын хуримтлагдсан шимтгэлийн авлагыг барагдуулах ажлын хүрээнд дараах байгууллагуудад тайлан мэдээ, холбогдох судалгааг гарган хүргүүллээ. Үүнд:

- Сангийн яамны Төрийн сангийн газарт 19.0 тэрбум төгрөгийн өр үүсгэсэн 818 төсөвт байгууллагын жагсаалт;
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт 11.9 тэрбум төгрөгийн өр үүсгэсэн 398 эрүүл мэндийн байгууллагын жагсаалт;
- Монголбанкны зээлийн мэдээллийн санд 38,008 ажил олгогчийн мэдээлэл;
- Улсын Бүртгэлийн ерөнхий газарт 495 аж ахуйн нэгж, байгууллагын судалгаа;
- Жижиг, дунд үйлдвэрийн газарт 655 аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг хүргүүлэв.

8. ЭМНДЕГ-ын даргын 2017 оны “Журам батлах тухай” А/108 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг үүссэн хугацаагаар нь ангилах, хянан шийдвэрлэх журам”-ыг хэрэгжүүлж, шимтгэлийн хуримтлагдсан авлагыг бууруулах шат дараалсан арга хэмжээг авч ажиллахыг аймаг, дүүргүүдийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд үүрэг болгон, хэрэгжилтэд хяналт тавин ажилласнаар дараах үр дүнд хүрсэн байна. Үүнд:

- 155.6 тэрбум төгрөгийн шимтгэлийн авлага үүсгэсэн 4,118 ажил олгогчид албан шаардлага хүргүүлж, 48.2 тэрбум төгрөгийн авлага төлөгдсөн;

- Харилцах дансны зарлагын гүйлгээг түр хугацаагаар зогсоосон 10,160 ажил олгогчийн 431.8 тэрбум төгрөгөөс 56.2 тэрбум төгрөгийн авлага төлөгдсөн;
- Төлбөр барагдуулах хуваарь гаргаж, гэрээ байгуулсан 3,384 ажил олгогчийн 270.2 тэрбум төгрөгийн авлагаас 35.8 тэрбум төгрөгийн авлага төлөгдсөн;
- Шүүхэд шилжүүлсэн 1,354 ажил олгогчийн 48.3 тэрбум төгрөгийн авлагаас 3.5 тэрбум төгрөгийн авлага төлөгдсөн;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлсэн 333 ажил олгогчийн 18.4 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагаас 2.6 тэрбум төгрөгийн авлага төлөгдсөн;

/Тайлбар: Авлага барагдуулах арга хэмжээ нь дээрх журмын дагуу шат дараалан авч байгаа тул авлагын мөнгөн дүн, ажил олгогчийн тоо нь давхардсан дүнгээр илэрхийлэгдсэн болно/.

Авч хэрэгжүүлсэн дээрх ажлын үр дүнд 2023 оны эхний 354.0 тэрбум төгрөгийн шимтгэлийн авлагаас 143.7 тэрбум төгрөгийн авлага барагдуулсан боловч урсгал авлага нэмэгдэж, 2023 оны 10 дугаар сарын авлага 440.7 тэрбум төгрөг байна. 2023 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 398.0 тэрбум төгрөг байна.

Ковид-19 цар тахалын улмаас аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа доголдсонтой холбоотойгоор нийгмийн даатгалын шимтгэлийн авлага оны эхнээс 19.3%-аар нэмэгдсэн байна.

3.6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭХ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ТАЙЛАГНАХ АЖЛЫН ТАЛААР

Төв орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудад 2022 оны жилийн эцэс, 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах хуваарийг хүргүүлэн хуваарийн дагуу тайлангуудыг шалган нэгтгэж, Үндэсний аудитын газар, Сангийн яам, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд хугацаанд нь хүргүүлэв.

Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулав. Үүнд:

- Төв орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудын 2022 оны жилийн эцэс, 2023 оны эхний хагас жилийн байгууллагын болон сангийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлангуудыг шалган нэгтгэж, Үндэсний аудитын газар, Сангийн яам, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албанд хугацаанд нь хүргүүлсэн.

- Байгууллагын болон сангийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг хүлээн авч шалган мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилласан.

- Үндэсний аудитын газраас Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна гэж дүгнэсэн байна.

- Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн аудит хийж байгаа аудитуудтай хамтран ажилласнаар Төрийн аудитын тухай хуулийн дагуу харьяа нийгмийн даатгалын 31 байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” дүгнэгдсэн.

- Үндэсний аудитын газар, Сангийн яамнаас НДЕГ-ын 2022 оны үйл ажиллагаанд хийсэн аудит болон Засгийн газрын тайлангийн аудитын хугацаанд шаардлагатай тайлбар, тоон мэдээ, мэдээллийг цаг тухай бүр гарган өгч хамтран ажилласан.

- Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Аудитын зөвлөмж хэрэгжүүлэх тухай” А/86 дугаар тушаал гарч, хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, 2022 оны Аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг гарган Үндэсний аудитын газар хуулийн хугацаанд хүргүүлсэн.

- Нийгмийн даатгалын сангийн 2022 он, 2023 оны хагас жилийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн танилцуулгыг бэлтгэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албанд хуулийн хугацаанд хүргүүлж, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн, нийтэд мэдээллээ.

- Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, 2022 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан, 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, 2023 оны хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан, Аудитын зөвлөмжийн биелэлтийг www.shilendans.gov.mn сайтад хуулийн хугацаанд байршуулав.

3.7. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЭЗЭМШИЛД БАЙГАА ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТАЛААР

Капитал банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн нийгмийн даатгалын сангийн өр, төлбөрт тооцон авсан хөрөнгийг худалдан борлуулах нээлттэй дуудлага худалдааг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны “Журам батлах тухай” 18 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоол, ТӨБЗГ-ын 2022 оны 7-1/2608 дугаар албан бичгээр өгсөн зөвшөөрлийг тус тус үндэслэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/29, 2023 оны А/186 дугаар тушаалаар 2 удаагийн дуудлага худалдааг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулж, 304.9 сая төгрөгийн үнэлгээтэй хөрөнгийг 313.9 сая төгрөгөөр борлуулав.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаанаар Капитал банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн төлбөрт хүлээн авсан хөрөнгүүдийн тухай асуудлыг хэлэлцүүлснээр “Хөрөнгө гэрээгээр худалдах зөвшөөрөл олгох тухай” 02 дугаар тогтоол батлагдаж, Капитал банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагчаас нийгмийн даатгалын сангийн нэхэмжилсэн өр төлбөрт тооцон авсан, гурав ба түүнээс дээш нээлттэй дуудлага худалдаагаар борлуулагдаагүй хөрөнгүүдийг иргэн, хуулийн этгээд, үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагуудтай “Худалдах, худалдан авах гэрээ” байгуулан, төлбөрийг 36 сараас ихгүй хугацаанд төлж барагдуулах шийдвэр гарсан.

Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компаниудтай хамтран ажиллах урилгын зарыг өдөр тутмын сонин болон цахим хэлбэрээр олон нийтэд хүргэснээр одоогийн байдлаар хүсэлт ирүүлсэн 8 байгууллагатай “Үл хөдлөх эд хөрөнгийг худалдахад зуучлах гэрээ” байгуулан хөрөнгийн худалдан борлуулах ажлыг зохион байгуулж байна. “Үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”-ээр 1.3 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлэв.

Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байсан 34 аж ахуй нэгж, иргэнтэй түрээсийн гэрээг байгуулан 205.1 сая төгрөгийн түрээсийн орлогыг Нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн.

4. ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАЛ

4.1. ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАЛЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тус дүрмийг хэрэгжүүлэх хүрээнд аймаг, дүүргийн Засаг дарга, Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах болон эрүүл мэндийн байгууллагын Эмнэлэг хяналтын комиссын эмч, мэргэжилтнүүдээс ирүүлсэн саналууд, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисст иргэн (даатгуулагч)-ээс хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаатай холбоотой ирүүлж буй өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал зэргээс зарим заалтыг нэмэх, хасах, өөрчлөх шаардлага гарч байгаа тул тус дүрмийн 6 заалтад өөрчлөлт оруулах, 2 заалт шинээр нэмэх саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын “Санал хүргүүлэх тухай” 2023 оны 01/261 тоот албан бичиг, Нийгмийн даатгалын багц хуулийг Улсын их хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны чуулганаар шинэчлэн баталсантай холбоотойгоор Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэмд оруулах өөрчлөлтүүдийн саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 01/1656 тоот албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлэв.

Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/758, А/197 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах ердийн өвчний жагсаалт”-ыг хэрэгжүүлэх явцад иргэд (даатгуулагч) болон аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллага, Эмнэлэг хяналтын комисс, Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүдээс хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалтад өөрчлөлт оруулах

шаардлагатай байгаа талаар санал ирүүлсээр байсан тул Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс нь тус жагсаалтад өөрчлөлт оруулах үндэслэлийг судлан, саналыг нэгтгэж 10 заалтыг шинээр нэмэх, 3 заалтыг хасах, 50 заалтад өөрчлөлт оруулахаар нийт 63 саналыг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын даргын “Санал хүргүүлэх тухай” 2023 оны 36 тоот албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлэв. 2023 оны 04 сард Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлтэй холбоотойгоор уг жагсаалтыг дахин боловсруулж, ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 01/1662 тоот 2023 оны 10 дугаар сард албан бичгээр хүргүүлэв.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/38 дугаар тушаалаар баталсан “Эмнэлгийн хуудас олгох, хянах журамд” өөрчлөлт оруулах саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 01/1837 тоот албан бичгээр журамд өөрчлөлт оруулах нийт 20 саналыг хүргүүлж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны “Журам, маягтын загвар батлах” А/177, А/433 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан болно.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дах хэсэгт заасан “Сэргээн засах төв болон сувиллын тусламж үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай” тогтоолын төсөлд тусгуулах саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 01/1839 тоот албан бичгээр ХНХЯ-д хүргүүлэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 10 дугаар тогтоолоор батлуулав.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9 дэх хэсэгт заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн “Журам батлах тухай” тогтоолын төсөл, “Даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журам”-ын төсөлд НДЕГ-ын даргын 2023 оны 01/1875 тоот албан бичгээр ХНХЯ-д журмын төсөлд тусгах 22 саналыг хүргүүлж Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 11 дүгээр тогтоолоор батлагдав.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дүгээр зүйлийн 37.12 дах хэсэгт заасан “Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн ажиллах дүрэм”-ийн төсөлд НДЕГ-ын даргын 2023 оны 01/2146 тоот албан бичгээр ХНХЯ-д санал хүргүүлэв. Тус журмын төсөлд тусгах 7 саналыг хүргүүлсэн болно.

Мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалт, хувь, хугацааны жагсаалтын саналыг боловсруулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/158, А/388 дугаар хамтарсан батлуулсан бөгөөд Захиргааны ерөнхий хуулийн дагуу захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн сангийн 6478 дугаарт бүртгүүлэв.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дах хэсэгт “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох, протез, ортопедийн жишиг үнийн жагсаалт”-ын төсөлд тусгуулах нийт 27 саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.

4.2. ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссоос аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн магадлагч эмч, анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийн дунд “Цахим эмнэлгийн хуудасны програмын хэрэгжилтийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдэвт цахим хэлэлцүүлгийг 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулав. Хэлэлцүүлэгт нийт 600 гаруй эмч, мэргэжилтнүүд оролцож, эмнэлгийн хуудсыг цахимаар бичиж, илгээхэд учирч буй

хүндрэл бэрхшээл, програмд нэмэлт хөгжүүлэлт хийх хэрэгцээ шаардлагын талаар санал солилцов. Эмнэлгүүдийн програм хангамжаас хамааран, эмнэлгүүдэд ашиглаж байгаа цахим эмнэлгийн хуудасны програм харилцан адилгүй, ЭХМТК-оос боловсруулан хүргүүлсэн програмын даалгаврын дагуу хийгдээгүй, сүлжээний саатлаас шалтгаалан ажил олгогчийн нэр, олохгүй байх, зарим үед эмнэлгийн хуудас илгээгдэхгүй байснаас шалтгаалан эмнэлгийн хуудсыг хугацаанд нь илгээж чадахгүй байх зэрэг хүндрэл бэрхшээл тулгарч байгаа талаар болон цаашид эдгээр авч хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар санал солилцов.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/38 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн хуудас олгох, хянах журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор эмнэлгийн хуудас бичих, илгээх, хяналт тавих явцыг цахим хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулан 2022 оны 1 дүгээр сараас эхлэн улсын хэмжээнд эмнэлгийн хуудсыг цахимаар бичиж, олгож байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт анхан шатны 602, 2, 3 дахь шатлалын 99, хувийн хэвшлийн 148, нийт 850 орчим эрүүл мэндийн байгууллага эмнэлгийн хуудсыг цахимаар бичиж олгож байгаа бөгөөд хөдөлмөрийн чадвар түр алдсан нийт 139296, жирэмсэн амаржсаны нийт 59949 иргэний тэтгэмжийг цахимаар хүлээн авч, хянаж баталгаажуулан бодож олгосон байна.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын нарийн бичгийн дарга болон магадлагч эмч нар Сэтгэцийн болон Мэргэжлээс шалтгаалах өвчний салбар комиссын 89 удаагийн хуралд оролцож 4481 иргэн (даатгуулагч)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоохтой холбоотой дараах асуудлыг шийдвэрлэв. Үүнд:

2023 оны жилийн эцсийн байдлаар Сэтгэцийн өвчний Эмнэлэг хөдөлмөрийн магадлах салбар комиссын 37 удаагийн хуралд төв комиссын Нарийн бичгийн дарга оролцож 1686 иргэн (даатгуулагч)-ий хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэв. Үүнээс шинээр 157 иргэнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоож, 1427 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг сунгаж, 78 иргэнийг цуцалж, бичиг баримтын бүрдэл дутуу үндэслэлээр 24 иргэнийг буцааж холбогдох бичиг баримтыг бүрдүүлсний дараа шийдвэрлэв.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/24 дугаар тушаалаар “Олон улсад хөдөлмөрийн чадвар алдалт тогтооход баримталж буй бодлого чиглэлийн өнөөгийн байдал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын удирдамж батлуулан Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын даргын 2023 оны 16 дугаар “Эрдэм шинжилгээний бага хуралд оролцуулах тухай” албан бичгээр Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, салбар сургууль, Эрүүл мэндийн яамны мэргэжлийн салбар зөвлөлүүд, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, Улсын I, II, III дугаар эмнэлэг, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст эрдэмтэн, судлаачдыг татан оролцуулах, хамтран ажиллах албан бичгийг хүргүүлэв.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хандан Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны “Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг шинэчлэн батлах тухай” дугаар А/758/А/197 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах ердийн өвчний жагсаалт”-д ажлын цаг богиносгох тодорхой заалт байхгүй тул нэмэлт өөрчлөлт оруулж өгөх талаар “Санал хүргүүлэх тухай” албан бичгийг хүргүүлэв.

Баянзүрх дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн зохион байгуулсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэнд ээлтэй дүүрэг” хэлэлцүүлэгт 2023 оны 4 дугаар сарын 20-ны өдөр Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын нарийн бичгийн дарга оролцож Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилт, өнөөгийн байдал, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн зарим асуудал, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн талаар нийт 40 орчим иргэдэд мэдээлэл өгөв.

Баян-Өлгий, Дархан-Уул, Орхон аймаг, нийслэлийн Багануур, Сүхбаатар дүүргийн ЭХМК-ын нийт 20 иргэний амбулаторийн картын бичилт, оношийн баталгаажуулалт, ЭХМК-ын хурлын шийдвэр зэрэгт 2023 оны 5 дугаар сард “Ижил мэргэжилтний үзлэг” зохион байгуулав. Хэлэлцүүлэгт ЭХМТК болон ижил мэргэжилтний үзлэгт оролцсон аймаг, дүүргийн ЭХМК, ЭХК-ын төрөлжсөн мэргэжлийн эмч нар болон НДХ-ийн магадлагч эмч, нийт 30 орчим эмч, мэргэжилтнүүд оролцов. Энэ удаагийн “Ижил мэргэжилтний үзлэг”-ээр амбулаторийн карт тус бүрт 3-4 төрөлжсөн мэргэжлийн эмч үнэлгээ хийсэн нь төрөлжсөн мэргэжлийн болон хяналтын эмчийн амбулаторийн картын бичилт, оношийн баталгаажуулалт, түүнд тавих дотоодын хяналт сайжирч, улмаар хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэхтэй холбоотой маргаантай

асуудал гарахаас урьдчилан сэргийлэх, өөрийн болон мэргэжил нэгтнийхээ үйл ажиллагааг харьцуулан алдаа дутагдлаа залруулах, сайн туршлагаас суралцах, улмаар иргэн (даатгуулагч)-д эмнэлэг хөдөлмөр магадлалын үйлчилгээг тэгш, чанартай үзүүлэх талаар ахиц гарах боломжийг бүрдүүлснээрээ чухал ач холбогдолтой болов.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо, ТББ-ын төлөөлөлтэй хамтран “Бөөрний өвчний үеийн тусламж үйлчилгээ” сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр Улаанбаатар хотод зохион байгуулав. Энэхүү уулзалт хэлэлцүүлэгт Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Медвик диализын төв, Нийслэлийн 6 дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн магадлагч эмч нар, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийт 30 гаруй эмч, мэргэжилтэн, иргэдийг хамруулав. Тус уулзалт хэлэлцүүлгээр эрүүл мэндийн даатгал болон нийгмийн хамгааллын салбараас хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж буй тусламж үйлчилгээ болон хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоох үйл ажиллагаанд мөрдөж буй хууль эрх зүйн баримт бичгийн талаар мэдээлэл өглөө. Мөн түүнчлэн тусламж үйлчилгээ үзүүлэхэд учирч буй хүндрэл, бэрхшээл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцож, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлсноороо ач холбогдолтой байв.

Нийслэлийн Багануур, Сүхбаатар дүүрэг, Баян-Өлгий, Дархан-Уул, Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх ЭХМК-ын цахим мэдээллийн санд бүртгэлтэй 15 000 гаруй иргэний мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эмнэлэг хөдөлмөр магадлалын цахим мэдээллийн сангийн бүртгэлийг нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагчдын мэдээллийн баазтай тулган шалгахад тахир дутуугийн тэтгэвэр зогсоогдсон 10, нас барсан 5, шилжиж ирсэн 2, ерөнхий мэдээлэл зөрүүтэй 1600, өвчний нэр, заалт зөрүүтэй 178 иргэн нийт 1800 орчим иргэний мэдээллийг нягтлан шалгаж, зөрүүг арилгах арга хэмжээ авах, хөдөлгөөн хийгдээгүй иргэдийн хөдөлгөөнийг бүртгэх хугацаатай үүрэг өгч, биелэлтэд хяналт тавин ажиллав.


Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Хүний эрхийн үндэсний дэд хорооноос шилжүүлсэн, Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисст албан байгууллага, даатгуулагч (иргэн)-аас ирүүлсэн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаатай холбоотой бичгээр ирүүлсэн 45 өргөдөл, гомдлыг хүлээн авч, ЭМЯ-ны мэргэжлийн салбар зөвлөл болон ЭХМТК-ын шинжээч эмч нараар дүгнэлт гаргуулан шийдвэрлэж бичгээр болон бусад хэлбэрээр, хуулийн хугацаанд нь хариуг хүргүүлэв.

Хяналт, шалгалтын чиглэлээр:

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын магадлагч эмч нар Багануур дүүрэгт хяналт, шалгалтыг зохион байгуулав.

Хөдөлмөрийн чадвар алдсан 173 даатгуулагч (иргэн)-ийг хамруулахаар төлөвлөсний дагуу 100 хувь хамруулж, тэдгээр иргэдийн тахир дутуугийн болон эмнэлгийн хувийн хэрэг, амбулаторийн карт, оношилгоо, шинжилгээний дүгнэлт зэрэгт тулгуурлан хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон байдалд хяналт шалгалт хийв. Дахин магадлалын хугацаанд нийт 165 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг хэвээр магадлаж, хугацаа дуусахаар цуцлахаар 2, хяналт сайжруулах 10, заалт өөрчлөх 3, 3 даатгуулагч (иргэн)-ийг онош батлах шинжилгээнд илгээв.

Зураг-1



Багануур дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын 2023 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн хурлын явцтай танилцав. Тухайн өдрийн

хурлаар нийт 24 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэлэлцсэнээс шинээр 3 иргэнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоож, 19 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг сунгаж, 2 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг цуцалж шийдвэрлэв. Комиссын гишүүдийн идэвх оролцоо сайн, гишүүд 100 хувийн ирцтэй оролцов.

Зураг-2




Мөн Багануур дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр авч буй 60 иргэний тэтгэврийн хувийн хэргийн бүрдүүлэлтийг шалгахад зөрчил илрээгүй болно.

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс болон Эмнэлгийн хяналтын комиссын гишүүд, мэдрэл, гэмтэл, дотрын эмч нарын төлөөлөл нийт 40 гаруй эмч мэргэжилтэнтэй 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдөр уулзалт зохион байгуулж, эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой эрх зүйн баримт бичгийн талаар, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэхэд анхаарах асуудлын талаар товч мэдээлэл хийж, санал солилцов. Уулзалтаар комиссын гишүүд, эмч нарын зүгээс жагсаалтад артерийн судасны эмгэгийн заалт шинээр нэмэх, дотрын өвчний бүлэгт байгаа арьсны өвчний заалт арьсны өвчний бүлэг рүү шилжүүлэх, жагсаалтын 7.15 заалтаар зөвхөн хүндрэлтэй үед хөдөлмөрийн чадвар алдалт тогтоодог байхаар, зүрхний шигдээс өвчний дараа хүндрэлгүй тохиолдолд тухайлбал 3.1.а, 3.4.а заалтуудыг 1 хүртэлх жил болгож өөрчлөх, гэмтлийн өвчний үед үйл ажиллагааны алдагдлын үнэлгээнд тулгуурлан хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх, өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтыг цуцалж, одоо авч байгаа тахир дутуугийн тэтгэврийн хэмжээг бууруулахгүйгээр өндөр насны тэтгэвэр тогтоодог байх зэрэг эрхзүйн зохицуулалт хийлгэх, хөдөлмөрийн чадвар алдалттай иргэдэд үзүүлэх сэргээн засах тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллах зайлшгүй шаардлагатай байгаа талаар санал дэвшүүлэв.

Зураг-3



Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/38 дугаар тушаалаар баталсан “Эмнэлгийн хуудас олгох, хянах журам”-ын хэрэгжилтийн байдалд Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв болон Энэрэлт-Өлзий, Дивангарьд өрхийн эрүүл мэндийн төвөөс даатгуулагчид бичиж олгосон хөдөлмөрийн чадвар түр алдсаны 677, жирэмсний болон амаржсаны 125, нийт 802 /давхардсан тоогоор/ эмнэлгийн хуудасны бичилт олголтын үндэслэлд E-Health, H-info, Medsoft програмын цахим бүртгэлийг үндэслэн шалгав.



Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дотоод ажил /төлөвлөгөө, тайлан, судалгаа зэрэг/-тай танилцаж, эмнэлэг хөдөлмөр магадлалын цахим мэдээллийн сангийн бүртгэлийг нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагчдын мэдээллийн баазтай тулган шалгахад 2023 оны 1, 2 дугаар сард тахир дутуугийн тэтгэвэр зогсоогдсон-10, нас барсан-5, шилжиж ирсэн-2, нийт 17 иргэний мэдээлэл зөрүүтэй байсныг шалгалтын хугацаанд хөдөлгөөнийг хийлгэж, бүртгэлийн зөрүүг арилгаж ажиллав. Мөн 2022, 2023 онд комиссын гишүүдийн хуралдаж ажилласан цагийн бүртгэлийг тэдгээрт олгосон цагийн хөлсний тооцоотой тулган шалгахад зөрчил илрээгүй болно.

Өвөрхангай аймагт Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын дахин магадлалыг зохион байгуулав.

Шалгалтад тус аймгийн Нийгмийн даатгал, Нийгмийн халамжийн сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагчид, аймгийн БОЭТ болон өрхийн эрүүл мэндийн төвүүд, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах болон Эмнэлэг хяналтын комисс хамрагдав.

Тус аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын бүрэлдэхүүн өөрчлөх батлах тухай” А/21 дугаар тушаалаар батлагдсан 10 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Шалгалтын хүрээнд хөдөлмөрийн чадвар алдсан иргэдээс түүвэрлэн Нийгмийн даатгал болон Нийгмийн халамжийн сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч **293** иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг магадлахаас:

- Сэтгэц – 71
- Сонсгол – 65
- Дотор – 151
- Бусад - 6

Нийт **285 /97.6%/** иргэнийг бичиг баримтад үндэслэн, шаардлагатай тохиолдолд иргэнийг байлцуулан дахин магадлаж, үүнээс **226 /79.3%/** иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэвээр, 11 иргэний заалтыг өөрчилж, 17 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг түр түдгэлзүүлж, онош эргэлзээтэй, заалт хувь, хугацаа зөрсөн, оношийн баталгаажилт хангалтгүй Хархорин сумын 15, Арвайхээр сумын 4, Баруунбаян-улаан, Өлзийт, Уянга, Хайрхан дулаан, Баянөндөр, Хужирт сумын тус бүр 1 нийт 25 иргэнийг цуцалж, 5 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг хугацаа дуусахаар цуцлах, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын дахин магадлалд тодорхойгүй шалтгаанаар хамрагдаагүй 5 иргэн /даатгуулагч/-ий амбулаторийн карт болон холбогдох материалыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисст хүргүүлж магадлуулахаар шийдвэрлэв.

Шалгалтын хугацаанд Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын нарийн бичгийн дарга болон магадлагч эмч нар нь Эмнэлэг хяналтын болон Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын 2023 оны 06 дугаар сарын 15-ний өдрийн хуралд оролцож хурлын явц, иргэн /даатгуулагч/-ий хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэж буй байдал, комиссын дотоод ажилтай танилцаж, хөдөлмөрийн чадвар алдалт түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж буй ажлын талаар болон эмнэлэг хөдөлмөрийн магадлалын ажлыг сайжруулах талаар санал солилцож, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Тухайн өдрийн хурлаар 42 иргэний асуудлыг хэлэлцэж 28 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгаж, 5 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалж, 9 иргэнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг шинээр тогтоож шийдвэрлэв.

2023 оны 06 дугаар сарын байдлаар олгосон жирэмсний болон амаржсаны 747, хөдөлмөрийн чадвар түр алдсаны 677 нийт 1424 тэтгэмжээс үргэлжилсэн хоног болон тэтгэмж

авсан давтамжийг харгалзан түүвэрлэж аймгийн БОЭТ, хувийн эмнэлгүүд, ӨЭМТ-с нийт 280 гаруй эмнэлгийн хуудсыг эрүүл мэндийн байгууллагын цахим бүртгэл, эмнэлгийн хуудас олголтын журнал, амбулаторийн карт, өвчний түүх зэрэг үндсэн материалтай тулган шалгахад эмнэлгийн хуудасны бичилт, олголттой холбоотой зөрчил илрээгүй нь Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/38 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн хуудас олгох, хянах журам”-ын хэрэгжилт хангалттай байна гэж дүгнэв.

Хамтарсан магадлал

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын хамтарсан магадлалыг хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоолгосон даатгуулагч (иргэн)-ийн тоогоор улсын дундаж (3.2)-аас өндөр байгаа Сэлэнгэ, Хэнтий, Өмнөговь аймгуудад Эрүүл мэндийн яамны мэргэжлийн салбар зөвлөлүүдтэй хамтран зохион байгуулав.

Хамтарсан магадлалаар дээрх аймгуудын хөдөлмөрийн чадвар алдсан 2824 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон байдалд хяналт шалгалт хийж, 1857 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэвээр магадлан, 408 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгаж, 169 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалж, 491 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, заалт, оношийг тус тус өөрчилж, 32 иргэнийг шинжилгээнд хамруулж магадлав.

Хамтарсан магадлалаар Сэлэнгэ аймгийн хөдөлмөрийн чадвар алдсан 1111 /92%/ иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон байдалд хяналт шалгалт хийж, 563 /50.6%/ даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэвээр магадлан, 221 /19.9%/ даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгаж, 62 /5.6%/ даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалж, 258 /23.2%/ даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, заалт, оношийг тус тус өөрчилж, 20 /1.8%/ иргэнийг шинжилгээнд хамруулж магадлав.

Зураг-5



Хяналт шалгалтын явцад тус аймгийн Засаг даргын тамгын газрын дарга, Эрүүл мэндийн газрын дарга нартай уулзалт зохион байгуулж, тус аймгийн хөдөлмөрийн чадвар алдалтын өнөөгийн байдал, эмнэлэг хөдөлмөр магадлалын үйл ажиллагааны талаар санал солилцов.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дотоод ажилтай танилцаж, цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлт, сүүлийн 3 жилийн тайлан, хурлын ирц, цагийн хөлс олгосон тооцоо болон эмнэлгийн хувийн хэргийн хөдөлмөрийг шалгаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дарга, гишүүд, Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлэг, өрх, сумын Эрүүл мэндийн төв, орон нутгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс, Эмнэлэг хяналтын комиссын гишүүд, эмч, мэргэжилтнүүдэд Зонхилон тохиолдох дотор, сэтгэц, мэдрэл, гэмтэл согог, чих, хамар хоолойн өвчний үед иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэхэд анхаарах асуудал, оношийн баталгаажилт, ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зэрэг сэдвээр сургалт зохион байгуулав. Сургалтыг:

- ✓ “Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын өнөөгийн байдал”
- ✓ “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”

- ✓ “Дотрын өвчнөөр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтооход анхаарах асуудал, оношийн баталгаажилт”
- ✓ “Чих хамар хоолойн өвчнөөр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтооход анхаарах асуудал, оношийн баталгаажилт”
- ✓ “Сэтгэцийн өвчнөөр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтооход анхаарах асуудал, оношийн баталгаажилт”
- ✓ “Мэдрэлийн өвчнөөр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтооход анхаарах асуудал, оношийн баталгаажилт”
- ✓ “Оюуны хомсдолын эмгэгийн тухай”
- ✓ “Зүрхний архаг дутагдал” сэдвээр тус тус хичээл зааж асуусан асуултад хариулт өгч мэргэжил аргагүйгээр хангаж ажиллав.

Зураг-6



• Хэнтий аймгийн хамтарсан магадлалыг 2023 оны 5 сарын 7-16-ны өдрүүдэд зохион байгуулав. Хамтарсан магадлалаар Хэнтий аймгийн хөдөлмөрийн чадвар алдсан 947 /93%/ иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон байдалд хяналт шалгалт хийж, 762 /80.5%/ даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэвээр магадлан, 59 /6.2%/ даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалж, 117 /12.4%/ даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, заалт, оношийг тус тус өөрчилж, 9 /0.9%/ иргэнийг шинжилгээнд хамруулж магадлав.

Зураг-7



Хяналт шалгалтын явцад тус аймгийн Засаг даргатай 2023 оны 5 дугаар сарын 8-ны өдөр уулзаж, хамтарсан магадлал зохион байгуулах нэгдсэн удирдамж болон тус аймгийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн тоон мэдээлэл зэргийг танилцуулж хамтарсан магадлалын хугацаанд иргэдийг бүрэн хамруулах талаар ярилцаж, санал солилцов.

Зураг-8



Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Нэгдсэн эмнэлэгтэй хамтран Эмнэлэг хяналтын болон Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүд, нэгдсэн эмнэлгийн 30 гаруй эмч, мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулав. Сургалтыг:

- ✓ “Эмнэлэг хөдөлмөр магадлалын өнөөгийн байдал”
- ✓ “Гэмтлийн өвчний үед хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтооход анхаарах асуудлууд”
- ✓ “Чих, хамар, хоолойн өвчний үеийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтооход анхаарах асуудал оношийн баталгаажилт”
- ✓ “Сэтгэцийн эмгэгээр хөдөлмөрийн чадвар алдалт тогтоох, сунгахад анхаарах асуудлууд”
- ✓ “Зүрх судасны өвчнөөр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтооход анхаарах асуудал, оношийн баталгаажилт, хяналт”
- ✓ “Мэдрэлийн өвчний шалтгаанаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтооход анхаарах асуудлууд” сэдвээр тус тус хичээл зааж эмч мэргэжилтнүүдийн асуусан асуултад хариулт өгч мэргэжил аргазүйгээр хангаж ажиллав.

Зураг-9



Хяналт, шалгалтын дүнгийн хурлыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн хурлын танхимд зохион байгуулав. Хуралд аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Эмнэлэг хяналтын болон Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын гишүүд 20 гаруй удирдлага, эмч, мэргэжилтнүүд оролцов.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нэгдсэн удирдамжийн дагуу Өмнөговь аймагт хамтарсан магадлалыг 2023 оны 09 сарын 07-ны өдрөөс 09 дугаар сарын 14-ний өдрүүдэд зохион байгуулав.

Хамтарсан магадлалаар Өмнөговь аймгийн хөдөлмөрийн чадвар алдсан **816** (нэмэлт 5) иргэнийг хамруулахаар төлөвлөснөөс **767 /93.9%/** даатгуулагч (иргэн)-д төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоо, шинжилгээ хийж, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, хэмжээ тогтоосон байдалд хяналт шалгалт хийв.

Зураг-10



Хамтарсан магадлалд хамрагдах иргэдийн 291 /35.6%/ нь мэдрэл, 268 /32.8%/ нь сэтгэгц, 257 /31.6%/ нь дотрын өвчний учир хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон байв. (нэмэлт дотор 4, мэдрэл 1)

Хамтарсан магадлалаар нийт 766 иргэнийг магадласнаас:

- ✓ Хэвээр – 532 /69.2%/

- ✓ Сунгасан – 187 /21.3%/ үүнээс:
 - Хувь буурсан- 51
 - Хувь- нэмсэн- 37
 - Хувь хэвээр- 97
 - Заалт өөрчлөгдсөн- 116
 - Заалт хэвээр- 70
- ✓ Цуцлагдсан - 48 /6.1%/
- ✓ Үзлэг шинжилгээнд илгээсэн - 3 /0.5%/ байна.
- ✓ Хамрагдаагүй- 27 /4.4%/

Биеийн байдал хүнд, хэвтрийн өвчтэй, зөөвөрлөх боломжгүй сэтгэцийн өвчнөөр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон 3 иргэнийг бичиг, баримтад тулгуурлан, цахимаар магадлав.

Зураг-11



Хамтарсан магадлалын явцад тус аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүдэд дотор, сэтгэц, мэдрэлийн өвчнөөр ажлын байран дах сургалт хийж, иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтооход анхаарах асуудлуудын талаар мэргэжил арга зүйгээр хангаж ажиллав.

Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын даргатай уулзалт зохион байгуулж комиссын үйл ажиллагааг сайжруулах, батлагдсан бүрэлдэхүүнээр хуралдах, магадлагч эмчийг орон тоогоор ажиллуулах талаар ярилцаж, санал солилцов.

Хяналт, шалгалтын дүнгийн хурлыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хурлын танхимд зохион байгуулав. Хуралд аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эмнэлэг хяналтын болон Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын гишүүд нийт 20 гаруй удирдлага, эмч, мэргэжилтнүүд оролцов.

Дүнгийн хурлаар хяналт шалгалтын дүнг танилцуулж, илэрсэн зөрчил дутагдал, цаашид анхаарах асуудал, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэв.

Зураг-12



ЭХМТК-ын магадлагч эмч нар хариуцсан аймаг, дүүргийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлын үед онлайн хэлбэрээр хуралд оролцож буй комиссын гишүүдийн ирц, халдвар хамгааллын дэглэм баримталж байгаа байдалд хяналт тавьж, орон нутаг болон салбар комиссын хурлын мэдээг аймаг, дүүрэг тус бүрээр авч нэгтгэж байна. 21 аймаг,

нийслэлийн 8 дүүргийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссууд 2023 онд 5600 гаруй иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэж буй байдалд Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын хамтарсан магадлал, дахин магадлал болон мэдээллийн баазад үндэслэн цахимаар хяналт тавьж ажиллав. Хяналт шалгалтаар 500 гаруй иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг өөрчилж магадлав.

Сэлэнгэ, Өвөрхангай, Хэнтий, Өмнөговь, Архангай аймаг, нийслэлийн Багануур, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс хөдөлмөрийн чадвар түр алдсаны 3700, жирэмсэн амаржсаны 2900 орчим иргэнд эмнэлгийн хуудасны тэтгэмж олгосон байдлыг түүвэрлэн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын дахин магадлал, хамтарсан магадлалаар болон “Medmonitor” цахим эмнэлгийн хуудасны программаар хяналт хийв. Үүнээс хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг 3 ба түүнээс дээш удаагийн давтамжтай авсан, тэтгэмж олгосон мөнгөн дүн тодорхойгүй зэрэг давхардсан тоогоор 60 орчим даатгуулагчид олгосон ХЧТА-ны тэтгэмж, жирэмсний эмнэлгийн хуудсыг тэтгэмжийн эрх үүсгэх зорилгоор хойшлуулж олгосон байж болзошгүй 40 гаруй даатгуулагч эхэд олгосон жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн нийт 100 гаруй иргэний тэтгэмжийн үндэслэлийг нягтлан шалгах хугацаатай үүрэг өгч биелэлтийг хангуулж ажиллав.

Орон нутаг болон салбар комиссын хурлын мэдээг аймаг, дүүрэг тус бүрээр авч сар бүр нэгтгэн удирдлагад танилцуулан ажиллаж байна. Үүнд 21 аймаг, нийслэлийн 8 дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссууд 2023 оны жилийн эцсийн байдлаар 10356 иргэнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоож, 60216 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгаж, 48 иргэний хөдөлмөрийн нөхцөл сольсон, 7202 иргэнийг цуцалж, нийт 77822 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэсэн байна.

Авлигатай тэмцэх газраас шинжээч томилох тухай ирүүлсэн албан бичгийн дагуу тус комиссын эмч шинжээчээр томилогдож холбогдох Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлийн мэргэжилтнүүдтэй хамтран нэр бүхий 15 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэсэн нь үндэслэлтэй эсэх талаар дүгнэлт гаргахаас 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар 3 иргэний хамтарсан шинжээчийн дүгнэлтийг гарган Авлигатай тэмцэх газар хүргүүлэв.

[Сургалт, судалгааны чиглэлээр:](#)

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран Сэтгэцийн өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэхтэй холбоотой тулгамдаж буй асуудал, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар аймаг, дүүргийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүд, эрүүл мэндийн байгууллагын нийт 194 эмч мэргэжилтнүүдийг хамруулсан сургалт, уулзалтыг 2023 оны 2 дугаар сарын 9-ний цахимаар зохион байгуулав.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссоос Монголын Хөдөлмөрийн эрүүл ахуйчдын үндэсний холбоотой хамтран “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний шинэ стандартын танилцуулах сургалт”-ыг 2023 оны 2 дугаар сарын 28-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулав. Сургалтад Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв, салбар, орон нутгийн комиссын дарга, магадлагч эмч, Хөдөлмөрийн эрүүл ахуйчдын үндэсний холбоо, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэр, Хөтөлийн цемент шохойн үйлдвэр, Багануурын уурхай, мэргэжлээс шалтгаалсан өвчний Эрдэнэт, Багануур сувилал зэрэг байгууллагын төлөөлөл, нийт 50 гаруй эмч, мэргэжилтнүүд оролцов. Сургалтаар ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн ангилал, үнэлгээнд тавигдах шаардлага MNS 5080:2022 стандартыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал болон ҮОМШӨ-ий хөдөлмөрийн чадвар алдалтын өнөөгийн байдлын талаар товч мэдээлэл хийж, багц стандартыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлаар санал солилцов.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссоос “Эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой тушаал шийдвэрийн хэрэгжилтэд анхаарах асуудал” сэдэвт сургалтыг 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр Сэлэнгэ аймагт зохион байгуулав. Сургалтад Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн яамны мэргэжлийн салбар зөвлөл, Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлэг, өрх, сумын Эрүүл мэндийн төвийн 40 орчим эмч мэргэжилтнүүд оролцов.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссоос “Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйлчилгээг боловсронгуй болгох нь” сэдэвт төвийн бүсийн зөвлөгөөнийг 2023 оны 4 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд Сэлэнгэ аймагт зохион байгуулав. Зөвлөгөөнд Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн яамны мэргэжлийн салбар зөвлөл, Сэлэнгэ, Дархан-Уул,


Хөвсгөл, Булган, Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дарга, гишүүд, Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлэг, өрх, сумын Эрүүл мэндийн төв, орон нутгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс, Эмнэлэг хяналтын комиссын гишүүд, эмч, мэргэжилтнүүдэд, нийт 70 гаруй эмч, мэргэжилтнүүд оролцов. Зөвлөгөөнөөр эмнэлэг хөдөлмөрийн магадлалын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэв. Үүнд: Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын өнөөгийн байдал, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрмийн хэрэгжилт, Эрүүл мэндийн яамны Дотор, Чих хамар хоолой, Сэтгэц, Гэмтэл, Мэдрэлийн мэргэжлийн салбар зөвлөлөөс хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтооход анхаарах асуудал, оношийн баталгаажилт, хяналт, Оюуны хомсдлын эмгэгийн тухай, Зүрхний архаг дутагдал сэдвүүдээр тус тус хичээл заав. Мөн Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Ёс зүйн үнэлэмж ба бидний хандлага тухай сэдвээр сургалт хийж, мэдээлэл өгөв. Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаатай танилцаж, харилцан туршлага солилцож, эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагааг боловсронгуй болгох нь сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

Зураг-13



Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс, Эрүүл мэндийн байгууллагын Эмнэлэг хяналтын комиссын гишүүд болон эмч, мэргэжилтнүүдэд “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” сэдэвт цахим сургалтыг 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулав. Сургалтад Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүд 140, Эрүүл мэндийн байгууллагын Эмнэлэг хяналтын комиссын гишүүд 58, нийт 198 эмч, мэргэжилтнүүд оролцов.

Зураг-14



Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас сувиллын болон унааны зардал авсан даатгуулагчдын судалгааг авч нэгтгэв. Судалгаагаар улсын хэмжээнд үйлдвэрлэлийн ослын сангаас нийт 3084 иргэн тахир дутуугийн тэтгэвэр авч байгаагаас 1560 буюу 50.6 хувь нь сэргээн засах сувиллын тусламж, үйлчилгээнд хамрагдаж, сангаас 593.4 сая төгрөгийн сувиллын зардал, 23.8 сая төгрөгийн унааны зардал гаргуулсан байна.

Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлтэй холбоотойгоор Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын Улсын зөвлөгөөнийг 2023 оны 09 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулав. Энэхүү зөвлөгөөнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Эрүүл Мэндийн Яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлийн дарга, гишүүд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын удирдлага,

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс болон аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн магадлагч эмч нийт 50 орчим эмч, мэргэжилтнүүдийг хамруулав.

Зураг-15



Уг зөвлөгөөнөөр эмнэлэг хөдөлмөрийн магадлалд оролцогч талууд ХНХЯ, ЭХМТК-оос эмнэлэг хөдөлмөрийн магадлалын бодлого, үйл ажиллагааны талаар, ЭМЯ-ны дэргэдэх дотор, мэдрэл, сэтгэц, чих хамар хоолойн өвчний мэргэжлийн салбар зөвлөлийн мэргэшсэн эмч, багш хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтооход анхаарах асуудлын талаар хичээл заав.

Сэлэнгэ аймгийн “Миний монгол”, Хэнтий аймгийн “Өндөрхаан”, телевиз, “Шууд.mn” сайтуудад иргэн (даатгуулагч)-ий хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэж буй үйл ажиллагааны талаар болон эмнэлгийн хуудасны бичилт, олголтыг цахимжуулсантай холбоотой асуудлаар нийт 3 удаа мэдээлэл өгөв.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах үйл ажиллагаанд оролцдог эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдэд даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, сунгах, гадаад улсад удаан хугацаагаар эмчлүүлж байгаа иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэрхэн шийдвэрлэх талаар” болон хөдөлмөрийн чадвар түр алдсан, жирэмсэн, амаржсаны эмнэлгийн хуудас олгох бичих хугацаа, олгох үйл явцын талаар зөвлөмж боловсруулж хүргүүлэв.

[Тайлагнах, мэдээлэх үйл ажиллагаа](#)

Дараах 3 тайланг нэгтгэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан үр дүнг тооцож ажиллав. Үүнд:

- Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссуудын 2022 оны хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон актын маягтын зарцуулалтын тайлан.

Нийт 21 аймаг, 8 дүүргийн орон нутгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс, Сэтгэцийн болон Мэргэжлээс шалтгаалсан өвчний салбар комиссуудаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон актын маягтын зарцуулалтын тайланг авч нэгтгэв. Үүнд:

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар 94710 даатгуулагч (иргэн)-ийг хэлэлцэн, нийт 85673 актын маягт зарцуулсан нь 2021 онтой харьцуулахад /-2.6%/-иар буурсан үзүүлэлттэй байна. 2022 онд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинээр тогтоолгосон даатгуулагч 12445 /14.5%/, хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг хэвээр сунгасан 53945 /62.9%/, хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг нэмэгдүүлэн сунгасан 9747 /11.3%/, хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг бууруулан сунгасан 13326 /15.5%/ нийт 85673 буюу /97.8%/ даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэн актын маягтыг зарцуулж, 1414 /1.6%/ актын маягт хүчингүй болсон байна. Тухайлбал Баянхонгор аймаг 134, Чингэлтэй дүүрэг 132, Сонгинохайрхан дүүрэг 127 актын маягт хүчингүй болгосон нь нийт хүчингүй болсон актын маягтын 393 /27.7%/-ийг эзэлж байна.

Сэтгэцийн болон Мэргэжлээс шалтгаалах өвчний салбар комиссууд 3483 актын маягт зарцуулсан байна. 2021 онтой харьцуулахад нийт актын маягтын зарцуулалт 3624 /3.8%/-иар буурсан үзүүлэлттэй байна.

Хүчингүй болсон актын маягтыг судлан үзэхэд, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэх актын маягтын хэвлэлийн алдаа 513 буюу /26.6%/-ийг эзэлж байгаа нь салбар болон орон нутгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлын ачаалал их байгаатай холбоотой гэж үзэв.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын 2023 оны жилийн эцсийн тоон тайланг нэгтгэж удирдлагад танилцуулан ХНХЯ, ЭМЯ хүргүүлэн ажиллав. Эмнэлэг хөдөлмөр магадлалын тоон тайлангийн нэгтгэлээр 2023 оны жилийн эцсийн байдлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон 102675 иргэн байна. Энэ нь өнгөрсөн оны тоон үзүүлэлттэй харьцуулахад

0.5 хувиар буурсан байна. Үүнээс Нийслэлийн хэмжээнд 40189 (39.2%) иргэн, орон нутгийн хэмжээнд 62486/ (60.8%) иргэн хөдөлмөрийн алдалтын хувь, хугацаа тогтоолгосон байна.

Нийт хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн 46.5 хувь нь хөдөлмөрийн чадвараа бүрэн, 53.5 хувь нь хагас алдсан байна.

Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэдийн тоо 8.8%-иар буурсан, хагас алдсан иргэдийн тоо 4.3%-иар ихэссэн байна.

Дотор, сэтгэц, мэдрэл, гэмтэл, нүдний өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон иргэдийн тоо өмнөх оны мөн үеийнхээс (81833) -1.7 хувиар буурч 80410 болсон байна. Энэ нь нийт хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэж буй өвчлөлийн 77.9 хувийг эзэлж сүүлийн 3 жил хөдөлмөрийн чадвар алдалтын тэргүүлэх шалтгаан болсон хэвээр байна.

Тус онд Архангай (-12.9%), Баянхонгор (-12.0%), Баян-Өлгий (-9.3%), Увс (-8.7%) аймгийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн тоо буурсан, Говьсүмбэр (7.7%), Өмнөговь (3.8%) аймаг, Хан-уул (3.7%), Сүхбаатар (3.5%) дүүргийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн тоо өссөн үзүүлэлттэй байна.

Ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан болж буй 30 бүлэг өвчнөөс дотор, сэтгэц, мэдрэл, гэмтэл, чих, хамар хоолойн өвчин нийт хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн 77.9 хувийг эзэлж, сүүлийн 3 жил дараалан хөдөлмөрийн чадвар алдалтын тэргүүлэх шалтгаан болсон хэвээр байна.

Нийт хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн 54.0 хувь (55730) нь 31-50 насны иргэд байгаа бөгөөд 20-59 насны хөдөлмөрийн чадвар алдалттай иргэдийн 2021 онтой харьцуулахад буурч, 60-аас дээших насны хөдөлмөрийн чадвар алдалттай иргэдийн тоо өссөн дүнтэй байна. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгож буй иргэдийн дундаж нас 43, эрэгтэй дундаж нас 44, эмэгтэй дундаж нас 42 байна. Мөн Мэргэжлээс шалтгаалсан өвчний Эмнэлэг хөдөлмөрийн магадлах салбар комиссоор ХЧА шийдвэрлүүлсэн иргэдийн дундаж нас хамгийн өндөр буюу 60, Сүхбаатар аймгийн ЭХМК-оор ХЧА шийдвэрлүүлсэн иргэдийн дундаж нас хамгийн бага буюу 35 байна.

Нийт хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн 59.6 хувь нь эрэгтэй 40.4 хувь нь эмэгтэй байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд ХЧА-ын хувь, хугацаа тогтоолгосон эрэгтэйчүүдийн тоо 11.5, эмэгтэйчүүдийн тоо 4.3 хувиар тус тус буурсан байна.

Нийт иргэдийн 18.0 хувь нь хөдөлмөрийн чадвар алдалт хугацаагүй тогтоолгосон байх бөгөөд 2021 оны тоон үзүүлэлттэй харьцуулахад 16.0 хувиар өссөн байна.

Үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэд өмнөх оны жилийн эцсээс 0.8 хувиар буурсан байна.

Хол, ойрын эрхтэндээ үсэрхийлж III,IV үедээ орсон хорт хавдар өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн тоо 2022 онд 28.3 хувиар, хорт хавдрын улмаас эрхтэн тайрсан ба авхуулсан 8.4 хувиар буурсан, I,II үеийн хорт хавдрууд мэс засал болон өвөрмөц (хими, туяа) эмчилгээний дараа хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн тоо 60.8 хувиар өссөн нь Монгол Улсын Засгийн газар, Эрүүл мэндийн яамнаас “Эрүүл мэнд үндэсний баялаг” уриа дор санаачлан хэрэгжүүлсэн халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээ, оношилгооны үйл ажиллагаатай холбоотой гэж дүгнэж болохоор байна.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой дүрэм, журмуудыг шинэчилсэнтэй холбоотойгоор цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд тавих хяналт сайжирч, холбогдох өөрчлөлтийг тухай бүр тогтмол оруулж хэвшив.

- Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрээр 2023 оны эхний хагас жилийн байдлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэд өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад -1.3 (103166) хувиар буурсан байна. алдалтын хувь, хугацааг шинээр тогтоолгосон 5971, сунгуулсан 97195, цуцлуулсан 3566, нас барсан 1034, хөдөлмөрийн нөхцөл сольсон 61, ажлын цаг хорогдуулсан 1 иргэн (даатгуулагч) байна.

Сүүлийн 3 жил хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон, сунгуулсан иргэдийн тоо тогтмол буурч байна. Дотор, Сэтгэц, Гэмтэл согогийн өвчин, Мэдрэл, Нүдний өвчин нь нийт хөдөлмөрийн чадвар алдалтын тэргүүлэх шалтгаан болсон хэвээр байна. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон, сунгуулсан иргэдийн тоо аймгийн хэмжээнд 2.7 хувиар буурсан бол, дүүрэгт 1.9 хувиар өссөн байна. Үүнээс Сүхбаатар дүүрэг (5.5), Сонгинохайрхан дүүрэг (4.9), Говьсүмбэр (3.6), Өмнөговь (2.5), Сүхбаатар (2.5), Дархан-уул (1.9) аймгуудад хамгийн өндөр өсөлттэй байгаа бол Архангай (-10.5), Завхан (-6.5),

Баянхонгор (-6.4), Увс (-6.3), хамгийн их буурсан үзүүлэлттэй байна. Нийт хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа цуцлуулсан иргэдийн 34.7 хувь (1247) иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгох шалтгаанаар, 20.6 хувь (737) иргэн “эрхтэн системийн үйл ажиллагаа тогтворжсон” шалтгаанаар ХЧА-ын хувь, хугацаа цуцлуулсан байна. Үүнээс үзэхэд иргэнийг хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагаа, түүнд тавих хяналт хангалтгүй байна гэж дүгнэв.

Нийт хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийг насны ангиллаар авч үзвэл 31-50 насны нийт 55460 (53.7) иргэн эзэлж байна. Хүйсээр авч үзвэл 61622 (59.7)-ийг эрэгтэйчүүд эзэлж байна.

Үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шийдвэрлүүлсэн иргэдийн тоо хагас жилийн байдлаар 918 иргэн байна. Энэ нь сүүлийн 3 жилийн харьцуулсан үзүүлэлтээр 0.3-иар өссөн үзүүлэлттэй байна. ХЧА-ыг шийдвэрлүүлж буй тэргүүлэх өвчлөл сүүлийн 3 жилийн харьцуулалтаар Гэмтэл согогийн өвчин, Мэдрэлийн өвчин, Нүдний өвчин эдгээр өвчлөл тэргүүлэх шалтгаан болж байна. Насны ангиллаар авч үзвэл 31-50 насны 382 (43.6) эзэлж байгаа нь анхаарал татаж байна.

Мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шийдвэрлүүлсэн иргэдийн тоо хагас жилийн байдлаар 2689 иргэн байна. Энэ нь сүүлийн 3 жилийн харьцуулсан үзүүлэлтээр -2.8-иар буурсан үзүүлэлттэй байна. ХЧА-ыг шийдвэрлүүлж буй тэргүүлэх өвчлөл сүүлийн 3 жилийн харьцуулалтаар Уушги тоосжих, Мэдрэлийн өвчин, Хордлогын өвчнүүд тэргүүлэх шалтгаан болж байна. Нийт хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийг нийгмийн байдлаар нь авч үзвэл ажилчин болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд 49964 буюу 48.4 хувийг эзэлж байна. “Ажилчин” ангилал сүүлийн 3 жилийн харьцуулсан үзүүлэлтээр тогтмол буурсан байна. Шинээр тогтоолгосон нийт иргэдийн 11.7 хувийг хорт хавдарын улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэд эзэлж байгаа нь улсын хэмжээнд анхаарах асуудал болсон гэж харж байна.

- Мэргэжлээс шалтгаалсан өвчний сувиллуудын 2022 оны тайланг хүлээн авч нэгтгэв. Мэргэжлээс шалтгаалсан өвчний сувиллууд нь бүгд магадлан итгэмжлэгдсэн бөгөөд сувиллын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаагаа зохих түвшинд явуулж, сувиллын гэрээний биелэлт сүүлийн 5 жилийн байдлаар 80-аас дээш хувьтай дүгнэгдсэн байна. Рашаан сувиллын бүтэц, үйл ажиллагааны MNS5232:2019 стандартад заасан эмч, мэргэжилтний орон тооны доод хязгаараас дээгүүр буюу стандартад заасан хүний нөөц, орон тоогоор ажиллаж байна.

Сувиллын зардлыг жилд 1.2 орчим тэрбум төгрөгөөр төсөвлөдөг боловч сүүлийн 5 жилийн байдлаар төсвийн гүйцэтгэл 6.2-80.4 хувь байна. Энэ нь сүүлийн 2 жилийн хугацаанд сувиллын байрыг коронавирусын батлагдсан тохиолдлыг эмчлэх болон тусгаарлах байрны зориулалтаар ажиллуулсан, хөл хорио тогтоосон зэрэг шалтгаанаас хамаарч төсвийн гүйцэтгэл 2020, 2021 онуудад огцом буурсан байна.

Сувилалд хамрагдсан иргэдийн биеийн байдалд хийсэн үнэлэлт дүгнэлт, үзүүлсэн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд хийсэн шинжилгээ, судалгаа байхгүй байгаа нь Мэргэжлээс шалтгаалсан өвчний сувиллын чанар, хүртээмжийг үнэлэхэд бэрхшээлтэй байна. Баян-Өлгий, Дархан-Уул, Орхон аймаг, нийслэлийн Багануур, Сүхбаатар дүүргийн ЭХМК-ын нийт 20 иргэний амбулаторийн картын бичилт, оношийн баталгаажуулалт, ЭХМК-ын хурлын шийдвэр зэрэгт “Ижил мэргэжилтний үзлэг” зохион байгуулж, 2022 оны 06 сарын 09-ний өдөр цахим хэлбэрээр хэлэлцүүлэв. Хэлэлцүүлэгт ЭХМТК болон ижил мэргэжилтний үзлэгт оролцсон аймаг, дүүргийн ЭХМК, ЭХК-ын магадлагч эмч, төрөлжсөн мэргэжлийн нийт 30 орчим эмч, мэргэжилтнүүд оролцов.

5. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, төрийн болон бусад байгууллагууд, ажил олгогч, иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг цахимаар хүргэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2023 онд дараах ажлуудыг гүйцэтгэлээ. Үүнд:

Шинээр 3 систем боловсруулан нэвтрүүлэв.

1. Даатгуулагч жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлтээ, мөн сайн дураар даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад гаргах хугацаа дуусахаас 8 хоногийн өмнө сануулах мэдэгдлийг тухайн

даатгуулагчийн гар утасны дугаар руу мессежээр илгээх “Message” системийг шинээр боловсруулан нэвтрүүлэв. Даатгуулагч уг мэдэгдлийн дагуу хүсэлтээ E-Mongolia портал, “Даатгуулагчид зориулсан вэб” системийг ашиглан цахимаар илгээх боломжтой бөгөөд энэ онд нийтдээ 11.9 мянган даатгуулагчид сануулах мессежийг илгээсэн байна.

2. “Шимтгэлийн цахим систем”-д ажил олгогч цахимаар бүртгүүлэх боломжийг шинээр бүрдүүлж нэвтрүүлэв. Ингэснээр ажил олгогч нийгмийн даатгалын байгууллагад ирэлгүйгээр бүртгүүлэх хүсэлтээ цахимаар илгээж, системд нэвтрэх нэр, нууц үгийг цахимаар авах юм. Ажил олгогчоос ирсэн хүсэлтийг нийгмийн даатгалын байцаагч хүлээн авч мэдээллийг шалгасны үндсэн дээр үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын санд төлөх шимтгэлийн хувь хэмжээг тогтоож, баталгаажуулснаар нэвтрэх нэр, нууц үг илгээгдэх боломжтой болов.
3. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагч “Даатгуулагчид зориулсан вэб” систем болон E-Mongolia порталыг ашиглан онлайнгаар шимтгэлээ төлөх боломжийг шинээр бүрдүүлэн туршин тестлэв.

Програм хангамжуудад 70 гаруй удаагийн өөрчлөлт хөгжүүлэлт хийв.

Салбарын хэмжээнд нийтдээ 45 програм хангамж ашиглагдаж байгаа бөгөөд эдгээрт хууль тогтоомжийн өөрчлөлт, хэрэглэгчийн хүсэлтээр өөрчлөлт хөгжүүлэлт, сайжруулалт хийх ажлыг тогтмол гүйцэтгэж байна. Үүний дүнд одоогийн байдлаар нийгмийн даатгалын үйлчилгээний 80% нь цахимжаад байна.

2023 онд хэрэгжих хууль тогтоомжийн өөрчлөлт болон хэрэглэгчийн хүсэлтээр програм хангамжуудад 70 гаруй удаагийн өөрчлөлт хөгжүүлэлт, сайжруулалтыг хийж цаг тухай бүрд нь нэвтрүүлэн нийгмийн даатгалын үйлчилгээний тасралтгүй, хэвийн ажиллагааг ханган ажиллалаа. Тухайлбал:

- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан болзол, нөхцөлөөр 2023 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгох насны шалгуурыг эрэгтэй 61 нас 6 сар, эмэгтэй 56 нас 6 сар, шимтгэл төлөх хугацааны шалгуурыг 21 жил 6 сараар тохируулав.
- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны “Оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 04 дүгээр тогтоолын дагуу нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох оршуулгын тэтгэмжийн хэмжээг 2 сая төгрөгөөр, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш амьгүй донор болж эд эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт олгох оршуулгын тэтгэмжийн хэмжээг 3 сая 500 мянган төгрөгөөр тус тус тохируулав.
- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2022 оны 10 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шимтгэлийн цахим систем, мөн шимтгэлийн, сайн дурын даатгалын, цаатан иргэдийн шимтгэлийн, тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн орлогын тооцооны програм хангамжуудад албан журмын болон сайн дураар даатгуулагчийн шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлсний дээд, доод хэмжээ, даатгуулагчийн тэтгэвэр, тэтгэмж тооцох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд, доод хэмжээг тохируулах өөрчлөлтийг хийв.
- Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Засгийн газрын 2023 оны 60 дугаар тогтоол, мөн ЦЕГ, ХБХЕГ-ын хүсэлтийн дагуу НДЕГ-ын даргын тушаалаар шинэчлэн баталсан даатгуулагчийн төрлийн 7 кодын хувь хэмжээг тохируулав.
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2013 оны А/197 дугаар тушаалаар баталсан “Даатгуулагчийн үндсэн ажил олгогчоос гадна нэгээс дээш байгууллагад ажиллан илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох аргачлал”-ын дагуу 2022 оны илүү төлсөн шимтгэлээ буцаан авах эрх нь үүссэн нийт 15 883 даатгуулагчийн мэдээллийг мэдээллийн санд байршуулж, даатгуулагчдад илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох боломжийг бүрдүүлэв.
- Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны “Итгэлцүүр шинэчлэн батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай, “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” тогтоолуудын дагуу нийт 490.0 гаруй мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлэн олгохтой уялдуулан тэтгэврийн тооцооны програм хангамжид 14 төрлийн өөрчлөлтийг оруулах, тэтгэвэр авагч “Даатгуулагчид зориулсан вэб” системийг ашиглан

2023 оны 07 дугаар сарын 01-ний тэтгэврийн нэмэгдлийн мэдээлэл, шинэ итгэлцүүрээр өсгөсөн цалингийн мэдээллээ дэлгэрэнгүй харах боломжийг бүрдүүлэх ажлуудыг гүйцэтгэн тэтгэврийн хэмжээг цаг хугацаанд нь нэмэгдүүлэх нөхцөлөөр ханган ажиллав.

- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль шинэчлэн батлагдаж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжихтэй холбогдуулан хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалтын дагуу 2019 онд дараалсан 6, 2020-2023 онд дараалсан 7 жилийн цалин хөлсний дунджаас тэтгэврээ тогтоолгосон тэтгэвэр авагч тэтгэврээ 5 жилийн дундаж цалин хөлснөөс өөрчлөн тогтоолгох хүсэлтээ “Даатгуулагчид зориулсан вэб” систем болон E-Mongolia порталыг ашиглан цахимаар илгээх боломжийг бүрдүүлэв.
- Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, баталгаажуулах, сэргээх шалгалт авах програм хангамжийг бэлтгэх, байцаагч, ажилтнуудын мэдээлэл болон шалгалтын асуулт, бодлогын нийт 46 бүлэг, 2.0 мянга гаруй асуулт бодлогын 8.2 мянга хариултын хувилбар, 500 бодлогын текстийг хариулт хувилбаруудын хамтаар хөрвүүлэн дүнгийн хуудсыг хэвлэх боломжийг бүрдүүлж шалгалтад хамрагдсан байцаагч, ажилтнуудаас ерөнхий мэдлэгийн шалгалтыг авч дүгнэх үйл ажиллагааг хувь хүний оролцоо, нөлөөлөлгүйгээр системээр амжилттай явуулах нөхцөлийг бүрдүүлэв.

Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн санг баяжуулав.

Нийгмийн даатгалын салбарын төв орон нутгийн 30 нэгжийн мэдээллийн санг өдөр бүр цахимаар цуглуулан нэгтгэж нэгдсэн мэдээллийн санг үүсгэх ажлыг тогтмол хийж гүйцэтгэлээ. Энэ онд ажил олгогч, даатгуулагч, тэтгэвэр, тэтгэмж авагчийн дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан 112.8GB хэмжээтэй нэгдсэн мэдээллийн сан нэмж үүсгэв.

Нэгдсэн мэдээллийн сангаас 200 гаруй удаагийн мэдээллийн боловсруулалт, судалгаа тооцоолол гаргав.

Нийгмийн даатгалын нэгдсэн өгөгдлийн сангаас яам, агентлаг, төрийн болон бусад байгууллагын хүсэлтээр нийтдээ 200 гаруй удаагийн мэдээллийн боловсруулалт, судалаа гаргаж хэрэглэгчдийг цаг тухайд нь мэдээллээр ханган ажиллав. Тухайлбал:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд:

* Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэгт шаардлагатай мэдээллийг **3 удаа**;

* Тэтгэврийн зөрүүг ойртуулах зорилгоор тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтооход шаардлагатай мэдээллийг **2 удаа, 12 хувилбараар**;

- Засгийн газрын 2023 оны 238 дугаар тогтоолын дагуу хийгдсэн тэтгэврийн нэмэгдлийн талаар иргэдээс гаргасан хүсэлтийг судлах зорилгоор:

* 2013 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх тэтгэвэр тогтооход баримтлах сарын хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээ 1404000 төгрөгийг 1503800, 1600000, 1700000, 1800000, 1920000 төгрөгөөр өөрчлөх тооцооллыг;

* 2023 оны 06, 07, 08 сарын байдлаарх нийт тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө, дундаж тэтгэврийн хэмжээг;

Улсын их хурлын Хянан шалгах хороонд:

* Зарим ажил олгогчийн 2010-2023 оны хооронд ажилласан ажилтнуудын дэлгэрэнгүй мэдээллийг үндсэн ажил мэргэжлийн кодоор;

Үндэсний статистикийн хороонд:

* ҮСХ-ны даргын 2013 оны 1/158 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу 2022 оны 4-р улирал, 2022 оны бүтэн жил, 2023 оны 1, 2, 3-р улирлын байдлаарх ААНБ-ын ажилтны тоо, цалин хөлстэй холбоотой **34 хүснэгтэн мэдээллийг 5 удаа**;

* ҮСХ-ны даргын 2018 оны А/137 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу 2022 он болон 2023 оны эхний хагас жилийн нийгмийн даатгалын салбарын **23 хүснэгтэн мэдээллийг 2 удаа**;

Сангийн яаманд:

* 2022 оны 01 сараас 2023 оны 08 сарыг дуустал хугацааны ажил болон албан журмын даатгуулагчийн ажил мэргэжлийн ангилал, ажилласан жил, даатгуулагчийн төрөл, нас хүйс, цалингийн сан, шимтгэлийн дүн зэрэг томоохон мэдээллийг;

Эдийн засгийн хөгжлийн яаманд:

* Гадаадын хөрөнгө оруулалттай нийт 11.0 мянга гаруй ААНБ-ын 2018-2023 оны байдлаарх цалингийн сан, ногдуулсан шимтгэлийн дүн, монгол, гадаад даатгуулагчийн тоон мэдээллийг;

Үндэсний аудитын газарт:

* 2022 онд даатгуулсан албан журмын монгол даатгуулагчдын дэлгэрэнгүй мэдээллийг;

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт:

* 2021-2023 онд нийгмийн даатгалын үйлчилгээ авсан даатгуулагчдын тоон мэдээллийг үйлчилгээний төрөл /тэтгэвэр, ЖА, ажилгүйдлийн, оршуулгын, ХЧТА-ы болон ҮОМШӨ-ий тэтгэмж, СДД, ЭМД/-өөр **2 удаа**;

Дэлхийн банкинд:

* Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хуулийн дагуу 2022 оны 5-12 саруудын буцаан олголттой холбоотой 3 төрлийн мэдээллийг 17 үзүүлэлтээр;

Хөгжлийн банкинд:

* Жагсаалтаар ирүүлсэн 61 ААНБ-ын 2023 оны 1, 2-р улирлын байдлаарх салбарын тоо, төлсөн шимтгэлийн дүн, даатгуулагчийн тоог;

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимд:

* ТОП-100 ААНБ шалгаруулахтай холбогдуулан 2022 оны байдлаар хамгийн олон даатгуулагч, хамгийн өндөр шимтгэл төлсөн эхний 500 ажил олгогчийн мэдээллийг;

Хүний эрхийн үндэсний комисст:

* 2019-2022 оны байдлаар тэтгэвэр авагчдын мэдээллийг нийт 7 үзүүлэлтээр;

Авлигатай тэмцэх газарт:

* Зарим ААНБ-ын шимтгэл төлөлтийн мэдээллийг **18 удаа**;

ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн алба, Мөрдөн шалгах алба, Экологийн цагдаагийн алба зэрэг байгууллагуудад:

* Зарим ААНБ-ын шимтгэл төлөлтийн мэдээллийг нийтдээ **69 удаа**;

Шүүхийн байгууллагад:

* Зарим ААНБ-ын шимтгэл төлөлтийн мэдээллийг **7 удаа**;

*НДЕГ-ын газар, хэлтсүүдэд шаардлагатай мэдээллийг нийтдээ **73 удаа**.*

Төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр мэдээлэл солилцох ажлыг өргөжүүлж 7 сервис шинээр боловсруулан нэвтрүүлэв.

Иргэд даатгуулагч, ажил олгогч, төрийн болон бусад байгууллагуудад үзүүлэх нийгмийн даатгалын цахим үйлчилгээг өргөжүүлэн ХУР систем болон И-Монгол академи УТҮГ-т 7 сервис шинээр боловсруулан хүргүүлсэн. Үүнд:

Төрийн мэдээлэл солилцооны ХУР системд 3 сервис:

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас “Өрхийн нэгдсэн мэдээллийн сан” үүсгэхтэй холбогдуулан даатгуулагчийн цалин, тэтгэврийн мэдээллийн сервис;
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн санг үүсгэхтэй холбогдуулан аж ахуйн нэгж, байгууллагын даатгуулагчдын тоо болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоон мэдээллийн сервис;
3. Малчид тариаланчдад төрөөс олгох урамшуулалд зориулсан сайн дурын даатгалын гэрээний мэдээллийн сервис.

Мөн ХУР систем шинэчлэгдсэнтэй холбогдуулан уг шинэчилсэн хувилбараас иргэний бүртгэлийн мэдээллийг авч ашиглах боломжийг бүрдүүлэв.

И-Монгол академи УТҮГ-т / E-Mongolia портал/:

1. Иргэд даатгуулагч хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон актын батлагдсан маягтаар 22 төрлийн мэдээлэл агуулсан сервис;
2. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоосон актыг англи хэлээр авах сервис;
3. ЭХМК-ын хурлаар тогтоолт, сунгалт хийлгэсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэхний мэдээлэл дамжуулах сервис;
4. 2019-2023 онд дараалсан 6, 7 жилийн цалин хөлсний дунджаас тэтгэврээ тогтоолгосон тэтгэвэр авагч тэтгэврээ нэг удаа өөрчлөн тогтоолгох хүсэлтээ цахимаар илгээх сервис.

Иргэд, даатгуулагч, ажил олгогч, харилцагч байгууллагуудад тогтмол 24/7 цагийн горимоор мэдээллийг цахимаар хүргэв.

Төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн “ХУР” системээр дамжуулан иргэд даатгуулагч, ажил олгогчид цахимаар 24/7 цагийн горимоор нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүлээ. Цахим үйлчилгээг тоон үзүүлэлтээр дурдвал:

- **“Нийгмийн даатгал”** аппликейшнийг нийтдээ **270.0 мянга** орчим иргэн идэвхтэй ашиглаж 22 төрлийн үйлчилгээ, мэдээллийг цахимаар авсан байна.
- **“Даатгуулагчид зориулсан вэб”** системд **1.6 сая** орчим удаагийн хандалт хийж 29 төрлийн үйлчилгээг цахимаар авсан байна.
- Нийт **30.0 мянга** даатгуулагч сайн дураар даатгуулах гэрээ байгуулах, хугацаа сунгах, төлбөрөө төлөх үйлчилгээнд онлайнаар хамрагдав.
- Давхардсан тоогоор **93.5 мянган** ажил олгогч, **2.1 сая** даатгуулагч цахимаар хандан **QR кодтой** шимтгэл төлөлтийн тодорхойлолтоо авсан байна.
- Төрийн үйлчилгээний **109 ТҮЦ машинаас 114.7 мянган** даатгуулагч, ажил олгогч дөрвөн төрлийн лавлагаа, тодорхойлолтоо хэвлэн авсан байна.
- НДШ төлөлтийн лавлагаа тодорхойлолтын бодит байдлыг шалгах вэб системээр Элчин сайдын яамдууд, банк, санхүүгийн байгууллагаас **4.5 мянган** ажил олгогч, **34.5 мянган** даатгуулагчийн шимтгэл төлөлтийн QR кодтой тодорхойлолтыг шалгав.
- Идэвхтэй шимтгэл төлж буй **56.8 мянган** ажил олгогч сар бүрийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангаа 100% цахимаар, үүнээс 23% нь тоон гарын үсгээр баталгаажуулан илгээв.
- **“Шимтгэлийн цахим систем”-ээр 3.8 мянган** ажил олгогчийн **48.7 мянган** тушаалын мэдээллийг цахимаар хүлээн авав.
- Нийт **1218** эрүүл мэндийн байгууллагаас **174.9 мянган** даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны, **64.3 мянган** даатгуулагч жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн, нийт **239.2 мянган** эмнэлгийн хуудас цахимаар хүлээн авсан байна.
- **“Шимтгэлийн цахим систем”-ээр 16.7 мянган** ажил олгогч **144.0 мянган** даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн тооцооллыг хийж цахимаар илгээсэн байна.
- Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болсон **1.6 мянган** даатгуулагч ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авах хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад цахимаар илгээв.
- Төрийн цахим үйлчилгээний **E-MONGOLIA** нэгдсэн порталаар нийгмийн даатгалын 16 төрлийн үйлчилгээг цахимаар үзүүлж байгаа бөгөөд үүнээс 5 лавлагаа тодорхойлолт нь англи хувилбараар гарч байна. Энэ онд уг порталаас давхардсан тоогоор нийтдээ **7613.1 мянган** лавлагаа тодорхойлолтыг цахимаар авсан ба үүнээс нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолтыг **6878.1 мянган** удаа авсан нь хамгийн их цахимаар авсан үйлчилгээ болсон байна.
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолоор баталсан "Нээлттэй өгөгдлийн жагсаалт", Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоолоор баталсан "Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам"-ын дагуу 2022 оны 4, 2023 оны 1, 2, 3 дугаар улирлын 16 нэр төрлийн нээлттэй мэдээллийг тус бүр дөрвөн форматаар хувирган ЗГХЭГ-ын www.opendata.gov.mn болон НДЕГ-ын www.ndaatgal.mn веб сайтуудад цаг тухай бүрд нь байршуулж нийтэд мэдээлэв.

[Даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2022 оны жилийн эцсийн үлдэгдлийн тооцооллыг хийв.](#)

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн “Нэрийн дансны 2022 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай” 2022 оны 07 тоот тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн нийт 1588.3 мянган даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2022 оны жилийн эцсийн байдлаарх үлдэгдлийн тооцооллыг хийсэн.

Даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2022 оны эцсийн үлдэгдлийн мэдээллийг “Даатгуулагчид зориулсан вэб”, E-Mongolia нэгдсэн портал, “Нийгмийн даатгал” аппликейшн, ТҮЦ машин зэрэг сувгуудаар цахимаар харах, файлаар татах, хэвлэн авах нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн байцаагч ажилтнууд //10.9.0.5/ndans вэб системээр даатгуулагчийн ТДШНД-ны мэдээллийг харах, хянах, хэвлэн өгөх боломжийг бүрдүүлсэн.

Мэдээллийн шинэчилсэн системийг үе шаттайгаар
нэвтрүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллав.

- Нэгдсэн өгөгдлийн сангийн архитектурын дэд бүтцийг тодорхойлон, түүний дагуу сервер компьютерт холбогдох програм хангамжуудыг суулган тохиргоо хийх ажлыг гүйцэтгэгч байгууллагатай хамтран хийв.
- Салбарын хэмжээнд одоо байгаа мэдээллийн санг шинэчилсэн системд хөрвүүлэх загварчлалыг боловсруулан түүний дагуу нийт ажил олгогч, даатгуулагчийн цалин, шимтгэл төлөлт, тэтгэвэр, тэтгэмжийн мэдээллийн санг хөрвүүлэн оруулах, тохируулга хийх ажлыг гүйцэтгэгч байгууллагатай хамтран хийсэн.
- Мэдээллийн шинэчилсэн цогц CORE системийг нэвтрүүлэх бэлтгэл ажлын иргэд даатгуулагчдад үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ тус бүрээр системд шалгалт хийх, тестлэх ажлыг гүйцэтгэхээр удирдах байгууллагаас байгуулсан “Ажлын хэсэг”-т Төвийн холбогдох ажилтнууд тогтмол ажиллан гүйцэтгэгч байгууллагатай 22 удаа, дотооддоо 20 гаруй удаагийн уулзалт зохион байгуулж, ажил олгогч болон даатгуулагч хандах портал системүүд, мөн 6 дэд систем, 10 гаруй бүтээгдэхүүн үйлчилгээний програмчлалын явцыг үйлдэл, цэс, цонх тус бүрээр тестлэн сайжруулалтын талаарх саналаа гүйцэтгэгч байгууллагад өгч шаардлагатай хөгжүүлэлтийг хийлгэсэн. Мөн тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээнд хуулийн дагуу тавигдах болзол нөхцөл, томъёоллыг шалгах 2.0 мянга гаруй шалгуур үзүүлэлтийг боловсруулан гүйцэтгэгч байгууллагад хүргүүлж, түүний дагуу 540 орчим кейсийг тестлэн шалгуур хангаж буй эсэхэд хяналт тавьж ажиллав.

Түүнчлэн мэдээллийн шинэчилсэн цогц системд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжих Нийгмийн даатгалын багц хуулийн 100 гаруй заалтын дагуу хийгдэх 300 орчим өөрчлөлт, мөн ажил олгогч болон даатгуулагчтай холбоотой ХУР систем рүү гаргах 50 гаруй сервисийн хөгжүүлэлтийг гүйцэтгэгч байгууллагатай хамтран хийж байна.

Салбарын байгууллагуудын сүлжээ, компьютер, техник хангамжийн
хэвийн ажиллагааг ханган ажиллав.

- Төв орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагуудаас ирүүлсэн 50 гаруй ажлын болон зөөврийн компьютер, 15 хэвлэгч, хувилагч, 10 гаруй дэлгэц, скайнер зэрэг нийтдээ 80 орчим техник хангамжийг оношлон шаардлагатай сэлбэг солих, электроникийн засвар хийх, үйлдлийн систем болон бусад програм хангамжуудыг суулгах, тохиргоо хийх ажлуудыг биечлэн болон зайнаас гүйцэтгэж хэвийн ажиллах нөхцөлөөр ханган ажиллав.
- Төв орон нутгийн хоёр нэгжийн ажлын байршил өөрчлөгдсөнтэй холбогдуулан шилэн кабелийн холболтыг шилжүүлэн нүүлгэх ажлыг харилцагч байгууллагатай хамтран шуурхай хийж хэвийн ажиллагааг ханган ажиллав.
- Сумдын нийгмийн даатгалын байцаагчийг цахимаар ажиллах нөхцөлийг хангах зориулалтаар сарын 60GB эрхтэй 100 ширхэг хөдөлгөөнт интернэтийн төхөөрөмжийг нэгжүүдэд хуваарилан өгч ашиглах боломжоор хангав.

6. БАЙГУУЛЛАГЫН СУРГАЛТ, ОЛОН НИЙТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА


6.1. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

Нийгмийн даатгалын ерөнхий газар нь 2023 оныг “Нийгмийн даатгалын шинэчлэлийн жил” болгон зарласантай холбоотой нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн даатгалын ач холбогдлын талаар сургалт зохион байгуулах ажлын чиглэлийг салбарын нийт хэлтсүүдэд тухай бүр хүргүүлэн ажиллав. Үүнд:


- Нийгмийн даатгалын байгууллагын 2023 онд сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах ажлын чиглэл боловсруулж 8/120 дугаар албан бичгээр, Хяналт шалгалтын байцаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт, Архив, бичиг хэрэг, хүний нөөц хариуцсан албан хаагчдын сургалтад оролцуулах тухай чиглэл, удирдамжийг 06/600, 02/727 дугаар албан бичгээр болон байгууллагын дотоод “Зар мэдээ”-нд, цахим сургалтын

www.surgalt.ndaatgal.mn системийг ашиглах зөвлөмж, чиглэлийг Тамгын газартай хамтран 01/913 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэв.

- Аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс (газар)-ын 2023 оны сургалт, сурталчилгааны төлөвлөгөөг нэгтгэн НДЕГ-ын 2023 оны сургалтын төлөвлөгөө (3 зорилт, 22 арга хэмжээ), нийгмийн даатгалын байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөнд сургалтын чиглэлээр хийх ажлын санал, авлигын эсрэг төлөвлөгөө, мэдээллийн цагийн хуваарийг боловсруулав.
- Сургалтын танхимыг тохижуулах, сургалт зохион байгуулах, хамтран ажиллах санал, тоног төхөөрөмж, барааны судалгааг гаргаж НДЕГ-ын даргад танилцуулсан.
- БНСУ-ын КОЙКА Олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалт зохион байгуулж, хамтран ажиллах саналын төслийг боловсруулж КОЙКА Олон улсын хамтын ажиллагааны байгууллагад хүргүүлсэн.
- Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдын 2023 оны сургалтын хэрэгцээний судалгааг нийт 491 байцаагч, албан хаагчийг хамруулсан. Судалгааны дүнгээр оролцогчдын 56,7% танхимын сургалт үр дүнтэй, 90% нь сургалтын агуулга, багшийн ур чадвар хамгийн чухал, 63,9% цаашид өөрийн гүйцэтгэж буй ажилтай холбоотой нийгмийн даатгалын хууль тогтоомжийн мэдлэг чадвараа дээшлүүлэх сургалтад хамрагдах хүсэлтэй байгаа талаар хариулт өгөв.
- “Хяналт шалгалтын байцаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт”, “Архив, бичиг хэрэг, хүний нөөц хариуцсан албан хаагчдыг чадавхжуулах сургалт”-ын оролцогчдоос сургалтын дараах үнэлгээг цахимаар авч дүнг боловсруулсан. Судалгаанд оролцогчдын 80-90% сургалтыг сайн гэж үнэлсэн бөгөөд дараагийн сургалтын агуулга, анхаарах асуудлын талаар нээлттэй хариулт өгөв.



- “Архив, бичиг хэрэг, хүний нөөц хариуцсан албан хаагчдын сургалт”-ын үнэлгээг цахимаар авч дүнг нэгтгэхэд 39 албан хаагч хамрагдсан. Сургалтын агуулга, зохион байгуулалтыг оролцогчдын 74,4% онц, 25,6% сайн гэж үнэлсэн бол 84,6% тухайн сургалт эрхэлсэн ажлын хүрээнд чухал шаардлагатай байсан, 80% Эрдэнэгэрэл, Цэндсүрэн багш нарыг хамгийн сайн сургагч багш, мөн 61,5% нь архив албан хэрэг хөтлөлтийн сургалтад дахин хамрагдах хүсэлтэй, 66,7% цаашид сургалтыг танхимаар, 17,9% ажлын байр дээр, 15,4% цахимаар зохион байгуулах нь үр дүнтэй гэж хариулсан.
- Монгол хэлний тухай хууль, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж төрийн албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэл ажлын хүрээнд нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдын монгол бичгийн мэдлэгийн түвшинг тогтоох сорилыг Хэлний бодлогын үндэсний зөвлөлтэй



хамтран 2023 оны 04 дүгээр сарын 24-нд цахимаар авч, салбарын 329 албан хаагч хамрагдав. Сорилын дүнгээр оролцогчдын 44,5% 31-40 нас, 32% 41-50, 15,3% 19-30, 7,9% 50 аас дээш насны албан хаагч байна. Дундаж үзүүлэлт “18” оноо буюу нийт оролцогчдын 60% нь 18 ба түүнээс дээш оноо авсан.

Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, ажилтнуудыг сургаж хөгжүүлэх зорилтын хүрээнд:

Тайлант хугацаанд салбарын хэмжээнд албан хаагчдыг чадавхижуулах, ур чадварыг дээшлүүлэх **774** удаагийн сургалтад **15918** албан (давхардсан тоогоор) хаагчийг хамруулав. (Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдыг чадавхижуулах сургалт зохион байгуулсан тоо, хамрагдсан хүний тоог 2023 оны жилийн эцсийн тайлангийн дүнгээс нэгтгэн харуулбал)

Хүснэгт -9


Байгууллагын нэр	Тоон дүн	
	Зохион байгуулсан сургалтын тоо	Сургалтад хамрагдсан ажилтны тоо
Архангай аймгийн НДХ	25	635
Баян-Өлгий аймгийн НДХ	15	22
Баянхонгор аймгийн НДХ	8	233
Булган аймгийн НДХ	13	114
Говь-Алтай аймгийн НДХ	17	355
Говьсүмбэр аймгийн НДХ	10	126
Дархан-Уул аймгийн НДХ	28	905
Дорнод аймгийн НДХ	16	336
Дорноговь аймгийн НДХ	25	361
Дундговь аймгийн НДХ	10	32
Завхан аймгийн НДХ	23	599
Орхон аймгийн НДХ	50	1147
Өвөрхангай аймгийн НДХ	55	937
Өмнөговь аймгийн НДХ	25	427
Сүхбаатар аймгийн НДХ	24	34
Сэлэнгэ аймгийн НДХ	53	194
Төв аймгийн НДХ	9	136
Увс аймгийн НДХ	22	528
Ховд аймгийн НДХ	13	319
Хэнтий аймгийн НДХ	45	1185
Хөвсгөл аймгийн НДХ	11	187
Баянгол дүүргийн НДХ	9	439
Баянзүрх дүүргийн НДХ	47	752
Чингэлтэй дүүргийн НДХ	25	532
Хан-уул дүүргийн НДХ	29	360
Сүхбаатар дүүргийн НДХ	9	389
Сонгинохайхан дүүргийн НДХ	40	809
Багахангай дүүргийн НДХ	7	207
Багануур дүүргийн НДХ	33	277
Налайх дүүргийн НДХ	20	225
Нийслэлийн НДГ	22	360
НДЕГ	36	2756
Нийт	774	15918

Үүнээс: НДЕГ-аас 21 удаагийн сургалтаар 964 (давхардсан тоогоор) албан хаагчийг сургалтад хамруулсан. Тухайлбал:

Үүнээс тус газар 36 удаагийн сургалт зохион байгуулж 2756 албан хаагчийг хамруулав. Тухайлбал:

- Албан хаагчдын гадаад хэлний мэдлэг дээшлүүлэх сургалт;
- Хяналт шалгалтын байцаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд;
- Нийгмийн даатгалын тухай хууль зөрчих зөрчлийг шалгахад анхаарах асуудал, Шүүхэд нэхэмжлэл гаргах тухай;
- Авлига, ашиг сонирхлын зөрчил түүнээс урьдчилан сэргийлэх нь;
- Архив, бичиг хэрэг, хүний нөөц хариуцсан албан хаагчдыг чадавхжуулах сургалт
- Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал сургалт;
- Монгол бичгийн түвшин тогтоох сорил;
- Нийгмийн даатгалын салбар дахь санхүүгийн дүн шинжилгээний практик ур чадварыг бэхжүүлэх нь;
- Дундговь, Ховд, Булган аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн албан хаагчдыг чадавхижуулах сургалт;
- Үндсэн хуульд өөрчлөлт оруулах талаарх танилцуулга, хэлэлцүүлэг;
- "Алсын хараа 2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь";
- Төрийн албаны зөвлөлийн вебинар сургалт (21 удаа)
- Байгууллагын мэдээллийн цаг 12 удаа
- Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн танилцуулах бүсчилсэн сургалт;
- Сургагч багшийн сургалт;
- Монгол бичгийн анхан шатны цахим сургалт;
- Гүйцэтгэлийн тайлан төлөвлөгөө боловсруулах арга зүй сэдэвт сургалт зэрэг болно.

Зураг-16



Мөн байгууллагын мэдээллийн цагаар;

- Аялал гэж юу вэ, Жуулчлал гэж юу вэ, Аялалаас олж авах танин мэдэхүй, Аялалын хувцас, хоол хүнсний сонголт, хадгалалт, хамгаалалт, анхаарах зүйл, Байгальтай

харилцах ухаан ба байгаль хамгаалал, Аялал жуулчлалд таны болон таны байгууллагын оролцоо

- Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх нь, гал түймэр гарсан тохиолдолд авах арга хэмжээ, анхаарал асуудал
- Антиоксидант, түүний ач холбогдол
- Дугуй унахын ач холбогдол, дугуйн хэрэглээг нэмэгдүүлэх нь зэрэг сэдвээр албан хаагчдад мэдээлэл өгсөн.

Дээрх сургалтаас онцолвол нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн талаар төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагын байцаагч, албан хаагчдад нэгдсэн ойлголт өгч, сургах, чадавхижуулах, ажил олгогч даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаар мэдээлэл, танилцуулга хийх сургалтыг 2023 оны 9 дүгээр сарын 13-наас 10 дугаар сарын 27-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулав.

Сургалтыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгчийн А/115 дугаар тушаалын дагуу сургалтад хамрагдаж сургагч багшийн эрх авсан ХНХЯ, НДЕГ-ын 36 сургагч багш батлагдсан удирдамж, хуваарийн дагуу, Дэлхийн банкны Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн санхүүжилтээр нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд явуулж, нийт **1195** албан хаагч, **4740** Ажил олгогч байгууллагын **6726** даатгуулагчийг хамруулав.

Зураг-17



Төрийн албаны зөвлөлийн Пүрэв гараг бүрийн 7:4:10 вебинар сургалтын мэдээллийг Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдад хүргэсэн. (14 удаа)

- “Авлигаас урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал” “Албан тушаалтны 2022 оны ХАСХОМ гаргах тухай” сэдвээр Авлигатай тэмцэх газрын ахлах комиссар Л.Нарантуяа, Ц.Баасандэлгэр;
- “Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны эрх зүйн орчин” сэдвээр Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн эрхлэгч доктор (Ph.D) А.Алтанзул
- “Төрийн албан хаагч” сэдвээр ЗГХЭГ-ын Дэд дарга Д.Батбаатар;
- “Манлайлал” сэдвээр Сургалт, судалгааны “Полиси” төвийн захирал Г.Эрдэнэгэрэл;
- “Төрийн албаны шинэтгэл, сонгон шалгаруулалтын зохицуулалт” сэдвээр Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан;
- “Үндсэн хуулийн үзэл баримтлал” сэдвээр МУИС-ийн багш, доктор Б.Гүнбилэг;
- “Стрессийг зохицуулахад таны оролцоо” сэдвээр СЭМҮТ-ийн Тандалт судалгааны албаны дарга, АУ-ын доктор Т.Ганцэцэг;
- “Цахим шилжилт” сэдвээр Санхүү эдийн засгийн их сургуулийн ахлах багш, доктор Д.Отгонболд;

- “Бүтээмжээ нэмэгдүүлэх нь” сэдвээр “Грандбук паблишинг” компанийн захирал Д.Гэрэлмаа;
- “Өсөлтийн сэтгэлгээ” сэдвээр Хуульч, “Хан голомт” группийн захирал, Ц.Азбаяр;
- “Чингис хаан Монголчуудын үнэт зүйл болох нь” сэдвээр Академич, Чингис хаан музейн захирал С.Чулуун;
- “Зөөлөн менежмент” сэдвээр “Дижитал воркс систем”-ийн шинжээч А.Ганбаатар;
- “Төрийн чадамжийг бүрдүүлэх нь” сэдвээр Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төвийн гүйцэтгэх захирал Б.Дөлгөөн

Ажил олгогч, даатгуулагчийн нийгмийн даатгалын хууль тогтоомжийн ойлголтыг дээшлүүлэх” зорилтын хүрээнд:

Ажил олгогч, иргэд даатгуулагчид чиглэсэн 586 удаагийн танхимын болон цахим сургалтад 49,172 иргэд, даатгуулагчийг хамруулах ажлыг зохион байгуулав.

Нийгмийн даатгалын (газар) хэлтсийн 2023 оны жилийн эцсийн тайлангийн дүнгээс сургалтад хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо, зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоог нэгтгэн харуулбал:

Хүснэгт -10

Байгууллагын нэр	Тоон дүн	
	Зохион байгуулсан сургалтын тоо	Сургалтад хамрагдсан ажилтны тоо
Архангай аймгийн НДХ	52	3362
Баян-Өлгий аймгийн НДХ	9	3269
Баянхонгор аймгийн НДХ	64	16236
Булган аймгийн НДХ	120	2966
Говь-Алтай аймгийн НДХ	10	7840
Говьсүмбэр аймгийн НДХ	12	1193
Дархан-Уул аймгийн НДХ	22	2419
Дорнод аймгийн НДХ	22	1603
Дорноговь аймгийн НДХ	112	8194
Дундговь аймгийн НДХ	51	4160
Завхан аймгийн НДХ	104	57209
Орхон аймгийн НДХ	136	4621
Өвөрхангай аймгийн НДХ	284	4974
Өмнөговь аймгийн НДХ	51	3953
Сүхбаатар аймгийн НДХ	73	2538
Сэлэнгэ аймгийн НДХ	65	3002
Төв аймгийн НДХ	90	7610
Увс аймгийн НДХ	449	30907
Ховд аймгийн НДХ	14	751
Хэнтий аймгийн НДХ	287	17360
Хөвсгөл аймгийн НДХ	8	6835
БГД-ийн НДХ	16	1739
БЗД-ийн НДХ	37	7889
БХД-ийн НДХ	36	5458
БНД-ийн НДХ	23	4599
СБД-ийн НДХ	22	3030
ХУД-ийн НДХ	25	2999
ЧД-ийн НДХ	6	531
НД-ийн НДХ	8	577
СХД-ийн НДХ	8	754
Нийслэлийн НДГ	34	589

НДЕГ	16	1718
Нийт	2266	220885

Үүнээс тус газар 16 удаагийн нийгмийн даатгалын хууль тогтоомжийн сургалтад 1718 иргэд даатгуулагчийг хамруулав. Тухайлбал:

- Монголын үйлвэрчний эвлэлийн гишүүн байгууллагууд
- МҮХАҮТ-ийн гишүүн байгууллагууд
- Цагдаагийн Ерөнхий газар
- Монгол улсын дотоод хэргийн их сургууль
- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтнууд
- Шүүх шинжилгээний ерөнхий газар
- Онцгой байдлын ерөнхий газар
- Төрийн сангийн хэлтсийн харъяа орон нутгийн өмчит байгууллага, төсөвт байгууллагын нягтлан бодогч нар
- Улсын бүртгэлийн ерөнхий газар
- Оюуны өмчийн газар
- Гадаадын иргэн харьяатын газар
- Соёл урлагийн салбарын ажилтнууд, чөлөөт уран бүтээлчид
- Архивын ерөнхий газар
- Дулааны 3 цахилгаан станц ТӨХК
- Эм Си Эс Групп
- Номин холдинг Групп
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар.

Зураг-18




Түүнчлэн салбарын хэмжээнд 240 удаагийн явуулын үйлчилгээнд 71032 иргэд даатгуулагч, 122 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөгт 18852, нийт **362** удаагийн арга хэмжээнд **89844** иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав.

Зураг-19



6.2. ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХҮРЭЭНД

Иргэд, даатгуулагчид, ажил олгогчид, харилцагч талуудад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах, зөвлөгөө, мэдээллийг тогтмол ойлгомжтой байдлаар хүргэх зорилгоор гарын авлага, сурталчилгааны хуудсыг олон нийтийн сүлжээ, цахим хуудас, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран түгээж ажиллав. Тус газрын @sigomongolia сошиал хуудас нь **137,427** дагагчтай бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дагагч **18** хувиар нэмэгдсэн байна.




Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээ, цаг үеийн мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудас болон @sigomongolia сошиал **8** хөдөлгөөнт постер, **44** постер мэдээлэл, **13** аудио, видео шторк,. Мөн **69** цаг үеийн буюу нийт **136** удаагийн мэдээллийг бэлтгэн түгээсэн бөгөөд давхардсан тоогоор **3.5** сая хүнд хүрсэн Үүнд:

- 2024.01.01 -ний өдрөөс хэрэгжиж эхлэх нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн постер хэлбэрээр бэлтгэн 7 хоног тутам байгууллагын цахим болон сошиал хуудсаар нийтэлж байна. Тайлант хугацаанд сошиал хуудсанд байршуулсан “Тэтгэвэр

тогтоолгосон 6 эсхүл 7 жилийн дундаж цалинг 5 жилийн дундаж цалингаар өөрчлөх хүсэлтээ дээрх линкээр илгээнэ үү”, “5 жилийн цалингаар тэтгэврийг өөрчлөхөд хэмжээ нь буурахаар бол тэтгэврийг хэвээр олгоно”, “Хэрэв та 2023.07.01-нээс өмнө тэтгэврээ тогтоолгосон бол 5 жилийн цалингаас тэтгэврийг өөрчлөн тогтоохдоо итгэлцүүр хэрэглэн, 10%-ийн нэмэгдэл тооцно” талаарх 3 постер мэдээлэл **801,473** хүнд хүрч, **694,737** хүн үзэж, **4,814** удаа цааш түгээсэн байна.

Зураг-20



- Нийгмийн даатгалын байгууллагын танилцуулга, Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга гарын авлагыг **7500** ширхэг хэвлэн, хэвлэмэл болон цахим хэлбэрээр түгээсэн.

- Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын агуулга бүхий аудио, видео шторк мэдээллийг түгээсэн нь **66,697** хүнд хүрч **24,500** хүн үзэж, **960** удаа цааш түгээсэн байна.

Нийгмийн даатгалын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хүрээнд:

Нийгмийн даатгалын үйлчилгээний хүртээмж, үйл ажиллагааг сайжруулах замаар олон нийтэд нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагааг шуурхай, чирэгдэлгүй, ил тод, нээлттэйгээр хүргэх хүрээнд дараах ажлыг зохион байгуулав. Үүнд:

- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооноос хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 550,000 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон болон нийгмийн даатгалын хууль тогтоомжийн өөрчлөлттэй холбоотойгоор @sigomongolia хуудасны чатбот болон байгууллагын вебсайт (www.ndaatgal.mn)-ын “нийгмийн даатгалын үйлчилгээ” болон “хууль эрх зүй” цэсний мэдээллийг тус тус шинэчлэв.
- Нийгмийн даатгалын хэлтсийн лавлах утасны үйл ажиллагаанд хийсэн судалгаанд үндэслэн Нийгмийн даатгалын хэлтсийн лавлах утасны үйл ажиллагааг сайжруулах зөвлөмжийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 01/583 тоот албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэв.
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолоор баталсан “НДЕГ-ын нээлттэй өгөгдлийн жагсаалт”-д заасан нээлттэй мэдээллийг байгууллагын www.ndaatgal.mn цахим хуудас болон холбогдох мэдээллийн сувагт Дотоод аудит, мониторингийн газар, Мэдээллийн технологийн төв, бусад зохион байгуулалтын нэгжүүдтэй хамтран байршуулсан болон Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын дагуу хийсэн үнэлгээний тайланг 2023.04.24-ний өдөр 01/831 дугаар албан бичгээр Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлэв. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дахь хэсэгт заасан **68** төрлийн чиг үүрэгт хамаарах мэдээллийг www.ndaatgal.mn цахим хуудсанд байршуулав.
- Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Засгийн газраас 2023 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарлаж төрийн мэдээллийг нээлттэй, ил тод болгох, цахимжилтыг эрчимжүүлэх, хүнд суртлыг арилгах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 01/1132 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн цахим хуудсыг шинэчлэх, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан **48** мэдээллийг цахим хуудсанд байршуулах, мэдээллийн самбарыг шинэчлэх талаар зөвлөмж хүргүүлэв.
- Тайлант хугацаанд тус Газрын “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарын нийгмийн даатгалын цахим үйлчилгээ, сурталчилгаа, ил тод байдал хэсгийн мэдээллийг тус тус шинэчлэв.
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын нэг цэгийн үйлчилгээний танхимд байршуулсан мэдээллийн самбарын мэдээллийг шинэчлэв.
- Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэгт хамаарах нээлттэй мэдээллийг олон нийтэд хүргэх, тэдний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор “Нээлттэй мэдээллийг цахим хуудсанд байршуулах хуваарь”, “Нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/66 дугаар тушаалаар батлуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийт газар, хэлтсүүдэд хүргүүлэв.

Хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцах чиглэлээр:

2023 оны жилийн эцсийн байдлаар zaag.mn, neguun.mn, zarig.mn, zindaa.mn, focus.mn, tovch.mn, breakingnews.mn, ireport.mn, tug.mn, zaag.mn, erennews.mn, ulsturch.mn, ikon.mn, ubpost.mn, mpress.mn, eguur.mn, ikon.mn, dardas.mn, mnb.mn, itoim.mn, today.mn, report.mn вебсайт, сошиал хуудас, Өглөөний сонин, Өдрийн сонин, Өнөөдөр сонин, зууны мэдээ, Mongol HD, TV8, Тэнгэр тв, TV9, UBS, Etv, Ntv, МҮОНРТ-ийн ММ Агентлаг, C1, Parliament, MN25, Eagle TV, Монголын сэтгүүлчдийн холбоо, арилжааны телевизүүдийн холбоо зэрэг 86 хэвлэл мэдээллийн байгууллагаар /давхардсан тоогоор/ 589 удаа /давхардсан тоогоор/ нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийг иргэд даатгуулагчдад хүргэж, хэвлэл мэдээллийн байгууллагыг эх сурвалж, мэдээллээр ханган ажиллав.

7. БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨВИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТАСАГ

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, Монгол Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газар, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн алба хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичиг, бусад холбогдох хууль тогтоомжуудыг тус тус хэрэгжүүлэн дараах үйл ажиллагааг явуулав.

7.1. БНСУ-Д ОРШИН СУУЖ БУЙ МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭД МОНГОЛ УЛСЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖУУДЫГ СУРТАЛЧЛАН ТАНИУЛЖ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

БНСУ-ын Хууль зүйн яамны харьяа Гадаадын иргэн, харьяатын газраас 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар гаргасан статистик мэдээгээр БНСУ-д Монгол Улсын 51,595 иргэн оршин сууж байна.

Үүнээс хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн тоо 4,186, байнгын оршин суугч 760, оршин суугч 1,197, оюутан 7,931, хэлний бэлтгэлд суралцагч 5,874, солонгос иргэнтэй гэр бүл болсон 2,023, гэр бүлийн визтэй 3,917 түр хугацааны буюу аялалын визтэй иргэд 17,817 байгаагаар тус тус бүртгэгдсэн байна.

Иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжийн тухай сургалт, сурталчилгаа хийх, явуулын үйлчилгээ зохион байгуулах

2023 оны байдлаар тус тасаг БНСУ-д ажиллаж, амьдарч буй иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын тэтгэврийн болон сайн дурын даатгалд хамруулах, иргэдэд нийгмийн даатгалын ашиг тусыг ойлгуулах, хуулийн өөрчлөлтүүдийг зөв мэдээлэх, шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор дараах сургалт, сурталчилгааны ажлууд болон явуулын үйлчилгээг зохион байгуулан амжилттай ажиллалаа. Үүнд:

Олон нийтийн сүлжээ, сошиал орчин болон цахим хэлбэрээр нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулах

Төвийн БНСУ дахь “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” цахим хуудас болон <https://seoulcenter.mlsp.gov.mn> сайтуудад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалд хэрхэн хамрагдах тухай нийт давхардсан тоогоор 48 удаагийн мэдээ, мэдээлэл нийтлүүлэв.

Мөн БНСУ-д ашиглагдаж буй Монголчуудын нэгдсэн цахим хуудсуудад /Нүүдэлчин Монголчууд, Гэрээнийхэн наашаа Е-9, Солонгос дахь эмэгтэйчүүд, Гэрээний залуусын нэгдэл Е9-өөс Е7 зэрэг/ нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийн талаар тогтмол мэдээ, мэдээлэл нийтэлж, иргэд, даатгуулагчдад сурталчлав. Жишээлбэл: Төвийн цахим хуудаснаа 11 дүгээр сарын 06-ны өдөр нийтлэгдсэн “Солонгос улсад байгаа Монгол иргэд сайн дурын даатгалд хэрхэн хамрагдах вэ?” гэсэн сурталчилгааны богино хэмжээний шторкийг давхардсан тоогоор 917 иргэн үзсэн байна.

2023 оны 05 дугаар сарын 21, 10 дугаар сарын 29-нд НДЕГ-аас уламжлал болгон зохион байгуулдаг хилийн чанадад суугаа Монгол Улсын иргэдэд “Нийгмийн хамгааллын салбарт

хамтран ажиллах тухай хэлэлцээр”, “Нийгмийн даатгалын ач холбогдол, сайн дурын даатгалд хамрагдах нь” сэдэвт 2 удаагийн цахим сургалтуудад тус тасгаас “БНСУ дахь Нийгмийн даатгалын үйлчилгээ” сэдвээр нийт 64 иргэн, даатгуулагчид танилцуулга хийж, сонирхсон асуултанд хариулан оролцов.

2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр БНСУ-д ажиллаж буй хөдөлмөрийн гэрээний ажилчдын дунд “Гэрээний залуусын нэгдэл” ТББ-аас анх удаа зохион байгуулсан “Анхдугаар чуулга уулзалт”-д тус тасгаас “Нийгмийн даатгалын ач холбогдол” сэдвээр илтгэл тавьж, оролцогчдод нийгмийн даатгалын хууль тогтоомжийн тухай мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллав.

2023 оны байдлаар БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр нийт 683 иргэн ирсэн. Дээрх иргэдийг БНСУ-д ирэхээс өмнө ХХҮЕГ-аас тус төвтэй хамтран ирэхийн өмнөх сургалтыг онлайн хэлбэрээр нийт 13 удаа зохион байгуулсан бөгөөд уг сургалтаар нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулж, Солонгос улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын нийгмийн даатгалын онцлогийн тухай мэдээ, мэдээллээр хангаж ажилласан. Уг сургалтын нэг үр дүн нь тус тасаг тайлант хугацаанд албан журмын даатгалд нийт 383 иргэнийг шинээр хамруулан гэрээ байгуулан ажиллаж байна.

- *Нийгмийн даатгалын “Явуулын үйлчилгээ” үзүүлж, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулах*

2023 онд тус тасгаас нийт 14 удаагийн “Явуулын үйлчилгээ”-г иргэд, даатгуулагчдад үзүүлж ажилласан ба 6 удаа орон нутагт, 8 удаа БНСУ-ын Сөүл хот дахь МУ-ын Консулын хэлтсийн байранд зохион байгуулсан. Үүнд: БНСУ-ын Мугпу, Тэгү, Чэжү, Гуанжү, Сөүл хотуудад тус тасгаас явуулын үйлчилгээг зохион байгуулсан бөгөөд нийт 240 гаруй иргэн даатгуулагчид нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулж, мэдээ мэдээлэл өгч ажиллав.

Иргэд, даатгуулагчид болон ажил олгогчдод нийгмийн даатгалын талаар ажлын байран дээр мэдээлэл, заавар, зөвлөгөө өгөх

Нийгмийн даатгалын талаар мэдээлэл авахыг хүссэн иргэд, даатгуулагч, ажил олгогчдод утсаар болон биечлэн мэдээлэл, заавар, зөвлөгөө өгч ажиллалаа.

Тайлант хугацаанд нийт давхардсан тоогоор 12,873, үүнээс 12,614 иргэн, даатгуулагч, ажил олгогчид утсаар, 259 иргэн, даатгуулагчид биечлэн Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах талаар болон бусад мэдээлэл, заавар, зөвлөгөө өгч, сурталчилгааны материал тараан ажиллав. Үүнд:

Даатгалд шинээр хамрагдах 934, даатгалын гэрээ сунгах 620, гэрчилгээ дахин авах 140, шимтгэлийн төлөлт шалгуулах 1,029, нэхэмжлэл, шимтгэл төлсөн баримт авах 569, буцаан олголтын тухай 69, БНСУ-ын УТА-д шимтгэл төлөх хүсэлтээ илэрхийлж, тодруулга авах тухай 294, нийгмийн даатгалын хууль тогтоомж, тэтгэвэр тэтгэмж болон бусад мэдээллийн талаар 1,208 иргэн, даатгуулагч, ажил олгогчид мэдээлэл, заавар, зөвлөгөө өгсөн байна.

7.2. БНСУ-Д ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛЛАЖ БУЙ ИРГЭДИЙГ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛД АЛБАН ЖУРМААР ХАМРУУЛАХ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БНСУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ДАГУУ МОНГОЛ УЛСЫН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛД ДААТГУУЛСАН ГЭРЧИЛГЭЭ БИЧИЖ ОЛГОХ АЖЛЫН ХҮРЭЭНД

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийн нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд бүртгүүлсэн байдал, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийг Нийгмийн даатгалын тухай хуулийн 04 дүгээр зүйлийн 02 дахь хэсгийн 04 дэх заалтын дагуу Монгол Улсын нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулан ажиллав.

Тус тасаг үүсгэн байгуулагдсан 2007 оны 03 дугаар сараас хойш БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирсэн иргэдийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд хамруулж, “Солонгос

Улсад гэрээгээр ажиллагсдын шимтгэлийн программ /<https://app.ndaatgal.mn:811/ndweb/> буюу мэдээллийн санд бүртгэн нийт 23,918 /давхардсан тоогоор/ даатгуулагчийн бүртгэлийг хийв.

Тэтгэврийн даатгалд даатгуулсан, мэдээллийн санд бүртгэлтэй нийт 23,938 даатгуулагчийг шилжилт хөдөлгөөнөөр ангилбал одоо ажиллаж байгаа 2,398, холбоо барих боломжгүй 112, хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусаж, нутаг буцсан 21,428 даатгуулагч байгаагаар бүртгэгдсэн байна. Тайлант хугацаанд мэдээллийн санд давхардсан тоогоор нийт 325 даатгуулагчийн шилжилт хөдөлгөөн болон мэдээлэлд өөрчлөлт хийсэн байна.

Тэтгэврийн даатгалд даатгуулагчдын программ дахь мэдээллийг мэргэжилтэн тус бүрээр харуулбал:


Хүснэгт-11

№	Мэргэжилтний нэр	Нийт даатгуулагчдын тоо	Ажиллаж буй даатгуулагчид	Нутаг буцсан	Оршин суух хугацаа хэтэрсэн
1	Л.АЗЗАЯА	592	444	147	1
2	Ц.БЯМБАА	1,085	510	574	1
3	О.ДАВААЖАВ	586	331	253	2
4	Г.ДОЛГОРМАА	470	282	183	5
5	Л.ДОРЖСҮРЭН	523	281	240	2
6	М.ЛХАГВАСҮРЭН	1,310	240	972	98
7	Ц.ЭРДЭНЭЦЭЦЭГ	343	310	30	3
8	МОНГОЛ БУЦСАН	19,029		19,034	
	БҮГД	23,938	2,398	21433	112

Нийт бүртгэлтэй даатгуулагчдын шилжилт хөдөлгөөнийг хувиар гаргавал, 10 хувь нь ажиллаж байгаа, 1 хувь нь холбоо барих боломжгүй болсон, 89 хувь нь хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусаж, нутаг буцсан байдалтай байна.

Даатгуулагчдын шилжилт хөдөлгөөнийг графикаар харуулбал:

График-11



БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирж буй иргэдийг Нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд хамруулах

2023 онд 683 иргэн МУ-аас БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирсэн байна.

Тайлант хугацаанд тус тасаг БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирсэн нийт 383 иргэнийг шинээр хамруулан, гэрээ байгуулж, “Солонгос улсад гэрээгээр ажиллагсдын шимтгэлийн программ” /<https://app.ndaatgal.mn:811/ndweb/> буюу мэдээллийн санд бүртгэв.

Тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын гэрээний хугацаа дуусаж, сунгалт хийлгэхээр хүсэлт гаргасан 362 даатгуулагчийн гэрээний хугацааг сунгаж, “Солонгос улсад гэрээгээр ажиллагсдын шимтгэлийн программ” /<https://app.ndaatgal.mn:811/ndweb/>-д бүртгэсэн.

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдэд Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэд, даатгуулагчдад Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын

хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг нийтдээ 850 гэрчилгээг бичиж, олгосон байна. Үүнд: шинээр олгосон 381, гэрээ сунгаж олгосон 362, ажил олгогч, даатгуулагчийн хүсэлтээр дахин олгосон 107 байна.

Нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд иргэдийг хамруулсан болон даатгуулагчдад гэрчилгээ бичиж олгосон байдлыг сар бүрээр харуулбал:

Хүснэгт-12

Сар	Тэтгэврийн даатгалд шинээр хамрагдсан	Гэрчилгээ олгосон байдал		
		Шинээр	Сунгалт хийсэн	Дахин
1	30	29	36	14
2	36	35	31	9
3	28	28	53	19
4	24	24	25	6
5	24	24	35	7
6	55	55	28	6
7	30	29	26	4
8	48	48	22	9
9	14	16	22	3
10	21	21	25	10
11	47	47	25	12
12	26	26	34	8
Нийт	383	382	362	107
Бүгд				

7.4. БНСУ-д ОРШИН СУУЖ БУЙ ИРГЭДИЙГ МОНГОЛ УЛСЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЙН ДУРЫН ДААТГАЛД ХАМРУУЛАХ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БНСУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ДАГУУ МОНГОЛ УЛСЫН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛД ДААТГУУЛСАН ГЭРЧИЛГЭЭ БИЧИЖ ОЛГОХ

Хөдөлмөрийн гэрээнээс бусад хэлбэрээр БНСУ-д оршин сууж буй иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах

Анх НДЕГ-ын даргын 2014 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/110 тоот тушаалаар “БНСУ-д оршин сууж буй Монгол Улсын иргэдийг нийгмийн даатгалд хамруулах, нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэх журам” батлагдсан. Энэхүү журмыг хэрэгжүүлэн, программ хангамжийг шинээр нэвтрүүлж, 2015 оны 05 дугаар сараас БНСУ-д оршин сууж буй иргэдийг анх удаа нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулж эхэлсэн.

Тайлант хугацаанд нийт сайн дурын даатгалд хамрагдсан гэрээний хугацаа нь хүчинтэй байгаа 1,036 даатгуулагчийн хувийн хэргийг хариуцан сайн дурын даатгалын <https://app.ndaatgal.mn:811/sdkorea/gereelist.aspx/> программд хяналт тавин ажиллав. Шинээр 278 даатгуулагчийг сайн дурын даатгалд хамруулж, 2 сараас 1 жилийн хугацаатайгаар гэрээ байгуулан ажиллав.

Сайн дурын даатгалд даатгуулсан иргэдэд Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох

БНСУ-д Е-9, Н-2-оос бусад төрлийн визээр ажил хөдөлмөр эрхэлсэн, Монгол Улсын нийгмийн даатгалын сайн дурын даатгалд даатгуулсан иргэдийн хүсэлтээр тус тасаг тайлант хугацаанд Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан 443 гэрчилгээг олгожээ.

Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд иргэдийг хамруулсан, гэрээнд хяналт тавин ажилласан болон гэрчилгээ олгосон байдлыг сар бүрээр харуулбал:

Хүснэгт-13

Сар	Сайн дурын даатгалд шинээр хамруулсан байдал	Гэрчилгээ олгосон байдал
1	23	38
2	27	67

3	26	32
4	23	40
5	46	34
6	18	27
7	10	28
8	14	46
9	21	33
10	40	50
11	20	22
12	10	26
Нийт	278	443

Тус тасгийн нийгмийн даатгалын санд нийт төвлөрүүлсэн орлого

НДЕГ-ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/04 тушаалаар тус тасгийн 2023 оны орлогын төлөвлөгөө 3,347,614,600.00 төгрөгөөр батлагдсан бөгөөд сар бүрийн орлогын төлөвлөгөө 278,967,883.33 төгрөг болно.

2023 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалын санд нийт 1,092,786,982.00 вон буюу 2,901,827,593.77 төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 86,7 хувиар биелүүлсэн.

Үүнд: Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого 516,841,001 вон буюу 1,373,106,533.7 төгрөгийг, сайн дурын даатгалын шимтгэлийн орлого 575,945,981 вон буюу 1,528,721,060.05 төгрөгийг тус тус төвлөрүүлэв.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого төвлөрүүлэлтийг орлогын төлөвлөгөөтэй харьцуулсан байдал, сар бүрээр харуулбал:

/2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр/ Хүснэгт-14

Сар	Сарын орлогын төлөвлөгөө /төгрөгөөр/	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого		Сайн дурын даатгалын шимтгэлийн орлого		Нийт төвлөрүүлсэн шимтгэлийн орлого		Биелэлтийн хувь	Тухайн сарын МБ-ны эхний даваа гарагийн хаалтын ханш
		Воноор	Төгрөгөөр	Воноор	Төгрөгөөр	Воноор	Төгрөгөөр		
1	278,967,883.33	43,560,500.00	118,048,955.00	53,630,275.00	145,338,045.25	97,190,775.00	263,387,000.25	94	2.71
2	278,967,883.33	42,180,500.00	117,683,595.00	43,457,860.00	121,247,429.40	85,638,360.00	238,931,024.40	86	2.79
3	278,967,883.33	48,158,501.00	130,991,122.72	46,262,370.00	125,833,646.40	94,420,871.00	256,824,769.12	92	2.72
4	278,967,883.33	44,020,500.00	117,534,735.00	47,046,170.00	125,613,273.90	91,066,670.00	243,148,008.90	87	2.67
5	278,967,883.33	38,626,180.00	100,041,806.20	50,171,487.00	129,944,151.33	88,797,667.00	229,985,957.53	82	2.59
6	278,967,883.33	42,535,820.00	112,294,564.80	43,835,807.00	115,726,530.48	86,371,627.00	228,021,095.28	82	2.64
7	278,967,883.33	41,710,500.00	109,281,510.00	48,648,392.00	127,458,787.04	90,358,892.00	236,740,297.04	85	2.62
8	278,967,883.33	44,040,500.00	117,147,730.00	45,235,899.00	120,327,491.34	89,276,399.00	237,475,221.34	85	2.66
9	278,967,883.33	36,870,500.00	96,969,415.00	50,409,588.00	132,577,216.44	87,280,088.00	229,546,631.44	82	2.63
10	278,967,883.33	43,410,500.00	111,130,880.00	51,452,320.00	131,717,939.20	94,862,820.00	242,848,819.20	87	2.56
11	278,967,883.33	37,010,500.00	98,077,825.00	49,678,054.00	131,646,843.10	86,688,554.00	229,724,668.10	82	2.65
12	278,967,883.33	54,716,500.00	143,904,395.00	46,117,759.00	121,289,706.17	100,834,259.00	265,194,101.17	95	2.63
	3,347,614,600.0	516,841,001.00	1,373,106,533.72	575,945,981.00	1,528,721,060.05	1,092,786,982.00	2,901,827,593.77	86.7	


Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого төвлөрүүлэлтийг мэргэжилтэн бүрээр харуулбал:

/2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр/ Хүснэгт-15

Нэрс	2023 он							
	Сарын орлогын төлөвлөгөө	Албан журмын даатгалын орлого		Сайн дурын даатгалын орлого		Нийт орлого		Биелэлтийн хувь
		Төгрөгөөр	Воноор	Төгрөгөөр	Воноор	Төгрөгөөр	Воноор	
Л.Азаяа	478,230,660.00	111,596,000.00	296,434,680.00	104,869,009.00	278,266,888.58	216,465,009.00	574,701,568.58	120
Ц.Бямбаа	478,230,660.00	58,961,000.00	156,258,990.00	61,435,784.00	162,956,140.43	120,396,784.00	319,215,130.43	67
Б.Даваажав	478,230,660.00	68,270,000.00	181,368,100.00	64,253,757.00	170,389,977.09	132,523,757.00	351,758,077.09	74
Г.Долгормаа	478,230,660.00	57,520,000.00	152,645,600.00	72,723,162.00	193,343,773.77	130,243,162.00	345,989,373.77	72
Л.Доржсүрэн	478,230,660.00	59,828,001.00	158,942,128.72	56,506,415.00	149,906,469.43	116,334,416.00	308,848,598.15	65
М.Лхагвасүрэн	478,230,660.00	66,470,000.00	177,021,800.00	122,506,946.00	325,259,052.97	188,976,946.00	502,280,852.97	105
Ц.Эрдэнэцэцэг	478,230,660.00	94,196,000.00	250,435,235.00	93,650,908.00	248,598,757.78	187,846,908.00	499,033,992.78	104

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого төвлөрүүлэлтийн гүйцэтгэлийг графикаар, сар бүрээр, төгрөгөөр харуулбал:

График-12



Нийгмийн даатгалын мэдээллийн санд даатгуулагчдын төлсөн шимтгэлийн орлогыг бүртгэх

Тайлант хугацаанд даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлд төлсөн орлогыг БНСУ-ын харилцагч Шинхан, Хана, Үри, Гүгмин 4 банкаас өдөр бүр интернет банкаар татан авч, <https://app.ndaatgal.mn:811/ndweb> программд бүртгэж, хяналт тавин ажиллав.

Даатгуулагчдын сайн дурын даатгалын шимтгэлд төлсөн орлогыг харилцагч Гүгмин банкаас өдөр бүр интернет банкаар татан авч, нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн “Харилцах 2023” программд төгрөгт хөрвүүлэн шивж, хяналт тавин ажиллав. Мөн сайн дурын даатгалын шимтгэлийн орлогыг “Сайн дур даатгалын сан”, “Сайн дурын даатгалын орлого, өдөр бүрээр” гэсэн 2 эксел файлд бүртгэл хөтлөн ажиллав.

Өргөдлийн дагуу даатгуулагчдын төлсөн шимтгэлийн орлогын дүнд залруулга хийх, мэдээллийн санд бүртгэх

Тайлант хугацаанд даатгуулагчид, ажил олгогчдын шимтгэл төлөх дансанд буруу шилжүүлэг хийсэн өргөдлийг хүлээн авч, журмын дагуу зохих баримтыг бүрдүүлэн, залруулгыг хийж, холбогдох программ, мэдээллийн санд мэдээллийг бүртгэн, хяналт тавьж ажиллав. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг данс андуурч шилжүүлснийг залруулах, илүү төлсөн шимтгэл болон данс андуурч даатгуулагчийн цалинг буруу шилжүүлснийг буцаан авах зэрэг нийт 24 өргөдлийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, зохих баримтыг бүрдүүлэн “Солонгос улсад гэрээгээр ажиллагсдын шимтгэлийн программ” /<https://app.ndaatgal.mn:811/ndweb/>-д залруулгыг хийж бүртгэв.

- Сайн дурын даатгалд илүү төлсөн шимтгэлийг буцаан авах, шимтгэлийг данс андуурч шилжүүлэх, төлсөн шимтгэлийг шилжүүлэн тооцуулах зэрэг нийт 24 өргөдлийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, зохих баримтыг бүрдүүлэн нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн “Харилцах 2023” программ, сайн дурын даатгалын <https://app.ndaatgal.mn:811/sdkorea/gereelist.aspx/> программ болон “Сайн дур даатгалын сан” эксел файлд залруулгыг хийж гүйцэтгэв.

Төвлөрүүлсэн орлогыг нийгмийн даатгалын санд шилжүүлсэн байдал

Тайлант хугацаанд тус тасгийн төвлөрүүлсэн шимтгэлийн орлогоос НДЕГ-ын Төрийн банкин дахь нийгмийн даатгалын сангийн холбогдох дансанд нийт 2,843 сая, үүнээс тэтгэврийн даатгалын санд 2,622 сая, тэтгэмжийн даатгалын санд 110.2 сая, ҮОМШӨ-ний даатгалын санд 110.2 сая төгрөгийг тус тус шилжүүлэв.

Мөн холбогдох сангийн тайлан мэдээг сар бүр нэгтгэн боловсруулж, НДЕГ-ын Санхүү бүртгэлийн газрын холбогдох мэргэжилтэнд илгээж, тайлагнан ажиллав.

Нийгмийн даатгалын санд шилжүүлсэн шимтгэлийн орлогын дүн /төгрөгөөр/

*/2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр/
Хүснэгт-16*

Сар	Даатгалын сангийн төрөл			НДЕГ-ын Төрийн банкн дахь дансанд шилжүүлсэн нийт дүн
	Тэтгэврийн даатгал	Тэтгэмжийн даатгал	ҮОМШӨ-ний даатгал	
1	227,764,473.18	9,103,560.98	9,103,560.98	245,971,595.14
2	239,263,212.08	10,091,919.67	10,091,319.67	259,446,451.42
3	232,408,530.70	8,974,113.33	8,974,113.33	250,356,757.36
4	220,391,477.80	8,773,115.00	8,773,115.00	237,937,707.80
5	191,089,403.94	9,405,304.82	9,405,304.82	209,900,013.58
6	224,759,544.89	10,069,751.89	10,069,751.89	244,899,048.67
7	215,889,288.11	8,889,115.50	8,889,115.50	233,667,519.11
8	218,445,536.16	8,784,339.39	8,784,339.39	236,014,214.94
9	208,640,594.26	8,473,482.85	8,473,482.85	225,587,559.96
10	232,834,152.06	10,309,951.44	10,309,951.44	253,454,054.94
11	204,501,542.37	9,066,867.14	9,066,867.14	222,635,276.65
12	206,630,235.24	8,260,778.78	8,260,778.78	223,151,792.80
Нийт дүн	2,622,617,990.99	110,202,300.79	110,201,700.79	2,843,021,992.57

Даатгалын шимтгэлийг хугацаанд нь төлөөгүй даатгуулагчидтай холбогдож, шимтгэлийн авлага барагдуулах

Даатгалын гэрээний хугацаа дуусаагүй боловч шимтгэл төлөхгүй байгаа даатгуулагчид цөөнгүй байгаа ба эдгээр даатгуулагчдыг шимтгэл төлүүлэх талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлэв. Үүнд:

- Даатгалын шимтгэл төлөхгүй байгаа даатгуулагчдын ажил олгогчтой холбогдон, факсаар мэдээлэл, нэхэмжлэл илгээх, цалингаас суутгал хийн төлүүлж байх талаар мэдээлэл хүргэх
- Шимтгэл төлөөгүй даатгуулагчдын гар утас руу шимтгэл төлөхийг шаардсан мессеж, анхааруулга бичиж илгээх

Тайлант хугацаанд шимтгэл төлөхгүй байгаа даатгуулагчид болон ажил олгогчдод факсаар давхардсан тоогоор 5,966 удаа шимтгэл төлөх нэхэмжлэл илгээсэн байна. Мөн утсаар болон цахим хэлбэрээр давхардсан тоогоор 8,289 даатгуулагч болон ажил олгогчтой холбогдож, шимтгэлийн төлөлт хийхийг шаардаж ярив.

7.5. БНСУ-Д ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР (Е-9, Н-2 ВИЗЭЭР) АЖИЛЛАХ ХУГАЦААНДАА ТУС УЛСЫН ҮНДЭСНИЙ ТЭТГЭВРИЙН ДААТГАЛД ШИМТГЭЛ ТӨЛСӨН ИРГЭДИЙН ШИМТГЭЛИЙГ БУЦААН ОЛГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

Монгол Улсын НДЕГ, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн алба хооронд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилт

Монгол Улсын НДЕГ, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн алба хооронд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн

даатгалд хамрагдан шимтгэл төлж байсан иргэдийн шимтгэлийн мөнгийг буцаан олгуулах ажлыг гүйцэтгэлээ. Үүнд:

2022 оны 12 дугаар сараас 2023 оны тайлант хугацаанд НДЕГ-аар дамжуулан тус тасагт 179-өөс 195 дугаар ээлжийн нийт 17 удаагийн 64 иргэн буцаан олголт нэхэмжилсэн бичиг баримтаа ирүүлснээс 179-өөс 189 дүгээр ээлжийн нийт 11 удаагийн 48 иргэний буцаан олголт бүрэн шийдэгдэж, 192,8 сая вон иргэдэд олгогдоод байна.

190-ээс 195 дугаар ээлжийн 16 иргэний материалыг НДЕГ-аас хүлээн авч шалган, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албаны Гадаад хамтын ажиллагааны төвийн буцаан олголт хариуцсан ажилтанд хүргүүлсэн. Эдгээр иргэдийн буцаан олголт одоогоор шийдвэрлэгдэх шатандаа явж байна.

Монгол Улсын НДЕГ, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн алба хооронд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу буцаан олголт асавсан байдал

Хүснэгт-17

№	Нэхэмжилсэн он	Ээлжийн дугаар	Буцаан олголт нэхэмжилсэн иргэдийн тоо	Буцаан олголт авсан иргэдийн тоо	Буцаан олгогдсон шимтгэлийн дүн /вон/
1	2022	179	6	6	27,031,070
2	2022	180	8	8	35,383,800
3	2022	181	6	6	19,426,790
4	2022	182	4	4	30,524,710
5	2023	183	4	4	21,755,810
6	2023	184	2	2	3,016,040
7	2023	185	3	7	21,774,460
8	2023	186	2	2	1,976,500
9	2023	187	3	3	6,017,350
10	2023	188	2	2	10,397,890
11	2023	189	3	4	15,591,900
12	2023	190	1		
13	2023	191	3		
14	2023	192	5		
15	2023	193	4		
16	2023	194	5		
17	2023	195	3		
Нийт	17		64	48	192,896,320

БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албанаас тус улсад хөдөлмөрийн гэрээгээр (Е-9, Н-2 визээр) ажиллах хугацаандаа үндэсний тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн иргэдэд шимтгэлийг буцаан олгосон байдал, тоон мэдээлэл

Тус тасгаас БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албаны Гадаад хамтын ажиллагааны төвд хүсэлт тавин тус улсад хөдөлмөрийн гэрээгээр (Е-9, Н-2 визээр) ажиллах хугацаандаа тус улсын үндэсний тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн Монгол Улсын иргэдэд “Гадаад иргэдийн хөдөлмөр эрхлэх хууль”-ийн дагуу төлсөн шимтгэлийг буцаан олгосон байдлыг, статистик тоон мэдээллийг авсан болно. БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын албанаас буцаан олголт авахдаа НДЕГ-тай байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд, эсвэл хөдөлмөрийн гэрээт ажилчин бүр мөсөн нутаг буцахдаа Инчоно нисэх онгоцны буудлаас тус тус буцаан олголт авдаг. Үүнд:

1. 2022-2023 оны 8 дугаар сар хүртэл буцаан олголт авсан иргэдийн тоо, мөнгөн дүн

/Хэмжих нэгж: Хүн, сая воноор/ Хүснэгт-18

Он сар	Буцаан олголт авсан иргэдийн тоо	Буцаан олголт авсан дүн
2023 оны 8 сар	314	2,664
2022 он	483	3,638

2. 2022-2023 оны 8 дугаар сар хүртэл тэжээгчээ алдсаны тэтгэвэр болон тахир дутуугийн тэтгэвэр авагчдын тоо

/Хэмжих нэгж: Хүн/ Хүснэгт-19

Ангилал	Нийт	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	Тохир дутуугийн тэтгэвэр
2023 оны 8 сар	55	53	2
2022 он	53	51	2

3. MOU болон Инчоны нисэх онгоцны буудал дээрээс буцаан олголт олгогдсон байдал

/Хэмжих нэгж: Хүн, сая воноор/ Хүснэгт-20

Ангилал	*MOU-аар дамжуулж		**Инчоны нисэх онгоцны буудлаас	
	Буцаан олголт авсан иргэдийн тоо	Буцаан олголт авсан дүн	Буцаан олголт авсан иргэдийн тоо	Буцаан олголт авсан дүн
2023 он	30	120	287	2,579
2022 он	60	233	313	2,538

* 2023 оны 09 сарын байдлаар

** 2023 оны 11 сарын байдлаар

БНСУ-ын адил төст үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудтай хамтарч ажиллах ажлын хүрээнд

Тайлант хугацаанд тус тасаг нь Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн Газар хооронд байгуулсан Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр, Монгол Улсын НДЕГ, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын алба хоорондын Харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилтийн хүрээнд БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын албаны Гадаад хамтын ажиллагааны төвтэй байнга мэдээлэл солилцон, харилцаа холбоотой ажиллаж, дараах арга хэмжээнүүдийг хамтран амжилттай зохион байгуулав. Үүнд:

- 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдөр тус тасгаас хамтран ажилладаг “Үри” банктай уулзалт зохион байгуулсан бөгөөд уг уулзалтаар “НДЕГ болон Үри банктай хамтран ажиллах санамж бичиг”-ийг сунгах тухай харилцан санал солилцсон. Мөн Үри банкнаас даатгуулагчдын шимтгэлийг төвлөрүүлэх шинэ 10,000 виртуал дансыг авч, хэрэглээнд ашиглаж байна.
- БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албаны Гадаад хамтын ажиллагааны төвийн Монгол мэргэжилтэн болох Н.Одончимэгтэй тус тасгийн мэргэжилтнүүд холбогдон ажиллав.
- БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албаны Гадаад хамтын ажиллагааны газрын Буцаан олголт хариуцсан мэргэжилтэн И.Дэ Сынтэй тогтмол холбогдон хамтран ажиллаж байна.

8. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

8.1. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АЖЛЫН ТАЛААР

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу давхардсан тоогоор 5 аймаг, 1 дүүргийн НДХ-т Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэл, хүний нөөцийн удирдлага зохион байгуулалт, архив болон албан хэрэг хөтлөлтийн стандарт, өмнөх шалгалтын мөрөөр хэрэгжүүлсэн ажлын үр дүнд төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт, шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авлаа.

2023 онд төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт, шалгалтад хамрагдсан НДХ-үүдийн судалгаа

/сая. төг/ Хүснэгт-21

№	Тайлангийн хугацаа	Шалгалтад хамрагдсан аймаг, дүүргийн нэр	Илэрсэн төлбөр, зөрчлийн дүн	Шалгалтын хэлбэр
---	--------------------	------------------------------------------	------------------------------	------------------

8	2023 он /5 аймаг, 1 дүүрэг/	1	Өмнөговь аймгийн НДХ	12.1	Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалт
		2	Завхан аймгийн НДХ	523.3	
		3	Сэлэнгэ аймгийн НДХ	74.3	
		4	Булган аймгийн НДХ	189.4	
		5	Архангай аймгийн НДХ	39.5	
		6	Сүхбаатар дүүргийн НДХ	95.8	
	Дүн	6		934.4	

2023 онд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг Өмнөговь, Завхан, Сэлэнгэ, Булган аймаг болон Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст төлөвлөгөөт шалгалт, Архангай аймгийн нийгмийн даатгалын хэлтэст төлөвлөгөөт бус шалгалт хийлээ. Шалгалтаар 2018 оноос хойш хугацаанд шинээр тэтгэвэр тогтоолгон авсан нийт 38700 иргэний тэтгэврийн тогтоолтыг шалгаж 187 иргэнд үндэслэлгүй баримтаар тэтгэвэр тогтоож, олгосон 934.4 сая төгрөгийн зөрчил илрүүлэн нөхөн төлүүлэхээр шийдвэрлэж нийт төлбөрийн 75.1 хувь буюу 701.7 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд төлүүлээд байна.

- Эрүүгийн цагдаагийн албатай хамтран нүүрс тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг нэр бүхий 55 байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж 4304 даатгуулагчид олгосон 12.1 тэрбум төгрөгийн цалингийн сангаас 2,843.4 сая төгрөгийн шимтгэл дутуу тооцсон зөрчил илрүүлэн, 50.0 саяас дээш төгрөгийн зөрчилтэй нэр бүхий 8 байгууллагад Эрүүгийн тухай хуулиар, бусад 47 байгууллагад Нийгмийн даатгалын тухай хуулиар хариуцлага тооцохоор шийдвэрлэв.
- Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын баталсан 2023 оны А/42 дугаар тушаалын дагуу барилга, зам тээвэр, боловсруулах үйлдвэр, уул уурхай, боловсрол, эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг дундаас дээш эрсдэл бүхий 627 аж ахуйн нэгж, байгууллагаас 65.0 хувь буюу 413 байгууллагыг хамруулан шалгаж 299 байгууллага “бага” эрсдэлтэй, 101 аж ахуй нэгж “дунд” эрсдэлтэй, 13 байгууллага “их” эрсдэлтэй үнэлэгдэв. Шалгалтын хугацаанд давхардсан тоогоор нийт 946 заалт бүхий 193 албан шаардлагыг хүргүүлж, 63.1 хувь буюу 596 заалтыг биелүүлж ажиллав.
- Шалгалтын хугацаанд 532 иргэнд олгосон хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос 208.9 сая төгрөгийн шимтгэлийг нөхөн төлүүлж, 29 иргэнд дутуу тооцож олгосон 6.2 сая төгрөгийг нөхөн олгохоор улсын байцаагчийн акт тогтоож, 88.2 хувийг барагдуулж ажиллав. Нэр бүхий 7 байгууллагад Зөрчлийн тухай хуулийн дагуу хялбаршуулсан журмаар шийдвэрлэж 4.8 сая төгрөгийн торгууль ногдуулж 6 заалт бүхий 3 албан даалгавар хүргүүлэв.

Мөн газрын даргын баталсан удирдамжийн дагуу Нийгмийн даатгалын сан болон Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авч байгаа иргэдийн тэтгэврийн давхардлыг 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд шалгаж 280 тэтгэвэр авагчтай холбоотой 184.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж 7 иргэнээр 2.6 сая төгрөгийг Нийгмийн даатгалын санд нөхөн төлүүлж, 273 иргэнээр 181.6 сая төгрөгийг Нийгмийн халамжийн санд тус тус нөхөн төлүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоож, төлбөрийн 75.0 хувийг барагдуулав.

Тайлант хугацаанд 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулалтад шалгалт хийж нийт 643 иргэнтэй холбоотой 809.6 сая төгрөгийн зөрчил илрүүлэн нөхөн төлүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоов.

- “Хуримтлагдсан авлагыг бууруулж, хамралтыг нэмэгдүүлэх” аяны хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд 2022 оны эцсийн байдлаар нийт 31.4 мянган аж ахуйн, нэгжийн 353.9 тэрбум төгрөгийн шимтгэлийн авлагатай байсан бөгөөд тайлант онд нийт авлагын хэмжээ 428.1 тэрбум төгрөгөөр

нэмэгдэж, 327.3 тэрбум төгрөгийг барагдуулсан боловч энэ оны авлагын хэмжээ 454.6 тэрбум болж оны эхний үлдэгдлээс 28.0 хувиар өссөн бөгөөд нийт авлагын 80.5 хувийг нийслэлийн 9 дүүргийн авлага эзэлж байна.

Шалгалтад хамрагдсан аймаг, дүүргийн хэмжээнд 120 ба түүнээс дээш хоногийн хуримтлагдсан өртэй 76 аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох албан тушаалтантай уулзаж, 59 байгууллагын 859.4 сая төгрөгийн авлагыг шалгалтын хугацаанд барагдуулж ажилласан.

Тайлант хугацаанд нийт авлагын эхний үлдэгдлийг Хэнтий аймаг 22.1 хувиар, Багануур дүүрэг 3.4 хувиар тус тус бууруулсан бол бусад аймаг, дүүргийн хэмжээнд 1-2.5 дахин харин Завхан аймаг 3 дахин нэмэгдүүлэв.

- Аж ахуйн нэгж, байгууллага иргэд, даатгуулагчтай холбоотой 741 зөрчлийн шинжтэй үйлдлийг шалгаснаас орон нутагт 332, нийслэлд 409 аж ахуйн нэгж, байгууллага, иргэд даатгуулагч хамрагдлаа. Нийт зөрчлийн 87.0 хувь буюу 644 зөрчлийг хялбаршуулсан журмаар, 11.2 хувь буюу 83 гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, 0.5 хувь буюу 4 зөрчлийг харьяаллын дагуу шилжүүлж, 1.3 хувь буюу 10 зөрчлийн хэрэгт 1.8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр тогтоосноос 599.9 сая төгрөгийн төлбөрийг орон нутагт, 1.2 тэрбум төгрөгийн төлбөрийг нийслэлд шалган тогтоож, нийт төлбөрийн 72.2 хувь буюу 1.2 тэрбум төгрөгийг барагдуулав.

Дээрх 741 аж ахуйн нэгж, байгууллагын 654 байгууллагад 234.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч 98.2 хувийг барагдуулж ажиллав.

- 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд дотоодын хяналт шалгалтаар илрүүлсэн 12.9 тэрбум төгрөгийн төлбөр, зөрчлийн дэлгэрэнгүй мэдээг 2023 оны 11 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар авч, нэгтгэн барагдуулалтад хяналт тавьж ажиллав.

Тайлант хугацаанд илэрсэн нийт зөрчлийн 55.8 хувь буюу 7.2 тэрбум нь уг сангаас илүү тооцож олгосон тэтгэврийн зөрчил байгаа бол нийт зөрчлийн 85.2 хувь буюу 6.1 тэрбум нь үндэслэлгүй баримтаар шүүхийн шийдвэр гаргуулан тэтгэвэр тогтоолгон авсан мөн архивын лавлагааг хуурамчаар үйлдсэн зэрэг зөрчил байгаад анхаарч ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

- Тэтгэврийн даатгалын сангаас их хэмжээний зөрчил илэрч байгаатай холбогдуулан Архивын ерөнхий газар болон Архангай, Дархан-Уул аймгуудын архивын тасгаас гаргаж ирүүлсэн 558 тушаалын үндэслэлийг Шүүхийн шинжилгээний хүрээлэнгээр криминалистикийн шинжилгээ хийлгэж, шинжээчийн дүгнэлт гаргуулан, цаашид авах арга хэмжээний талаар аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст чиглэл хүргүүлж, хуурамч баримтыг хэрхэн ялгаж таних, уг баримтаар тэтгэвэр тогтоолгосон нөхцөлд шийдвэрлэх арга замын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласны дүнд Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс дотоодын хяналт шалгалтаараа хуурамч баримт бүрдүүлэн тэтгэвэр тогтоолгон авсан нийт 42 иргэнтэй холбоотой 633.0 сая төгрөгийн зөрчил илрүүлэн нөхөн төлүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоож, төлбөрийн 70.2 хувь буюу 444.2 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд нөхөн төлүүлж, 5 иргэнтэй холбоотой 129.4 сая төгрөгийн зөрчлийг шийдвэрлүүлэхээр хуулийн байгууллагад шилжүүлэв.

- Тайлант хугацаанд илэрсэн нийт зөрчлийн 85.2 хувь нь уг сангаас илүү тооцож олгосон тэтгэврийн зөрчил байгаагаас 89.0 хувь нь үндэслэлгүй баримтаар шүүхийн шийдвэр гаргуулан тэтгэвэр тогтоолгон авсан мөн архивын лавлагааг хуурамчаар үйлдсэн зэрэг зөрчил эзэлж байна.

Мөн иргэдийн гар дээр байгаа үндэслэлгүй баримтаар шүүхийн шийдвэр гаргаснаар тэтгэврийн даатгалын санд их хэмжээний хохирол учирч байгаад дүгнэлт хийж Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хороотой хамтарсан уулзалт зохион байгуулан, 44 шүүгчийн 114 шүүхийн шийдвэрийг шүүгч нэг бүрээр танилцуулав.

- Хил хамгаалах ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын хамтран ажиллах санамж бичгийг 2023 оны 2 дугаар сарын 17-ны өдөр шинэчлэн байгуулж батлуулав.

Уг санамж бичгийн хүрээнд Монгол Улсын Хилийн тухай хууль, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон

Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хил хамгаалах байгууллагын албан хаагч, улсын хил дээр алба хааж байгаа офицер, ахлагч нарын ажил эрхлээгүй гэр бүл, Хилийн цэргийн сургуульд сонсогчоор суралцсан болон хугацаат цэргийн алба хаасан иргэдийн хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж авах эрхийг баталгаажуулах чиглэлээр аймаг, дүүрэгт байрлах хилийн цэргийн ангиудтай харьаллын дагуу нийгмийн даатгалын хэлтэс бүр хамтарсан ажлын хэсэг байгуулан, зохион байгуулж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган баталж ажлын хэсгээс холбогдох арга хэмжээг авч ажиллалаа. Мөн нийгмийн даатгалын хэлтсүүдийн архивт хадгалагдаж буй хил хамгаалах байгууллагын бие бүрэлдэхүүн (*офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагч, үйлчилгээний ажилчид*), цэргийн сургуулийн сонсогч, хугацаат цэргийн албан хаагч, ажил эрхлээгүй гэр бүл (*офицер, ахлагч*)-ийн 1995 оноос 2022 оныг дуусталх хугацааны эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг үндсэн баримт, сангийн мэдээлэлтэй тулган баталгаажуулах, илэрсэн зөрчлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх ажлыг зохион байгууллаа. Энэхүү ажлын хүрээнд 1995-2005 онд хугацаат цэргийн албан хаагчдын нийгмийн даатгалын шимтгэл нь бөөн дүнгээр төлөгдсөн боловч даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалтын тайлан хийгдээгүй байсныг хадгаламжийн нэгж нөхөн бүрдүүлэх журмын дагуу бүртгэж, холбогдох баримтуудыг хэлтсийн архивт хүлээн авсан.

- Сүүлийн жилүүдэд “Хяналтын программ”-ыг ашиглан улмаар хяналт, шалгалтын ажлыг цаасан болон цахим мэдээллийн санд тулгуурлан хийснээр цаг хугацаа, хөрөнгө, зардал хэмнэж, Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирч, зөрчил, дутагдлыг тухай бүр нь арилгах, сангийн зарцуулалтад гарах эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэв.
- **2023 онд** Нийгмийн даатгалын багц хууль шинэчлэгдсэнтэй холбоотойгоор Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан “**Сургагч багш бэлтгэх сургалт**”-д хамрагдаж Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн 160 гаруй байцаагч, ажилтнууд мөн ажил олгогч байгууллагын 1160 орчим нягтлан бодогч, ажилтнуудыг хамруулан шинэчилсэн хуулийн талаар сургалт зохион байгуулав.

Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь төсөл”-ийн хүрээнд ОУХБайгууллагын санхүүгийн дэмжлэгээр хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хяналтын улсын байцаагчдыг чадавхжуулах сургалт зохион байгуулж сургалтад аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн хамгааллын 37 улсын байцаагч хамрагдаж, төрөөс баримтлаж буй нийгмийн хамгааллын салбарын бодлого, нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулах ажлын үр дүн хэрэгжилтийн талаар бодит байдалтай танилцах, туршлага солилцох, дадлагажих ажлыг БГДүүргийн НДХ-тэй хамтран зохион байгуулав.

9. САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ

9.1. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ:

Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналтад 2023 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн нийт 31 шийдвэрийн 86 заалт байна.

Хяналтад байгаа нийт 31 шийдвэрийн 7 шийдвэр нь 2022 онд гарсан, 24 шийдвэр нь 2023 онд шинээр хяналтад авсан заалтууд байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд 2023 оны эхний хагас жил болон 2023 оны жилийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээний үнэлгээний дүнг дараах байдлаар харуулав.

Шийдвэрийн төрөл	2023 оны эхний хагас жил			2023 оны жилийн эцэс		
	Нийт шийдвэрийн тоо	Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь	Нийт шийдвэрийн тоо	Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь
Монгол Улсын Засгийн газрын тогтоол	13	23	92.0	15	50	96.0
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	4	5	96.6	4	5	100
Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл				12	33	100
Нийт	17	28	94.3	31	88	98.6

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжиж буй 17 хууль тогтоомж, дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 28 заалтын биелэлтийг 2023 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар 94.3 хувиар үнэлж, үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 01/1428 дугаар албан бичгээр, 2023 онын жилийн эцсийн байдлаар 31 хууль тогтоомж, дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 88 заалтын биелэлтийг 98.6 хувьтай үнэлж, үнэлгээний тайланг Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэхээр бэлтгэж байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ:

Шилэн дансны хөтлөлтийн талаар:

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд шилэн дансны нэгдсэн цахим хуудас/shilendans@mof.gov.mn/-д “Төсөв, гүйцэтгэл”, “Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт”, “Бусад” гэсэн цэсээр нийт 24 төрлийн мэдээллийг харьяа байгууллагууд байршуулан мэдээлж байна. Үүнд:

- *Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасны дагуу байгууллагын мэдээллийг Нийгмийн даатгалын ерөнхий газар, МТТ, БНСУ дах Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв, Нийслэлийн нийгмийн даатгалын газар, 9 дүүрэг, 21 аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нийт 34 эрх байгууллага;*
- *Хуулийн 6 дугаар зүйлийн 6.7-д заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн мэдээллийг Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн нийгмийн даатгалын газар, 9 дүүрэг, 21 аймгийн нийгмийн даатгалын сан;*

Нийгмийн даатгалын байгууллагууд 2023 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 8,208 мэдээллийг байршуулахаас хугацаандаа байршуулсан мэдээлэл 7,805, хугацаа хоцроосон мэдээлэл 296, байршуулаагүй 107 мэдээлэл байсан ба мэдээлэл байршуулалт 99 хувь, хугацаандаа мэдээлэл байршуулалт 95 хувьтай байна. Үүнд:

- *Нийгмийн даатгалын байгууллагын мэдээлэл байршуулалт:* 2023 оны 3 дугаар улирлын байдлаар нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны нийт 4,284 мэдээллийг байршуулахаас хугацаандаа байршуулсан мэдээлэл 4,112, хугацаа хоцроосон мэдээлэл 129, байршуулаагүй 43 мэдээлэл байсан ба мэдээлэл байршуулалт 99 хувь, хугацаандаа мэдээлэл байршуулалт 96 хувьтай байна.
- *Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт:* 2023 оны 3 дугаар улирлын байдлаар Нийгмийн даатгалын сангийн нийт 3,924 мэдээллийг байршуулахаас хугацаандаа байршуулсан мэдээлэл 3,693, хугацаа хоцроосон мэдээлэл 167, байршуулаагүй 64 мэдээлэл байсан ба мэдээлэл байршуулалт 98 хувь, хугацаандаа мэдээлэл байршуулалт 94 хувьтай байна.

Шилэн дансны хөтлөлтийн нэгдсэн тайланг 2023 оны 1,2,3 дугаар улирлын байдлаар гаргаж, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2023 оны 1/83, 1/789, 1/ 1431, 1/1865 дүгээр албан бичгээр тус тус хүргүүлэв.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулаагүй Завхан, Говь-Алтай, Хөвсгөл, Ховд, Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарт Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Шилэн дансны мэдээлэл байршуулах тухай” 01/773, 01/774, 01/790, 01/791, 01/792 дугаар албан бичгийг хүргүүлэв.

Мөн 2023 оны 03 дугаар улирлын мэдээгээр Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг байршуулаагүй Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргад “Шилэн дансны мэдээлэл байршуулах тухай” 03/1861 дүгээр албан бичгийг хүргүүлэв.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын талаар:

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16.5.7 дахь заалт, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/197 дугаар тушаал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, шилэн дансны цахим хуудасны 2023 оны хөтлөлт, мэдээлэл байршуулсан байдал, холбогдох баримт бичгийг бүрэн оруулсан байдалд хяналт тавьж, дүн шинжилгээ хийх, гаргасан алдаа, илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийг дуустал хугацааг хамруулан 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 14-ний өдрүүдэд дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн.

Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагууд нь Shilendans.gov.mn цахим хуудсанд Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа болон Нийгмийн даатгалын сангийн мэдээллийг тухай бүр, сар, улирал, хагас жил, жилээр гэсэн давтамжтайгаар мэдээлж байна.

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар шилэн дансны цахим хуудсанд нийт 9,739 мэдээлэл байршуулахаас 9,320 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 365 мэдээллийг хугацаа хоцроож, 54 мэдээллийг байршуулаагүй байна. Мэдээлэл байршуулалт 99.4 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 95.7 хувьтай байна. Үүнд:

- **Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт:** 5,168 мэдээлэл байршуулахаас 4,988 мэдээллийг хугацаанд нь байршуулж 162 мэдээллийг хугацаа хоцроож, 18 мэдээллийг байршуулаагүй байна. Мэдээлэл байршуулалт 99.7 хувь, хугацаанд нь байршуулсан мэдээлэл 96.52 хувь

- **Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт:** 4,571 мэдээлэл байршуулахаас 4,332 мэдээллийг байршуулж 203 мэдээллийг хугацаа хоцроож, 36 мэдээллийг байршуулаагүй байна. Мэдээлэл байршуулалт 99.2 хувь, хугацаанд нь байршуулсан мэдээлэл 94.5 хувь;

Нийгмийн даатгалын салбарын дүнгээр нийт мэдээлэл байршуулалтыг аймаг, дүүргээр харуулбал:

Хүснэгт-23

№	Байгууллагын нэр	Нийт мэдээлэл	Мэдээлэл хугацаандаа оруулсан	Үүнээс				Хугацаа хоцорсон мэдээлэл	Үүнээс			Мэдээлэл оруулаагүй	Нийт мэдээлэл байршуулсан хувь	Хугацаандаа мэдээлэл байршуулсан хувь
				Мэдээлэл хугацаандаа оруулсан	Ил тод болгоогүй /Мэдээлэл оруулж	Ил тод болгосон /Араас нь хугацаандаа зассан/	Оруулах мэдээлэл байхгүй		Хугацаа хоцроосон	Оруулах мэдээлэл байхгүй	Ил тод болгосон /хоцорч зассан/			
1	НДЕГазар	152	150	89	-	2	59	2	2	-	-	-	100%	99%
2	МТТөв	152	150	73	-	-	77	2	2	-	-	-	100%	99%
3	БНСУ дахь НД-ын тасаг	152	140	54	-	2	84	12	4	8	-	-	100%	92%

5	ННДГ	174	173	78	-	2	93	1	1	-	-	-	100%	99%
6	Баянгол	304	302	112	-	14	176	2	2	-	-	-	100%	99%
7	Баянзүрх	304	296	99	-	7	190	8	3	4	1	-	100%	97%
8	Сүхбаатар дүүрэг	304	299	117	-	6	176	5	4	-	1	-	100%	98%
9	Сонгинохайрхан	304	296	117	1	10	168	8	8	-	-	-	100%	97%
10	Чингэлтэй	304	301	147	-	2	152	3	-	-	3	-	100%	99%
11	Хан-Уул	304	302	302	-	-	-	2	2	-	-	-	100%	99%
12	Налайх	304	301	139	-	-	162	3	2	1	-	-	100%	99%
13	Багануур	304	293	118	-	2	173	11	11	-	-	-	100%	96%
14	Багахангай	293	281	130	3	118	30	12	12	-	-	-	100%	96%
15	Архангай	304	300	133	-	9	158	4	2	-	2	-	100%	99%
16	Баян-Өлгий	304	300	103	-	10	187	4	4	-	-	-	100%	99%
17	Еаянхонгор	304	299	131	5	7	156	5	4	-	1	-	100%	98%
18	Булган	304	304	132	-	18	154	-	-	-	-	-	100%	100%
19	Говь-Алтай	304	283	72	-	5	206	21	11	10	-	-	100%	93%
20	Говьсүмбэр	304	281	62	-	7	212	23	18	2	3	-	100%	92%
21	Дархан-Уул	304	288	89	1	4	194	16	15	1	-	-	100%	95%
22	Дорноговь	304	291	90	14	3	184	13	4	9	-	-	100%	96%
23	Дорнод	304	298	154	-	5	139	6	4	2	-	-	100%	98%
24	Дундговь	304	297	136	-	2	159	7	3	4	-	-	100%	98%
25	Завхан	304	279	114	-	5	160	25	12	4	9	-	100%	92%
26	Орхон	304	298	113	-	2	183	6	3	2	1	-	100%	98%
27	Өвөрхангай	304	296	85	28	2	181	8	8	-	-	-	100%	97%
28	Өмнөговь	304	287	120	-	4	163	17	16	-	1	-	100%	94%
29	Сүхбаатар	304	304	123	-	2	179	-	-	-	-	-	100%	100%
30	Сэлэнгэ	304	285	91	-	1	193	19	5	14	-	-	100%	94%
31	Төв	304	202	58	-	3	141	48	16	1	31	54	82%	66%
32	Увс	304	293	127	8	6	152	11	8	3	-	-	100%	96%
33	Ховд	304	297	165	2	1	129	7	7	-	-	-	100%	98%
34	Хөвсгөл	304	294	177	-	3	114	10	3	4	3	-	100%	97%
35	Хэнтий	304	260	260	-	-	-	44	-	-	44	-	100%	86%
Нийт		9,739	9,320	4,110	62	264	4,884	365	196	69	100	54	99.4%	95.7%

Дээрх хүснэгтээс харахад:

- Хугацаандаа байршуулсан 9,320 мэдээллээс:

- ✓ Мэдээллээ хугацаандаа оруулсан 4,110 мэдээлэл;
- ✓ Ил тод болгоогүй /Мэдээлэл оруулж байгаа/ 62 мэдээлэл;
- ✓ Ил тод болгосон /Дараа нь хугацаандаа зассан 264 мэдээлэл;
- ✓ Оруулах мэдээлэл байхгүй төлөвт оруулсан 4,884 мэдээлэл байна.

- Хугацаа хоцроож байршуулсан 365 мэдээллээс:

- ✓ Хугацаа хоцроосон 196 мэдээлэл;
- ✓ Оруулах мэдээлэл байхгүй төлөвт 69 мэдээлэл;
- ✓ Ил тод болгосон /хоцорч зассан/ 100 мэдээлэл байна.

Шилэн дансны хууль, журмын хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын дүн мэдээ, танилцуулгыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 01/109 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.

9.2. ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ:

Төсвийн ерөнхийлөн захирагч /Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд/-аас төсвийн шууд захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-тай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ:

Төсвийн ерөнхийлөн захирагч /Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд/-аас Төсвийн шууд захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-тай 2023 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд эхний хагас жил болон жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ үнэлгээг хийв.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 10 зорилтын 59 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд:

- *Бодлогын баримт бичигт тусгагдсан 1 зорилт, 12 арга хэмжээ;*
- *Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн 1 зорилт, 17 арга хэмжээ;*
- *Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийн 4 зорилт, 18 арга хэмжээ;*
- *Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр 4 зорилт, 12 арга хэмжээ байна.*

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг 93.7 хувиар, жилийн эцсийн биелэлтийг 96.52 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэж, үнэлгээний тайланг Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 01/1289, 01/2268 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэв.

Төсвийн шууд захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-аас зохион байгуулалтын нэгжийн дарга /менежер/-тай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ:

Төсвийн шууд захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-аас зохион байгуулалтын нэгжийн дарга нартай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2023 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээг хийв.

Зохион байгуулалтын нэгжийн дарга нарын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 198 арга хэмжээг тусгаж, нэмэлт 32 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллав. Үүнд:

- *Тамгын газар: 33 арга хэмжээ;*
- *Дотоод аудит, мониторингийн газар: 19 арга хэмжээ, нэмэлт 24 арга хэмжээ;*
- *Бодлогын хэрэгжилт, судалгааны газар: 30 арга хэмжээ;*
- *Сургалт олон нийт хамтын ажиллагааны газар: 9 арга хэмжээ;*
- *Хяналт шалгалтын газар: 10 арга хэмжээ;*
- *Санхүү бүртгэлийн газар: 14 арга хэмжээ, нэмэлт 4 арга хэмжээ;*
- *Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс: 23 арга хэмжээ, нэмэлт 4 арга хэмжээ;*
- *Мэдээллийн технологийн төв: 11 арга хэмжээ;*
- *Нийслэлийн Нийгмийн даатгалын газар: 49 арга хэмжээ;*

Зохион байгуулалтын нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг эхний хагас жилийн байдлаар 94.6 хувь, жилийн эцсийн байдлаар 92.2 хувиар буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж, дүн мэдээг НДЕГ-ын даргад танилцуулав.

Зохион байгуулалтын нэгжийн 2023 онд дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр хүлээсэн үүргийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний дүнг харуулбал:

Нэгжийн үнэлгээний дүн

Хүснэгт-24

№	Газрын нэр	Менежерийн нэр	Үнэлгээ
1	Тамгын газар	Б.Батсүх	92.5
2	Бодлогын хэрэгжилт, судалгааны газар	Ц.Ганцэцэг	93.3
3	Санхүү бүртгэлийн газар	Б.Даваахүү	93.9
4	Сургалт олон нийт хамтын ажиллагааны газар	Д.Цэцэгбадам	90.0
5	Хяналт шалгалтын газар	Д.Ганзориг	89.0
6	Мэдээллийн технологийн төв	Г.Хүрэлбаатар	94.5
7	Дотоод аудит, мониторингийн газар	Б.Ганхуяг	92.5
8	Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс		91.8
Нийт дундаж үнэлгээ			92.2

Аймаг /нийслэл/, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс /газар/-ийн төсвийн шууд захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ;

Төсвийн төвлөрүүлэн захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-аас Төсвийн шууд захирагч нар /Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга/-тай 2023 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн болон жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээг хийв.

Төсвийн шууд захирагч нарын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилт, 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Тус гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний 2023 оны жилийн эцсийн биелэлтэд зохион байгуулалтын нэгжүүдээс өгсөн үнэлгээний дунджийг тус бүрээр нь харуулбал нийт дундаж үнэлгээ **88.1** хувьтай байна. Үүнд:

Хүснэгт-25

№	Нэгжийн нэр	Арга хэмжээний тоо	Үнэлгээ /дундаж оноо/
1.	Бодлогын хэрэгжилт судалгааны газар	6	93.9
2.	Санхүү бүртгэлийн газар	16	89.7
3.	Дотоод аудит, мониторингийн газар	2	82.7
4.	Хяналт шалгалтын газар	5	87.1
5.	Тамгын газар	7	86.9
6.	Сургалт, олон нийт, хамтын ажиллагааны газар	3	86.0
7.	Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс	4	90.6
8.	Мэдээллийн технологийн төв	4	89.1
Нийт оноо		47	88.2

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний дүнг дэлгэрэнгүйгээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ НАРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮНЭЛГЭЭ**

Хүснэгт-26

№	Газар, хэлтсийн нэр	БХСГ	СБГ	ДАМГ	ХШГ	ТГ	СОНХАГ	ЭХМТК	МТТ	Дундаж оноо
1	Архангай	90.5	92.2	80.0	82.6	85.1	93.0	87.5	93.0	88.0
2	Баян-Өлгий	93.2	91.6	81.0	86.6	85.8	75.3	87.5	90.3	86.4

3	Баянхонгор	94.0	86.5	78.8	86.6	84.5	73.3	86.3	89.3	84.9
4	Булган	90.3	84.1	62.3	86.0	85.0	76.3	85.0	86.0	81.9
5	Говь-Алтай	94.8	91.1	92.0	91.6	88.6	85.0	93.8	93.4	91.3
6	Говьсүмбэр	89.7	80.7	59.3	83.4	79.1	73.3	85.0	84.3	79.3
7	Дархан-Уул	95.0	92.0	95.0	90.0	91.0	98.0	94.0	93.4	93.6
8	Дорнод	97.2	90.9	94.3	90.4	89.6	82.0	92.5	87.7	90.6
9	Дорноговь	96.0	90.0	92.0	91.6	85.0	92.7	93.0	92.8	91.6
10	Дундговь	95.7	92.3	82.0	85.6	86.7	76.7	92.4	89.5	87.6
11	Завхан	96.0	89.0	83.0	82.6	85.0	78.7	91.3	95.0	87.6
12	Орхон	96.7	92.5	98.3	91.6	91.0	100	96.3	93.0	94.9
13	Өвөрхангай	94.0	91.5	88.5	85.0	88.3	98.7	93.8	93.8	91.7
14	Өмнөговь	95.5	90.3	44.3	90.0	85.0	81.7	88.0	90.0	83.1
15	Сүхбаатар	96.7	91.5	92.5	89.4	88.6	89.3	90.0	84.9	90.4
16	Сэлэнгэ	91.8	90.4	90.0	89.4	87.5	90.0	88.8	85.0	89.1
17	Төв	90.0	86.9	36.8	83.6	80.0	80.0	85.0	81.0	77.9
18	Увс	93.0	90.0	95.3	89.0	90.0	95.3	91.3	90.0	91.7
19	Ховд	94.5	89.0	90.0	89.4	86.3	86.0	93.8	91.7	90.1
20	Хэнтий	94.0	88.6	92.3	84.6	89.0	94.3	92.5	89.1	90.6
21	Хөвсгөл	90.3	91.6	96.5	82.6	87.9	85.0	95.0	82.0	88.9
22	Нийслэлийн Нийгмийн даатгалын газар	96.0	91.3	95.0	85.0	93.3	86.7		84.1	90.2
Дундаж үнэлгээ		93.9	89.7	82.7	87.1	86.9	86.0	90.6	89.1	88.2

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргаас аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нартай 2023 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн байдлаар биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний дүнг нэгтгэлээр харуулбал:

- 90-94.9 оноогоор үнэлэгдсэн 1 газар, 10 аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс;
- 81.9-88.0 оноогоор үнэлэгдсэн 9 аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс;
- 77.9-79.3 оноогоор үнэлэгдсэн 2 аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс байна.

Төсвийн шууд захирагч нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг эхний хагас жилийн байдлаар 85.8 хувиар, жилийн эцсийн байдлаар 88.2 хувь буюу Тодорхой үр дүнд хүрсэн гэж үнэлж үнэлгээний дүнг удирдлагад танилцуулав.

9.3. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ;

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ:

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр хэрэгжүүлэхээр 1 зорилт бүхий 1 арга хэмжээ тусгагдсан байна. Үүнд:

Зорилт 1.5. “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ажиллах хүч бэлтгэж, ажлын байрыг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, нийгмийн хамгааллыг зорилтот бүлэгт чиглүүлж, халамжаас хөдөлмөрт шилжих оновчтой бодлого хэрэгжүүлнэ” зорилтын хүрээнд:

- 1.5.5. Тэтгэврийн зөрүүг ойртуулах зорилгоор тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтоох /ЗГҮАХ-2.5.5/;

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 2023 оны эхний хагас жил, болон жилийн эцсийн байдлаар 100 хувиар үнэлж, үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 01/1218, 2024 оны 01/23 дугаар албан бичгээр Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад 2023 оны эхний хагас жилийн байдлаарх хэрэгжилтийн тайлан, холбогдох мэдээ, мэдээллийг үндэслэн Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийв.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд 5 зорилт бүхий 8 арга хэмжээ тусгагдсан байна. Үүнд:

- 2.5.1. “Нийгмийн даатгалын шинэчлэл хийж, иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, хувийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломж бүхий олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжинэ.” зорилтын хүрээнд 3 арга хэмжээ;
- 2.5.2. “Нийгмийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны үлдээдлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ” зорилтын хүрээнд 1 арга хэмжээ;
- 2.5.4. “Хөдөлмөрийн зах зээлийг орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчилж, бүтээмж, үр дүнд суурилсан цалин хөлс, ажлын үнэлгээний систем нэвтрүүлж, зайнаас болон цагаар ажиллах уян хатан зохицуулалт бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ” зорилтын хүрээнд 1 арга хэмжээ;
- 2.5.5. “Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ” зорилтын хүрээнд 2 арга хэмжээ;
- 2.5.6. “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, түргэн шуурхай, хүртээмжтэй болгоно” зорилтын хүрээнд 1 арга хэмжээ;

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 2023 оны эхний хагас жилийн байдлаар 92.5 хувиар, жилийн эцсийн байдлаар 92.2 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж, үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 01/1345, 2024 оны 01/23 дугаар албан бичгээр болон цахимаар Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.

Монгол улсыг (2021-2025 онд) хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ;

Монгол Улсын Их хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 2022 онд нийгмийн даатгалын чиглэлээр хэрэгжүүлэхээр 2 зорилт бүхий 4 арга хэмжээ тусгагдсан байна.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний дүнгээр:

- Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрсэн, тодорхой үр дүн гарсан 100 хувийн хэрэгжилттэй 3 арга хэмжээ;
- Зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч ажил хийгдэж буй 90 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ,

үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 2023 оны жилийн эцсийн байдлаар 97.5 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж, үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 01/23 дугаар албан бичгээр Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ:

Авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны ажлын төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийв.

Тус төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр 6 зорилтын 20 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг харуулбал:

- “Үр дүнтэй” зорилт арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан буюу 100 хувийн биелэлттэй 12 арга хэмжээ;
- “Тодорхой үр дүнд хүрсэн” зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай 70-99 хувийн биелэлттэй 4 арга хэмжээ;
- Үнэлэх боломжгүй 4 арга хэмжээ байна.

2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажил үүргийг зохих түвшинд биелүүлсэн тул төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны жилийн эцсийн байдлаар 96,7 хувь буюу “Бүрэн хангалттай” гэж үнэлж, танилцуулгыг Тамгын газарт хүргүүлэв.

Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ:

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад 2023 оны эхний 8 сарын байдлаар хэрэгжилтийн тайлан, холбогдох мэдээ, мэдээллийг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийв.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт 2023 онд нийгмийн даатгалын чиглэлээр хэрэгжүүлэхээр “Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ Нэгдүгээр үе шат /2021-2023/-ны хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа.” гэсэн зорилтын хүрээнд 1 зорилт бүхий 7 арга хэмжээ тусгагдсан байна. Үүнд:

- Албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэд, малчдыг нийгмийн даатгалд даатгуулах тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.;
- Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.;
- Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлж, төрийн болон хувийн тэтгэврийн сангаас тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлж, санхүүгийн зах зээлийг дэмжинэ.;
- Нийгмийн даатгалын мэдээллийн системийг боловсронгуй болгож, хяналтыг сайжруулна.;
- Нутгийн захиргааны байгууллагатай хамтран өрхийн болон хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг нийгмийн даатгалд заавал даатгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийнэ.;
- Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлно.;
- Тэтгэврийн даатгалын хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжүүлж, 1979 оноос хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг бодит хуримтлал болгоно.;

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 2023 оны эхний хагас жилийн байдлаар 95.0 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж, үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 01/1785 дугаар албан бичгээр болон цахимаар Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.

9.4. САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮР ДҮНТЭЙ БАЙЛГАХ ЧИГЛЭЛЭЭР БУСАД БАЙГУУЛЛАГУУДТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ:

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд мэдээллийн шинэчилсэн системийг турших, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан хөгжүүлэх төслийн хүрээнд салбарын хэмжээнд мэдээллийн шинэчилсэн системийг турших, нэвтрүүлэх, хүлээн авахад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлыг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулан ахлан ажиллаж, SICOS программыг нэвтрүүлэхээр IT Zone ХХК-тай хамтран ажиллаж байна.

Энэ ажлын хүрээнд ажлын хэсэг IT Zone ХХК -тай 15 удаа, дотооддоо 24 удаагийн уулзалтыг зохион байгуулав.

Дотооддоо зохион байгуулсан хуралдаанаар тэтгэвэр, тэтгэмж, нэрийн данс, ажил олгогчийн бүртгэл, харилцагчийн бүртгэл, цэргийн тэтгэврийн өөрчлөлт, нягтлан бодох бүртгэл, БНСУ дах албан журмын даатгал, сайн дурын даатгал, 0-3 нас хабрид эхийн бүртгэл, буцаан олголт зэрэг бүтээгдэхүүнд хуулийн дагуу тавигдах болзол нөхцөл, шалгах шалгуур үзүүлэлтээр нийгмийн даатгалаас иргэд даатгуулагчдад үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ тус бүрээр боловсруулж, бүх тохиолдлыг тестлэх ажлыг хэлэлцэн IT Zone ХХК-д хүргүүлсэн..

Мөн IT Zone ХХК-ийн удирдлагуудтай 15 удаагийн уулзалтыг зохион байгуулж, программ нэвтрүүлэлтийн төлөвлөгөө, үйлчилгээг тестлэх асуудлаар ярилцаж санал солилцсон байна.

Тус газраас ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал, хугацааны алданги, цаатан иргэдийн шимтгэл ногдуулалт, төлөлттэй холбоотой бүтээгдэхүүн үйлчилгээний бүх тохиолдлыг боловсруулж, тестлэхэд бэлэн болгож ажлын хэсэгт хүргүүлэв.

Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай” хуулийн хэрэгжилтийг хангах;

Үнэт цаас эзэмших эрхтэй тэтгэвэр авагчдаас 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш нас барж, үнэт цаасыг ар гэрийн хүнд нь өвлүүлэх 8,537 нас барсан иргэд байснаас 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 7,294 иргэний ар гэрт 6,834,2 сая төгрөгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв”-өөр дамжуулан олгоод байна Харин 1,243 нас барсан иргэдийн ар гэрт 982,7 сая төгрөг олгогдоогүй байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021, 2022 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн зарцуулалт, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтэд аудит хийх;

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайдын 2023 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/32 дугаар тушаалаар баталсан “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт улсын төсвөөс 2021, 2022 онд хүүхэд, хамгааллын хөтөлбөр, арга хэмжээнд зориулж баталсан хөрөнгийн зарцуулалт, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам”-ын хэрэгжилтэд шалгалт хийх удирдамжийн дагуу ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс 05 дугаар сарын 05-ны өдөр хүртэлх хугацаанд ажиллав.

Батлагдсан удирдамж, хөтөлбөрийн дагуу хяналт шалгалтыг хийж, аудитын тайлан, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналыг 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Ажлын хэсэгт хүргүүлэв.

Татварын албанд бүртгэлтэй боловч нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлээгүй, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын мэдээлэл зөрүүтэй ажил олгогчийн судалгааг гаргуулах, холбогдох хэлтсүүдэд хүргүүлэх;

Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор Татварын ерөнхий газартай хамтран ажиллах ажлын хүрээнд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого зөрүүтэй, болон нийгмийн даатгалд хамрагдаагүй аж ахуйн нэгжийн судалгааг 2 удаа ирүүлсэн.

Уг судалгаагаар 152.0 аж ахуйн нэгж байгаа бөгөөд уг жагсаалтыг БХСГазарт хүргүүлж ажиллав.

Нэр бүхий тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагын ажилчдад олгосон хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг шалгах, дүн мэдээг ажлын хэсэгт хүргүүлэх;

Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны хүсэлтийн дагуу Хяналт шалгалтын газар, Бодлогын хэрэгжилт, судалгааны газар, Дотоод аудит, мониторингийн газартай хамтарч тээврийн үйлчилгээ эрхэлдэг нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагын 2010 оноос 2022 оны хугацаанд ажилчдад олгосон хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг санхүүгийн үндсэн баримтад тулгуурлан шалгасан.

Энэхүү ажлын хүрээнд “Херосвин” ХХК-ийн цалин, хөлстэй холбоотой мэдээллийг шалгасан бөгөөд тус аж ахуйн нэгж байгууллага нь Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооноос баталсан “Салбаруудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ”-ээс доогуур цалин, хөлс олгосон зөрчил илэрсэн.

Илэрсэн зөрчлийн дүн мэдээг ажлын хэсэгт хүргүүлэв.

9.5. ТӨСӨВ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус газар нь эрхэлсэн ажлын хүрээнд 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ болон аудитыг хийж гүйцэтгэсэн ба 21 аймгийн холбогдох тайлан мэдээ, санхүүгийн баримтыг цахимаар авч т ажилласан.

Нийгмийн даатгалын байгууллагаас 2023 онд өндөр насны тэтгэвэрт гарах албан хаагчдын ажилласан жил болон 36 сар хүртэлх цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжид мониторинг хийх;

Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын ажилтнуудын 2024 онд өндөр настны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн тооцооллыг ажилтан, албан хаагчдын хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр, ажилд томилсон, чөлөөлсөн тушаал, холбогдох архивын лавлагаа, цалингийн тооцооны карт, нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд тулгуурлан төрийн албанд ажилласан хугацаа, дундаж цалинд үндэслэн хянав.

Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын хэмжээнд 2024 онд 36 ажилтан албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарах ба эдгээр ажилтан албан хаагчдад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж болох нийт 1,070.1 сая төгрөгийн тооцооллыг хийж Тамгын газар, Бодлогын хэрэгжилт судалгааны газарт 2023 оны 07 дугаар сард, 11 дүгээр сард, 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн цалин нэмэгдэхтэй холбогдуулан дээрх тооцоололд өөрчлөлтийг оруулж 36 албан хаагчийн 1,081.4 сая төгрөгийн тооцооллыг хийж Бодлогын хэрэгжилт, судалгааны газарт хүргүүлсэн.

Үндэсний аудитын газраас Нийгмийн даатгалын төв орон нутгийн байгууллагуудын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд мониторинг хийх

Үндэсний аудитын газраас нийгмийн даатгалын төв орон нутгийн байгууллагуудын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нэгтгэж, дүгнэлээ.

Аудитаар 6.58 сая төгрөгийн 12 акт, 176,755.5 сая төгрөгийн 50 албан шаардлага, 3,670.16 сая төгрөгийн 57 зөвлөмж ирүүлсэн ба актын биелэлт 77.1 хувь, албан шаардлагын биелэлт 3.69 хувь, зөвлөмжийн биелэлт 98.0 хувьтай байна.

Акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримтын хамт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2023 оны 01/1615 албан бичгээр болон цахимаар хүргүүлсэн ба Үндэсний Аудитын газрын www.fas.audit.mn цахим хуудас /Санхүүгийн тайлангийн аудитын систем, акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт бүртгэх/-д биелэлтийг нотлох баримтын хамт байршуулав.

Нийгмийн даатгалын сангуудын орлогын төвлөрүүлэлтэд мониторинг хийх;

Аймаг, дүүргийн хэлтсүүдийн Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, санд төвлөрүүлэлтийн байдалд дүн шинжилгээ хийв.

Төвлөрсөн харилцах дансанд байгаа шимтгэлийн орлогыг нийгмийн даатгалын сангуудад хуваарилж байгаа эсэх, сангуудын зарцуулагдаагүй үлдэгдэл (зардлаас давсан орлого)-ийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын төв сангуудын холбогдох харилцах дансанд төвлөрүүлж байгаа эсэх, сангуудын мөнгөн хөрөнгийг холбогдох сан болон төв санд заасан хугацаанд нь төвлөрүүлэхгүй байгаа шалтгааныг тодорхойлж, дүгнэлт гаргах, бодит байдлыг удирдлагад танилцуулах зорилгоор хийж гүйцэтгэсэн.

2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Нийгмийн даатгалын 5 төрлийн санд 383,599,16 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан бөгөөд үүнээс 36,168.43 сая төгрөг нь сумдын харилцахын үлдэгдэл бөгөөд үлдэгдлийг банк тус бүрээр харуулбал:

- Төрийн санд 4.60 хувь буюу 17,638.51 сая төгрөг;
- Хаан банканд 56.08 хувь буюу 217,428.42 сая төгрөг;
- Төрийн банканд 27.93 хувь буюу 107,132.60 сая төгрөг;
- Голомт банканд 4.04 хувь буюу 15,480.73 сая төгрөг;
- Худалдаа хөгжлийн банканд 3.95 хувь буюу 15,168.29 сая төгрөг;
- Капитран банканд 2.56 хувь буюу 9,801.62 сая төгрөг;
- Хас банканд 0.24 хувь буюу 934.19 сая төгрөг;

Нийгмийн даатгалын сангийн нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 41,439.0 сая төгрөг байна
Үүнээс:

- Зардлаас илүү авч үлдсэн мөнгөн хөрөнгө 19, 364.9 сая төгрөг;
- Төвлөрсөн харилцахын мөнгөн хөрөнгө 22,074.1 сая төгрөг;

Орлогын төвлөрсөн харилцах данс болон дараа сарын зарлагын мөнгөн хөрөнгийн нөөц хөрөнгийг хассанаас үлдсэн бусад сангийн дансны үлдэгдэл мөнгөн хөрөнгийг төвлөрүүлээгүй шалтгаан, гарч буй хүндрэл бэрхшээлүүдийг тодорхойлон дүгнэлтийн хамт удирдлагад танилцуулав.

Судалгааг хийх явцад сангийн харилцах дансны үлдэгдлийг сар бүрийн эцэст бүрэн хуваарилж тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн Санхүү бүртгэлийн тасгийн дарга болон орлогын нягтлан бодогч нарт зөвлөж ажиллав.

Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтэд мониторинг хийх;

1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Мэдээллийн ил тод, нээлттэй байдалд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг мэдээллийн хүртээмжтэй байдал, хугацаандаа нийтлэгдсэн байдал, мэдээллийн бүрэн бүтэн байдал, эх сурвалжийн байдал зэрэг шалгуур үзүүлэлтээр дараах мэдээллийн хүрээнд дүгнэв. Үүнд:

- Нэг чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт 9;
- Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод байдал, нээлттэй байдал 6;
- Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа 17;
- Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээлэл 1;
- Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал 2;

Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 91.4 хувиар “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэж, үнэлгээний дүнг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 01/831 дүгээр албан бичгээр болон цахимаар Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлэв.

2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй өгөгдлийн жагсаалт”, Засгийн газрын 2022 оны “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны А/40 дүгээр тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын веб сайт ажиллуулах журам”-ын хүрээнд Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудын www.ndaatgal.mn цахим хуудсанд нээлттэй мэдээллийг байршуулж буй байдалд дүн шинжилгээг үнэлгээг хийв.

Уг шинжилгээгээр мэдээлэл байршуулсан байдлыг дараах чиглэлийн хүрээнд үнэлж нэгтгэсэн.

Үүнд:

- *Хуулийн 8.2 дугаар зүйлд чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийг бүрэн байршуулсан эсэх;*
- *Хуулийн 8.3 дугаар зүйлд мэдээлэл хариуцагч өөрийн хүний нөөцийн талаарх мэдээллийг бүрэн байршуулсан эсэх;*
- *Хуулийн 8.4 дүгээр зүйлд мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг бүрэн байршуулсан эсэх;*
- *Хуулийн 8.5 дугаар зүйлд мэдээлэл хариуцагч хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний талаар мэдээллийг бүрэн байршуулсан эсэх;*
- *Хуулийн 8.6 дугаар зүйлд бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангасан эсэх;*

Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын заалтыг үндэслэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дугаар заалтаар байршуулсан мэдээлэлд хийсэн шинжилгээ, судалгааны үр дүнд Нийгмийн даатгалын ерөнхий газар 91.48% , Нийслэлийн нийгмийн даатгалын газар 72.92%, дүүргийн хэмжээнд 43.14%, аймгийн хэмжээнд 55.88% гүйцэтгэлтэйгээр нийтэлсэн байна.

Мэдээллийг салбарын хэмжээнд 53.95%-тай байршуулсан байгаа нь хангалтай үзүүлэлт биш юм.

Мөн 4 шалгуур үзүүлэлтээр шинжилгээ хийхэд Нийгмийн даатгалын ерөнхий газар 90.79% , Нийслэлийн нийгмийн даатгалын газар 76.05%, дүүргийн хэмжээнд 60.65%, аймгийн хэмжээнд 51.76% нь хэрэгжсэн байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг Нийгмийн даатгалын байгууллага 59.57%-тай хэрэгжүүлж байгаа нь хангалтгүй байна.

Хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд аймаг (нийслэл), дүүргийн хэмжээнд мэдээллийг хугацаа хоцроож байршуулах, мэдээлээгүй зэрэг зөрчлөөс гадна чиг үүрэг, бүтэц, шинээр хэрэгжиж байгаа хууль, засгийн газрын тогтоол, шийдвэр, тушаал, албан хаагчдын мэдээллийг хугацаанд нь байршуулсан харагдаж байгаа боловч доторх мэдээлэл хоосон, Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллийг шууд хуулбарлан байршуулсан зэрэг алдаа дутагдлууд илэрч байна.

Мөн дээрх алдаа дутагдал болон www.ndaatgal.mn вебсайт ажиллахгүй байгаа, утсан гэх шалтгаанаар ажил олгогч, даатгуулагч, иргэдийг мэдээллээр хангаагүй нь Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

9.6. ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС АЖЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022, 2023 оны эхний 6 сарын байдлаар санхүү үйл ажиллагаанд шалгалт хийх;

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Тамгын газар, Хяналт шалгалтын газартай хамтран Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын хүрээнд тус хэлтсийн 2022, 2023 оны эхний 6 хагас жилийн байдлаар санхүү үйл ажиллагаанд шалгалт хийв.

Тус шалгалтаар дараах зөрчил дутагдал илэрсэн байна. Үүнд:

- *2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар ХХОАТ-ын үлдэгдэл татварын цахим системтэй зөрсөн;*
- *Шатахууны зардалд гаргасан;*
- *И баримтын цахим системд дутуу болон илүү бүртгэгдсэн гүйлгээ;*
- *2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар Үндсэн хөрөнгийн тайланд үлдэх өртөггүй хөрөнгө тусгасан;*
- *Шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй 3 мэдээлэл;*
- *Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн;*
- *Зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн;*

Шалгалтын дүн мэдээг удирдлагад танилцуулсан ба Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Шалгалтын дүнгийн

тухай” А/112 дугаар тушаалаар илэрсэн зөрчлийг арилгах, хэрэгжилтийг хангаж ажиллах талаар үүрэг, даалгавар өгөгдөв.

Архангай аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах;

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газарт ирүүлсэн иргэний гомдлын мөрөөр уг гомдолд дурдсан асуудлыг бүх талаас нь судлан үзэж, илэрсэн зөрчил дутагдлын үндэслэлийг шалгаж тодруулах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Санхүү бүртгэлийн газар, Тамгын газартай хамтран Архангай аймгийн нийгмийн даатгалын хэлтэст ажиллав.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн баталсан удирдамжийн дагуу Архангай аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст Нийгмийн даатгалын тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг Хяналт шалгалтын газартай хамтран шалгав.

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргад танилцуулав.

Төлөвлөгөөт бус хяналт-шинжилгээ, үнэлгээ

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх журмын хэрэгжилтэд шинжилгээ хийх;

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/86 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дотоод аудитын журам”-ыг мөрдлөг болгон Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн тухай хуулийн 171 дүгээр зүйл, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, 26 дугаар зүйлийн 26.1.4 зүйл, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны “Журам батлах тухай” 10 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх журам”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний хорооны баталсан 2022 оны төлөвлөгөөг үндэслэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжилтэд дүн шинжилгээг хийв.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Тайлант хугацаанд 14 байгууллагад 32 арга хэмжээний зардалд нийт 1,186.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Дээрх 1,186.4 сая төгрөгийн санхүүжилтээс 84.2 сая төгрөгийн зардлын буцаалт хийхээс 64.2 сая төгрөгийн буцаалтыг хийж, 20.0 сая төгрөгийн зардлын тооцоог нийлж дүнг эцэслээгүй байна.

Санхүү бүртгэлийн газраас ирүүлсэн санхүүгийн анхан шатны баримт бичиг, холбогдох тайланг нягтлахад дараах нийтлэг дутагдал байна.Үүнд:

- *Нотлох баримтгүй;*
- *Урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний ажлын тайлан хангалтгүй, бодит үр дүнг тодорхойлох боломжгүй, үр дүнтэй эсэх нь тодорхойгүй;*
- *Төсвийн зарцуулалтын тайлан, үр дүнгийн тайланг хугацаанд нь ирүүлээгүй;*
- *Хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөгөөнд тусгагдсан хугацаанд нь хэрэгжүүлсэн эсэх нь тодорхой бус;*
- *Сургалт зохион байгуулах гэрчилгээ авсан нь тодорхой бус, гэрчилгээ байхгүй;*
- *Урд оны урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг үнэлсэн үнэлгээ хийгээгүй;*
- *Анхан шатны баримтын бүрдэл дутуу, арга хэмжээг зохион байгуулсан тухай ажлын тайлан ирүүлээгүй байгууллагуудад санхүүжилтийг олгосон;*
- *Анхан шатны баримтын бүрдэл дутуу зэрэг байна.*

Илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, санал дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж удирдлагад хүргүүлснээр, Хөдөлмөрийн аюулгүй байдал, үндэсний хорооны 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх;

Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйл, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын хуралдааны 2022 оны 55 дугаар тэмдэглэл, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 1/1306 дугаар зөвлөмжийн дагуу улсын нэгдсэн санд бүртгэлтэй Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 3 захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийн явцыг 100 хувь буюу холбогдох шийдвэр нь тавьсан зорилгодоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан “Бүрэн хэрэгжсэн” гэж үнэлсэн.

Үнэлгээний танилцуулга, хэрэгжилтийн тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 01/1013 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн 2023 оны “Мэдээ, тайлан ирүүлэх тухай” 04/2130 дугаар албан бичгийн дагуу Захиргааны хэм хэмжээний акт батлахаар тусгайлан эрх олгосон заалтын хэрэгжилт, баталсан захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн.

Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд мониторинг хийх;

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн Нийгмийн даатгалын газар, 21 аймаг, 9 дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тоон мэдээ, мэдээлэлд үндэслэн шийдвэрлэлтийн үйл ажиллагаанд 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр болон 3 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар мониторинг хийв.

Мониторинг хийх явцад Нийгмийн даатгалын байгууллагад ажил олгогч, даатгуулагч, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хэрхэн хүлээн авч бүртгэдэг талаарх судалгааг гаргасан ба уг судалгаагаар нийгмийн даатгалын байгууллагууд өргөдөл, гомдлыг 6 өөр байдлаар бүртгэж байна.

ABLE программ: 50 хувь 1 газар, 15 хэлтэс;

ERP программ: 28,1 хувь 1 газар, 8 хэлтэс;

Ексел: 3,1 хувь буюу 1 хэлтэс;

Бүртгэлийн дэвтэр: 12,5 хувь буюу 4 байгууллага;

Е Дос: 3,1 хувь буюу 1 хэлтэс;

И-оффис: 3,1 хувь буюу 1 хэлтэс;

Нийгмийн даатгалын байгууллагуудад 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 3 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд нийтдээ 3,329 өргөдөл, гомдол ирсэн байна. Үүнээс:

- *Өргөдөл, хүсэлт 3,265;*

- *Гомдол 64 бүртгэгдсэн байна.*

Нийгмийн даатгалын байгууллагад

- *Ажил олгогч 4;*

- *Иргэд 3,181;*

- *Албан хаагч 144 өргөдөл, гомдлыг ирүүлсэн байна.*

Ирүүлсэн өргөдөл, гомдлын дийлэнх нь:

- Эрүүл мэндийн даатгалын хураамж төлөлт, илүү төлсөн шимтгэлийн буцаалт залруулгатай холбоотой 1,052 өргөдөл байгаа бөгөөд нийт өргөдлийн 33.07 хувь;
- Сайн дурын даатгал, илүү төлсөн шимтгэлийн залруулгатай холбоотой 659 өргөдөл ба нийт өргөдлийн 20.72 хувь;
- Данс андуурч төлөгдсөн шимтгэлтэй холбоотой залруулга хийх тухай 180 өргөдөл ба 5.66 хувийг тус тус эзэлж байна.

Нийгмийн даатгалын байгууллагуудад ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 90.54 хувьтай ба хяналтад байгаа 262, хугацаа хэтэрсэн 53 өргөдөл, гомдол байна.

Мөн хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 30 өргөдөл гомдол байна. Энэ нь нийт өргөдөл гомдлын 0.9 хувийг эзэлж байна.

Өргөдөл гомдлыг шийдвэрлэх хоног дунджаар 9.38 хоног байна.

Илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, санал дүгнэлт гаргаж зөвлөмж боловсруулан Нийслэлийн Нийгмийн даатгалын газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд Дотоод аудит, мониторингийн газрын 2023 оны 03/878 дугаар албан бичгээр зөвлөмжийг хүргүүлэв.

Нийгмийн даатгалын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам"-ын дагуу мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох байцаагч, ажилтнуудын нэрсийн жагсаалтад мониторинг хийж, Тамгын газарт хүргүүлэх;

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны “Дүрэм батлах тухай” А/73 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын байцаагчийн мэргэшлийн зэргийг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журам”-д заасны дагуу Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагад ажиллаж байгаа байцаагчдын нэрсийн жагсаалтад 2023 оны 2 дугаар сарын 7-10-ны өдрүүдэд мониторинг хийсэн.

Мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох шалгуурыг хангасан байдлыг Нийгмийн даатгалын байцаагчаар ажилласан хугацааны нотлох баримт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээ, ёс зүйн зөрчил, сахилгын шийтгэлтэй эсэх зэрэг шалгуур үзүүлэлтийг холбогдох баримт бичигтэй тулган нягталж, Тамгын газарт хүргүүлэв.

Дээрх жагсаалтаар нийт 522 байцаагчийн нэрс ирүүлсэн ба дээрх нэрсийн жагсаалтад орхигдуулсан 12 байцаагч ажилтнууд байв.

Мөн Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагад ажиллаж буй мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох байцаагч, ажилтнуудын 2024 онд олгох зэргийн нэмэгдлийн тооцоолол хийв.

2024 онд 553 байцаагчид 1,219.7 сая төгрөгийн мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох тооцооллыг хийж Бодлогын хэрэгжилт судалгааны газарт тус тус хүргүүлэв.

Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх сэргээх, эрх баталгаажуулах шалгалтад орох байцаагч, ажилтнуудын нэрсийн жагсаалтад мониторинг хийж, ажлын хэсэгт хүргүүлэх;

Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, баталгаажуулах, сэргээх шалгалтыг 2023 оны 12 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулав.

Энэхүү ажлын хүрээнд улсын байцаагчийн шалгалтад орох нийт 286 ажилтнуудын нэрсийн жагсаалтыг баримт бичигтэй тулган нягталж, ажлын хэсэгт хүргүүлэв.

Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, авлагын мэдээнд мониторинг хийх;

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө биелүүлэх, шимтгэлийн авлага барагдуулах тухай” А/16 дугаар тушаалаар баталсан төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд аймаг, дүүргийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, авлагын мэдээнд дүн шинжилгээ хийв.

Энэхүү дүн шинжилгээг 2022 оны жилийн эцэс, 2023 оны 1, 2, 3 сар болон өмнөх оны мөн үетэй харьцуулж, дараах байдлаар нэгтгэн дүгнэсэн. Үүнд:

- *Нийгмийн даатгалын сангийн авлага, өглөгийн мэдээ;*
- *Нийгмийн даатгалын сангийн авлагын өсөлт, бууралт (байгууллагаар);*
- *Нийгмийн даатгалын сангийн авлагын өсөлт, бууралт (насжилтаар);*
- *Нийгмийн даатгалын сангийн өглөгийн мэдээ;*

Тус мониторингоор Нийгмийн даатгалын сангийн нийт авлага 2023 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар 376.1 тэрбум буюу оны эхний авлагаас 8.7 тэрбум /2.4 хувь/, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.9-22.4 хувиар өссөн, Нийгмийн даатгалын сангийн авлагын 95.9 хувь буюу 360.6 тэрбум төгрөгийг аж ахуйн нэгж байгууллагаас, 4.1 хувь буюу 15.5 тэрбум төгрөгийг төсөвт байгууллагын авлага эзэлж байгаа ба төсөвт байгууллагын авлага 5.9-8.0 хувиар өссөн, Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 2023 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн

байдлаар 24.0 тэрбум төгрөг байгаа ба 2022 оны жилийн эцсийн байдлаарх өглөгтэй харьцуулахад 72.3 хувь буюу 10.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Мониторингийн дүн мэдээг үндэслэн Нийгмийн даатгалын байгууллагын хэмжээнд өглөг, авлагыг бууруулах үе шаттай арга хэмжээ авч, ажил зохион байгуулахад анхаарах асуудлын талаар Дотоод аудит, мониторингийн газрын даргын “Зөвлөмж хүргүүлэх тухай” 2023 оны 03/896 дугаар албан бичгийг Нийслэлийн Нийгмийн даатгалын газар, аймаг дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүллээ.

Нийгмийн даатгалын хамралтын мэдээнд мониторинг хийх;

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө биелүүлэх, шимтгэлийн авлага барагдуулах тухай” А/16 дугаар тушаалаар баталсан төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд Санхүү бүртгэлийн газраас гаргаж ирүүлсэн аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хамралтын 2022 оны 12, 2023 оны 1, 2 дугаар сарын мэдээг үндэслэн шинжилгээ хийлээ.

Энэхүү дүн шинжилгээг 2023 оны 1, 2 сарыг өмнөх оны мөн үетэй харьцуулж, дараах байдлаар нэгтгэн дүгнэсэн. Үүнд:

- *Нийгмийн даатгалд хамрагдсан ажил олгогчийн тооны өсөлт, бууралт;*
- *Нийгмийн даатгалд хамрагдсан нийт даатгуулагчийн тооны өсөлт, бууралт;*
- *Нийгмийн даатгалд хамрагдсан албан журмын даатгуулагчийн тооны өсөлт, бууралт;*
- *Нийгмийн даатгалд хамрагдсан сайн дурын даатгуулагчийн тооны өсөлт, бууралт;*

Тус мониторингоор Нийт хамрагдсан даатгуулагчийн нийт тоог 2023 оны 1 ба 2 дугаар сарын хамралтыг 2022 оны мөн үетэй харьцуулахад 1 дүгээр сард 53,116 буюу 32.82 хувиар буурсан, 2 дугаар сард 24,043 буюу 2.90 хувиар өссөн, албан журмын даатгуулагчийн 2023 оны 1 ба 2 дугаар сарын хамралтыг 2022 оны мөн үетэй харьцуулахад 1 дүгээр сард 588732 буюу 50.89 хувиар буурсан, 2 дугаар сард 24,576 буюу 3.32 хувиар өссөн, сайн дурын даатгуулагчийн хувьд 2023 оны 1 ба 2 дугаар сарын хамралтыг 2022 оны мөн үетэй харьцуулахад 1 дүгээр сард 5,616 буюу 12.10 хувиар өссөн, 2 дугаар сард 533 буюу 0.61 хувиар буурсан байна.

Хамралтын мэдээнээс харахад 2023 оны 1 ба 2 дугаар сарын хамралтыг 2022 оны мөн үетэй харьцуулахад 1 дүгээр сард Архангай, Говь-Алтай, Хөвсгөл, Дархан-Уул аймаг, Налайх, Багахангай дүүргээс бусад аймгуудад 8.79-99.33 хувиар буурсан, 2 дугаар сард Баянхонгор, Булган, Дорнод, Орхон, Говьсүмбэр, Дундговь, Өвөрхангай аймгууд Багахангай, Налайх дүүргүүдэд 1.50-15.67 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мониторингийн дүн мэдээг удирдлагад танилцуулав.

9.7. ТООЦООЛОЛ, СУДАЛГАА, ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ НЭГТГЭХ, ХОЛБОГДОХ ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ;

Мэдээллийг нь зөрүүтэй бүртгэсэн байх магадлалтай нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох даатгуулагчдын мэдээллийг нягталж, зассан тайлбарыг шалгаж, нэгтгэх

“Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хууль”, Засгийн газрын 2022 оны “Журам батлах тухай” 230 дугаар тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/99 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад баримтлах журмыг хэрэгжүүлэх заавар”-ын хэрэгжилтийн хүрээнд Мэдээллийн технологийн төвөөс ирүүлсэн мэдээллийг нь зөрүүтэй бүртгэсэн байх магадлалтай 901 даатгуулагчийн жагсаалтыг нягтлуулахаар аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр хүргүүлэв.

Тус жагсаалтаар хүргүүлсэн даатгуулагчдын зөрүүтэй бүртгэсэн байх магадлалтай даатгуулагчдын мэдээллийг засварласан тухай тайлбарыг 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс 11-ний өдрүүдэд гаргуулан авч зарим даатгуулагчдын мэдээллийг Нийгмийн даатгалын мэдээллийн сангийн нэгдсэн санд тулгуурлан нэгтгэж, засав.

Мэдээллийг нь зөрүүтэй бүртгэсэн байх магадлалтай нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох 901 даатгуулагчийн дараах хэлтсүүд мэдээллийг нь засварлаагүй байна. Үүнд:

- Регистрийн дугаар нь УБЕГазрын баазад албан журмын даатгуулагч: Дорнод, Ховд аймгууд, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул дүүргүүд;
 - Нэг регистрийн дугаар дээр овог нэр зөрсөн даатгуулагч: Сэлэнгэ аймаг;
 - Регистрийн дугаар зөв боловч улсын бүртгэлийн баазтай зөрсөн: Сүхбаатар дүүрэг;
 - Төлөлтөөс хэтрүүлж, ногдуулалт хийсэн /Дутуу төлөлттэй/ сайн дурын даатгуулагч: Өвөрхангай аймаг;
 - Төлөлтөөс хэтрүүлж, ногдуулалт хийсэн сайн дурын даатгуулагч /hybrid /: Баянгол дүүрэг;
- Нэг сар дээр нэг даатгуулагчийн нэг удаагийн ногдуулалтыг 2 дахин бүртгэсэн: Сэлэнгэ, Дархан-Уул аймгууд;

Монгол улсын харьяатаас гарсан болон нас барсан байх магадлалтай иргэний нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаа эсэхийг нягтлан тооцоолол хийх;

Тагнуулын ерөнхий газрын мөрдөн шалгах газрын 2023 оны 16/384 дүгээр албан бичгийн дагуу Монгол улсын харьяатаас гарсан байх магадлалтай 10, нас барсан байх магадлалтай 24, нийт 34 иргэний нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаа эсэхийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан болон харьяа аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдтэй холбогдож нягтлан шалгаж тооцооллыг хүн тус бүрээр гаргав.

Дээрх жагсаалтаар ирсэн 34 иргэний тэтгэврийн илүү олголтын тооцооллыг хийхэд:

- Нас барсан байх магадлалтай 24 иргэнтэй холбоотой 133.4 сая төгрөг;
 - Харьяатаас гарсан байх магадлалтай 9 иргэнтэй холбоотой 117.5 сая төгрөг байна.
- Иргэдийн нэрсийн жагсаалтыг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлж, дахин нягталж шалгах зөвлөмжийг 2 удаа өгч ажилласан.*

Мөн дээрх тооцоолол, зөрчлийн барагдуулалт, хийгдсэн ажиллагааны талаарх тайлбарыг 2 удаа гаргуулж, удирдлагад 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр, 06 дугаар сарын 09-ний өдөр танилцуулав.

Төрийн албан хаагчийн буруутай үйлдлийн улмаас 2016-2023 онуудад ажлаас үндэслэлгүй халагдсан нь тогтоогдож, шүүхийн шийдвэрээр ажилд нь эгүүлэн томилсон ажилтнуудын судалгааг гарган холбогдох газар хүргүүлэх;

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан 2023 оны “Төрд учирсан хохирлыг барагдуулах ажил зохион байгуулах тухай” А/59 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын 2023 оны 12/1227 дугаар албан бичгийг ирүүлсэн.

Уг албан бичигт заасны дагуу төрийн албан хаагчийн буруутай үйлдлийн улмаас төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажлын хүрээнд Нийгмийн даатгалын салбарын 2016-2023 онуудад ажлаас үндэслэлгүй халагдсан нь тогтоогдож, шүүхийн шийдвэрээр ажилд нь эгүүлэн томилсон ажилтнуудын судалгааг гаргаж 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 01/1115 дугаар албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.

Дээрх ажлын хүрээнд 16 албан тушаалтантай холбоотой 77.2 сая төгрөгийг төлүүлэхээс 7 албан тушаалтантай холбоотой 28.1 сая төгрөгийг нөхөн төлүүлсэн бөгөөд 10 албан тушаалтантай холбоотой 49.1 сая төгрөгийг төлүүлэхээр ажиллаж байна.

Мөн Шүүхийн шийдвэрээр ажилдаа эгүүлэн томилогдсон ажилтан, албан хаагчтай холбоотой захиргааны хууль бус шийдвэр гаргасан 15 албан тушаалтнуудад төрд учирсан хохирлыг барагдуулж, байгууллагыг хохиролгүй болгох тухай албан бичгийг 2023 оны 07 дугаар сард 11 албан тушаалтнуудад хүргүүлсэн бөгөөд 4 албан тушаалтан дээрх төлбөрийг төлж эхэлсэн учир хүргүүлээгүй болно.

Төрд учирсан хохирлын нөхөн төлүүлэх талаар зохион байгуулсан ажлын тайланг гаргаж Дотоод аудит, мониторингийн газрын 2023 оны 03/2246 дугаар албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.

Сангийн яамнаас Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудад 2017-2019 онуудад хийгдсэн хяналт шалгалтаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нэгтгэх, хяналт тавих;

1. Сангийн Сайдын баталсан удирдамжийн дагуу Сангийн яамнаас Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудын 2021, 2022 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг 2023 оны 1 дүгээр улиралд хийв.

Тус шалгалтын хугацаанд Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагад 2017-2019 онуудад хийсэн санхүүгийн хяналт шалгалтаар өгөгдсөн 84,542.7 мянган төгрөгийн төлбөр тогтоосон 39 акт, 46,831.0 мянган төгрөгийн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг гаргуулж, биелэлтийг нэгтгэн Сангийн яамны хяналт шалгалтын ажлын хэсэгт 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр хүргүүлсэн.

Тус нэгтгэлээр акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт 63,2 хувьтай байна.

2. Сангийн Сайдын баталсан 2023 оны СХШХ/02 дугаар удирдамжийн дагуу Сангийн яамнаас Нийгмийн даатгалын ерөнхий газар, харьяа байгууллагуудын 2021, 2022 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг хийсэн.

Тус шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, шалгалтын дүн мэдээ, шалгалтаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай” А/133 дугаар тушаалаар Сангийн яамны Дотоод аудитын хорооны зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагад хүргүүлсэн бөгөөд биелэлтийг нэгтгэв.

Сангийн яамны Дотоод аудитын хорооны 2019 оны 14 дүгээр тогтоолоор өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг гаргаж, Сангийн яаманд хүргүүлэх;

Капитал банк ХХК дахь банкны эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн төлбөрийг төлүүлэх, Чингис хаан банкинд байршиж буй сангийн мөнгөн хөрөнгийг барагдуулахаар хэрэгжүүлж буй ажлын талаарх танилцуулгыг нэгтгэж, холбогдох нотлох баримт бичгийн хамт 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд цахимаар хүргүүлсэн ба жилийн эцсийн биелэлтийг Дотоод аудит, мониторингийн газрын 2023 оны 03/2289 дүгээр албан бичгээр Сангийн яамны Дотоод аудитын хороонд хүргүүлэв.

Капитал банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн төлбөрийг төлүүлхээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ:

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/96 дугаар тушаалаар Капитал банкныг албадан татан буулгах шийдвэр гарч, банкны эрх хүлээн авагч томилогдсоноос хойш хугацаанд Капитал банк ХХК дахь банкны эрх хүлээн авагч (цаашид КЭХА гэх)- аас төлбөр нэхэмжлэх, нэхэмжилсэн төлбөрийг төлүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний танилцуулгыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл (цаашид НДҮЗ гэх)-ийн хурлаар 12 удаа хэлэлцүүлж, 7 тогтоол батлагдаж, гарсан шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган ажиллав.

Капитал банк ХХК дахь банкны эрх хүлээн авагчаас 104.2 тэрбум төгрөг нэхэмжилсэн ба 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар 10.74 тэрбум төгрөг нь мөнгө хэлбэрээр, 25.06 тэрбум төгрөг нь хөрөнгө хүлээн авснаар нийт 35.7 тэрбум төгрөгийн авлага барагдаж, 68.4 тэрбум төгрөгийн үлдэгдэл байгаагаас ҮОМШӨ-ий даатгалын сангийн 62.0 тэрбум, ажилгүйдлийн даатгалын сангийн 6.4 тэрбум төгрөг байна.

Хөрөнгүүдийг 10 удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар болон Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагаар дамжуулан худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, нийт 8 519.37 сая төгрөгийн 34 ширхэг хөрөнгийг 8 715.27 сая төгрөгөөр борлуулан, төлбөрийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлэв.

Чингис хаан банкинд байршиж байгаа сангийн мөнгөн хөрөнгийг барагдуулахаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ:

Чингис хаан банк ХХК нь нэхэмжилсэн дүнгээс 2023 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар нийт 6.87 тэрбум төгрөг төлөгдөж, авлагын үлдэгдэл 94.91 тэрбум төгрөг байгаагаас ҮОМШӨ-ий даатгалын сангийн 89.0 тэрбум, ажилгүйдлийн даатгалын сангийн 1.39 тэрбум, тэтгэмжийн даатгалын сангийн 4.52 тэрбум төгрөг байна.

Архангай аймгийн Хайрхан сумын Нийгмийн даатгалын тасгийн барилгатай холбоотой хэрэгжүүлж байгаа арга хэмжээ:

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд түрээсэлсэн байгууллага /хувь хүн/ байхгүй болно.

Нийгмийн даатгалын байгууллагын ndaatgal.mn цахим хуудсаар олон нийтэд мэдээлэл нийтлэх ажлыг зохион байгуулах, мэдээлэл байршуулах;

1. Нийгмийн даатгалын салбарын нээлттэй мэдээллийг ил тод болгох, шилэн индексийн үнэлгээг нэмэгдүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 01/1132, мөн Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2023 оны “Судалгаа ирүүлэх тухай” 03/1180 дугаар албан бичгийг Нийслэлийн нийгмийн даатгалын газар, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлсэн.

2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоолоор баталсан Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл журам”, мөн оны 201 дүгээр тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Хуваарь, төлөвлөгөө батлах тухай” А/66 дугаар тушаалаар баталсан ажлын хэсэг байгуулж, “Нээлттэй мэдээллийг цахим хуудсанд байршуулах хуваарь”, “Нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу Алсын хараа-2050, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Монгол улсыг (2021-2025 онд) хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, Хууль тогтоомж шийдвэрийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, Дотоод аудит, мониторингийн газрын үйл ажиллагааны тайлан, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөний явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, шилэн дансны хөтлөлтийн тайлан зэрэг мэдээллийг цахим хуудсанд хугацаанд нь байршуулан ажиллаж байна.

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллах;

“Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн 2023 оны ажлын төлөвлөгөөг баталж, уг төлөвлөгөөнд нийт 9 ажил үйлчилгээг тусгасан ба хэрэгжилт 100 хувьтай байна.

Шаардлагатай журам боловсруулах үүргийн хүрээнд холбогдож журмыг шинэчлэн батлуулах;

Нийгмийн даатгалын багц хуулийг 2024 оноос эхлэн хэрэгжүүлэхтэй холбоотойгоор доорх журмыг шинэчлэн боловсруулж батлуулав.

- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Журам батлах тухай” А/194 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг авах эрх бүхий иргэн, албан тушаалтныг тодорхойлох журам;
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Журам батлах тухай” А/190 дүгээр тушаалын хавсралтаар баталсан Бүртгэлийн дугаар олгох, хэрэглэх болон хувийн хэрэг нээх, бүртгэх, хөтлөх, шилжүүлэх, журам, холбогдох маягтын загвар;

Тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулж, мэдээллийн сан үүсгэх ажлын дүн мэдээг нэгтгэх;

Нийгмийн даатгалын байгууллага цахим үйлчилгээнд шилжсэнтэй холбоотойгоор архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх, тэтгэврийн хувийн хэргийг цахим хэлбэрт шилжүүлэх, Нийгмийн даатгалын байгууллагын архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, хамгаалах, лавлагаа мэдээлэл шалгах, хяналт тавих, ашиглалтын хугацааг уртасгах, тэтгэвэр авагчдад өөрсдийн тэтгэвэр тогтоолттой холбоотой баримт бичигтэй танилцах, шаардлагатай бол хуулбарлан авах ажлыг шуурхай болгох зорилгоор мэдээллийн нэгдсэн сан үүсгэх ажил явагдаж байна.

Энэхүү ажлын хүрээнд тэтгэвэр авагчдын тэтгэврийг цахимаар шалгаж тогтоох, цахим хяналт шалгалтыг сайжруулах, даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг шуурхай үзүүлэх зорилгоор тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулах, мэдээллийн сан үүсгэх ажил хийгдэж байгаа бөгөөд ажлын явц, судалгааг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдээс гаргуулан авч нэгтгэв.

Судалгааны 2023 оны эхний 5 сарын байдлаар нэгтгэлээр нийт 485,4 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэрэг цахимжуулахаас 83,0 мянган тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулж, явц 17.1 хувийн биелэлттэй байна.

---oOo---

